"Инвескор ББСБ" ХК
Гүйцэтгэх захирал



**Ч.Хашчулуун**
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Монгол Улсын Их Сургуулийн
Эдийн Засгийн тэнхмийн
Профессор



**Р.Мөнхтөр**
ТУЗ-ийн гишүүн

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК
Дэд захирал



**Д.Энхбат**
ТУЗ-ийн хараат бус гишүүн

"Хархорум Дижитал" ХХК
Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал



**Н.Хирохито**
ТУЗ-ийн гишүүн

"Инвескор Жапан" ХХК
Гүйцэтгэх захирал



**Ч.Өнөржаргал**
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
Нягтлан бодох бүртгэлийн
тэнхимийн ахлах багш



**Г.Уянгахишиг**
ТУЗ-ийн гишүүн

"Инвескор Капитал ҮЦК" ХХК
Гүйцэтгэх захирал



**Т.Тэлмэн**
ТУЗ-ийн гишүүн

"Амар Даатгал" ХХК
Бизнес хөгжлийн газрын захирал

● Аудитын хороо ● Эрсдэлийн удирдлагын хороо ● Цалин урамшууллын хороо ● Нэр дэвшүүлэх хороо ♛ Тухайн хорооны дарга

ТУЗ-ийн дэргэд түүний гишүүдээс бүрдсэн Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын, Эрсдэлийн удирдлагын хороод байнгын үйл ажиллагаа явуулдаг. Хороод тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэй.

**Схем 2.** Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод

| ТУЗ-ийн дэргэдэх хороод | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аудитын хороо | Дарга: | Ч.Өнөржаргал | Гишүүд: | Ч.Хашчулуун, Р.Мөнхтөр |
| Нэр дэвшүүлэх хороо | Дарга: | Ч.Хашчулуун | Гишүүд: | Д.Энхбат, Х.Намики |
| Цалин урамшууллын хороо | Дарга: | Д.Энхбат | Гишүүд: | Т.Тэлмэн, Ч.Өнөржаргал |
| Эрсдэлийн удирдлагын хороо | Дарга: | Б.Анхболд | Гишүүд: | Д.Баясгалан, Г.Уянгахишиг |

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
6060854 ☏ 11192...
УЛААНБААТАР ХОТ

## 3.4. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд

**Схем 3.** Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид




### 3.4.1. Хувьцаа эзэмшигчдийн тухай

#### "Эс Ай Би Жэй Капитал" ХХК

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь бизнес, менежментийн зөвлөгөө өгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэдээлэл технологи, үл хөдлөх хөрөнгийн зуучлал, болон түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2016 онд байгуулагдсан.

### 3.4.2. Үнэт цаас гаргагчийн хараат болон охин компаниуд

**Схем 4.** Үнэт цаас гаргагчийн хараат болон охин компаниуд



Үнэт цаас гаргагч нь 5 охин компанитай бөгөөд эдгээрээс 4 компанийн 100 хувийн хувьцааг эзэмшдэг ба 1 компанийн 75 хувийг эзэмшдэг. Тодруулбал:

### "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК /100%/

"Инвескор хэтэвч ББСБ" ХХК нь 2019 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Покет гар утасны аппликэйшнээр дамжуулан барьцаагүй онлайн зээлийн бүтээгдэхүүнийг харилцагч нартаа хүргэж байна. Покет аппликэйшн нь цаг ямагт шинэчлэгдэж, зээл, санхүү, төлбөр тооцоо, худалдаа үйлчилгээний салбарын олон шинэлэг шийдлүүдийг агуулж, санхүү, төлбөр тооцооны бие даасан экосистем болж өргөжин тэлсээр байна.

### "Покет КГ" ХХК /100%/

"Покет КГ" ХХК нь 2020 онд Киргиз Улсад Покет гар утасны аппликэйшнээр дамжуулан барьцаагүй онлайн зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдадаа хүргэх зорилготойгоор байгуулагдсан. 2021 оны эцсээр 5 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

### "Инвескор Си Эй МФК" ХК /100%/

"Инвескор Си Эй МФК" ХК нь Киргиз Улсад ББСБ-ын үйл ажиллагаа явуулдаг. 2021 оны эцсийн байдлаар 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 832 харилцагчийн 6.8 тэрбум төгрөгийн зээлийн багцтай. Тус компани нь 5 гишүүний бүрэлдэхүүн бүхий ТУЗ, Удирдлагын хорооны бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

### "Инвескор Актив ТЗК" ХХК /75%/

Тус компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготойгоор үүсгэн байгуулагдсан тусгай зориулалтын компани юм. "Инвескор Актив ТЗК" ХХК-ийг "Инвескор ББСБ" ХК болон "Микро Кредит ББСБ" ХХК нь автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр үүсгэн байгуулсан. "Инвескор Актив ТЗК" ХХК нь хувьцаа эзэмшигч ББСБ-уудаас зээлийн багцыг худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр шилжүүлэн авч, 2021 онд 4 тэрбум төгрөгийн баталгаат ХБҮЦ-ийг МХБ дээр гарган амжилттай арилжаалсан болно. Тус компани нь 3 гишүүн бүхий ТУЗ-тэй ба хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг "Рэдбэррал Инвестмент энд Менежмент" ХХК үзүүлж байна.

### "Инвескор КЗ" ХХК /100%/

Үнэт цаас гаргагч нь Казахстан Улсад бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэвтрүүлж зах зээлээ тэлэх зорилгоор "Инвескор КЗ" ХХК-ийг 2022 оны 5 сард үүсгэн байгуулсан. Уг компаниар дамжуулан Казахстан Улсын зах зээлд уламжлалт зээлийн бүтээгдэхүүн болон финтек шийдэлд тулгуурласан дижитал зээлийн маркетплэйс платформ, цахим хэтэвчийн үйлчилгээг тус тус нэвтрүүлэхээр ажиллаж байна.

## 3.4.3. Үнэт цаас гаргагчийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн нэгдэл, зэргэлдээ компаниуд

### "Инвескор Лизинг" ХХК

"Инвескор Лизинг" ХХК нь үл хөдлөх хөрөнгө, автомашин, оффис болон тоног төхөөрөмжийн лизинг, хөрөнгө оруулалтын санхүүжилтын боломжийг гадаадад оршин суугаа Монгол иргэдэд олгодог. Энэхүү санхүүгийн түрээсийн үйлчилгээ хүрээнд "Инвескор Лизинг" ХХК нь Монгол улс, Япон улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) болон АНУ-д үйл ажиллагаа эрхэлж, Улаанбаатар хот дахь орон сууцны хотхон, хорооллыг барьж буй барилгын томоохон компаниудтай хамтран ажиллаж, таатай нөхцөлөөр орон сууц өмчлөх боломжийг олгох үйлчилгээг үзүүлж байна.

СЗХ 2022 .11.03 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21
"ИНВЕСКОР ББСБ" ХК InvesCore FINANCIAL INSTITUTION 6060854 1119286063 УЛААНБААТАР ХОТ

**"Инвескор Капитал ҮЦК" ХХК**

"Инвескор Капитал ҮЦК" ХХК нь 2018 онд байгуулагдсан андеррайтер, брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны компани юм. Тус компани нь МХБ, хөрөнгийн зах зээл дээр нээлттэй болон хаалттай хэлбэрээр үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгслүүд бүтэцжүүлэх, хөрөнгө оруулалт болон нэгдэн нийлэх үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлж ирсэн. Ингэхдээ зах зээлийн жишиг, тухайн компанийн онцлогт нийцсэн шийдлийг санал болгодог. 2019 онд "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцааг МХБ-ээр дамжуулан анх удаа нийтэд санал болгох (IPO) ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлж, 18.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн ба 2021 онд Монголын анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох Инвескор Актив ХБҮЦ гаргах, анхны хувийн хэвшлийн Бондын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг, эрэлттэй бүтээгдэхүүнүүдийг нийлүүлээд байна.

**"Финберри" ХХК**

2019 онд байгуулагдсан "Финберри" ХХК нь хөрөнгө оруулалтын зуучлалын чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгдөг бөгөөд краудфанд платформ юм. Краудфанд нь Монгол Улсад явагдаж байгаа төсөл хөтөлбөр, санхүүжилт зэрэгт олон нийтээс санхүүжилт татах бөгөөд энэ бүх уялдаа холбоог тухайн краудфанд платформоор шийдэх юм. Бүтээгдэхүүний урамшуулалт санхүүжилт, хандив, зээлийн үйлчилгээг хамруулснаараа онцлогтой.

**"Инвескор Проперти" ХХК**

"Инвескор Проперти" ХХК нь 2017 онд байгуулагдсан, үл хөдлөх хөрөнгийн зуучлал, менежментийн үйлчилгээг хотын А зэрэглэлийн бүсэд үзүүлдэг бөгөөд "Хоймор Оффис", "Амбассадор Резиденс" хотхоны менежментийг гүйцэтгэж байна. Тус компани нь энэхүү танилцуулга бэлтгэгдэх өдрийн байдлаар "Инвескор Тауер" үл хөдлөх хөрөнгийн төслийг хариуцан хөгжүүлж байгаа ба менежментийн үйлчилгээ үзүүлж буй үл хөдлөх эд хөрөнгүүдийн нийт үнэлгээ нь жил ирэх тусам өсөж 2021 оны байдлаар 81 тэрбум төгрөгт хүрээд байна.

**"Инвескор Жапан" ХХК**

"Инвескор Жапан" ХХК нь 2019 онд байгуулагдсан бөгөөд Япон Улсад санхүүгийн зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалт босгох үйл ажиллагаа явуулдаг. Олон улсын хөрөнгө оруулагч нарыг Монголд хөрөнгө оруулах, үнэт цаас худалдаж авах, хадгаламж байршуулах үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд Инвескор Санхүүгийн Группийн гишүүн компаниудтай синержи үүсгэн хамтарч ажилладаг ба тухайлбал "Инвескор Проперти" ХХК-ийн төслүүдэд хөрөнгө оруулах, "Инвескор ББСБ" ХК-д урт хугацааны итгэлцэл байршуулах зэргээр ажиллаж байна. Тус компани нь гадны хөрөнгө оруулалтыг, тэр дундаа Япон Улсын хөрөнгө оруулагчдыг татаж, Монгол Улсын бизнесийн салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

**"Эй Ай Лаб" ХХК**

"Эй Ай Лаб" ХХК нь 2018 онд байгуулагдсан бөгөөд систем хөгжүүлэлт, программ хангамж, аппликэйшн хөгжүүлэлт зэрэг мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг. 2018 онд Смарт-ЛОС систем болон хиймэл оюун ухаанд суурилсан Скоринг системийг зах зээлд нэвтрүүлсэн ба мөн Инвескор Санхүүгийн Группийн гишүүн компаниудын шаардлагатай систем, вэб болон аппликэйшн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэдэг.

**"Коло Тинкинг" ХХК**

Инвескор Санхүүгийн Группийн ажилтнууд нь санаачилга гаргаж, толгой компаниас санхүүжилт татах замаар 2020 онд "Коло Тинкинг" ХХК-ийг дизайн хөгжүүлэлт, маркетинг сурталчилгааны үйл ажиллагаа явуулахаар байгуулсан. Инвескор Санхүүгийн группийн компаниудад үйлчилгээ үзүүлэхээс гадна зах зээлд шинээр цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах гэж буй байгууллагуудад веб болон аппликэйшн дээрх UX/UI программ хөгжүүлэлтийг гүйцэтгэдэг бөгөөд дараах аппликэйшн, вэб, брэндбүүкийн ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн.

СЭХ
он сар өдөр
2022 11 09
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

3

### "Инвескор Ассет Менежмент ҮЦК" ХХК

"Инвескор Ассет Менежмент ҮЦК" ХХК нь 2021 онд үүсгэн байгуулагдсан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд юм. Тус компани нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлэх, түүнийг төлөөлөх үйл ажиллагааг эрхлэн явуулах юм.

### "Монголиа Талент Нэтворк" ХХК

2011 онд анх үүсгэн байгуулагдсан Монгол улсын тэргүүлэх зэрэглэлийн хүний нөөц зуучлал, менежментийн компани бөгөөд 2021 онд "Эс Ай Би Жэй Капитал" ХХК хөрөнгө оруулалт хийж, хувьцаа эзэмшигч болсон. 2021 онд хиймэл оюун ухааны тусламжтайгаар тохирох ажлын байрыг санал болгох, ажлын байрны хайлт хийх, ажил олгогч болон ажил горилогч нарыг холбох "Worki" аппликэйшнийг хөдөлмөрийн зах зээлд нэвтрүүлснээр олон мянган хүний цаг завыг хэмнэж, карьер хөгжилд нь дэмжлэг үзүүлж байна.

### "Ай Си Рэит" ХХК

Ай Си Рэит ХХК нь 2022 онд байгуулагдсан бөгөөд үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн менежмент юм. Хөрөнгө оруулалтын зорилготой үл хөдлөх хөрөнгүүдийг өмчилж, тэдгээрийн түрээсийн тогтмол орлого болон үнэ цэнийн өсөлтөөс хөрөнгө оруулагчиддаа өгөөж хүртээх байдлаар олон улсад хэрэгждэг REIT /Real Estate Investment Trust/ загвартай төстэй хэлбэрийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
6060854 ... 1119285063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 11 09
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн тухай

4.1. Монгол улсын эдийн засгийн төлөв байдал

4.2. Монгол улсын санхүүгийн зах зээлийн хөгжил

4.3. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын төлөв байдал

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
ФИНАНСИАЛ ИНСТИТЬЮШН
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
ХҮРГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21

# 4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн тухай



2021 оны 03 дугаар улиралд КОВИД-19 халдварын эсрэг вакцинжуулалт эрчимтэй үргэлжилж, хөл хорио суларч, олон улсын эдийн засаг сэргэж байсан боловч оны сүүлээр омикрон хувилбар дэгдсэнээр улс орнууд дахин хөл хорио тогтож эхэлсэн. Тодруулбал, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-д 12 дугаар сарын 14-ний өдөр омикрон хувилбарын анхны зөөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдсэн ба тохиолдол илэрсэн Тяньжин мужийн 10,000 иргэн хөл хорионд орж, үйлдвэрүүдийг түр зогсоож байсан. Вирусын шинэ хувилбарын дэгдэлт олон улсын нийлүүлэлтийн сүлжээний нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн ба эдийн засгийн идэвхжлийг сулруулах үндсэн шалтгаан болсон билээ.

Омикрон хувилбарын тархалттай холбоотойгоор олон улсын томоохон байгууллагууд, агентлагууд 2022 оны 01, 02 дугаар саруудад дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллүүдээ шинэчлэн 2022 онд дэлхийн эдийн засаг 4.2 хувиар, 2023 онд 3.5 хувиар өсөх төлөвтэй гэж таамагласан байна. Цар тахлын тархалт оны эхний улиралд өндөр хэвээр байх хэдий ч, улс орнуудын хөл хорио харьцангуй суларч, КОВИД-19 халдварын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө нь дельта хувилбараас бага байх, нийлүүлэлтийн доголдол багасаж, томоохон эдийн засгуудын өсөлт үргэлжлэх хүлээлттэй байна. Тухайлбал, АНУ, БНХАУ, Евро бүсийн эдийн засгууд 2022 онд урт хугацааны трендээс давж өсөх төлөвтэй гэж үзэж байгаа бол хөгжиж буй орнуудын хувьд 2022 онд КОВИД-19 халдварын эсрэг арга хэмжээ хангалттай хэмжээнд хүрч амжихгүй гэсэн хүлээлттэй байгаа тул цар тахлын сөрөг нөлөөг илүү хүндээр мэдрэхээр байна хэмээн эдийн засгийн шинжээчид үзэж байна.

**Хүснэгт 2.** Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентлагуудын 2022 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд, хувиар

| Эх сурвалжууд | Төсөөлөл хийгдсэн огноо | Дэлхийн эдийн засгийн өсөлт | БНХАУ-ын өсөлт | АНУ-ын өсөлт | Евро бүсийн өсөлт | ОХУ-ын өсөлт |
|---|---|---|---|---|---|---|
| Олон Улсын Валютын сан (ОУВС) | 2022/01/26 | 4.4% | 4.8% | 4.0% | 3.9% | 2.8% |
| Дэлхийн банк | 2022/01/12 | 4.1% | 5.1% | 3.7% | 4.2% | 2.4% |
| НҮБ | 2022/01/13 | 4.0% | 5.2% | 3.5% | 4.0% | 2.7% |
| Рубини | 2021/12/17 | 4.2% | 5.2% | 3.9% | 3.9% | 2.2% |
| Барклийс | 2022/02/04 | 4.2% | 4.7% | 3.7% | 4.1% | 2.6% |
| Коммерзбанк | 2022/02/04 | 4.5% | 4.5% | 3.8% | 3.5% | - |
| Фитч | 2022/02/07 | - | 4.8% | 3.7% | 3.9% | 2.6% |
| **Дундаж** | | **4.2%** | **4.9%** | **3.8%** | **3.9%** | **2.6%** |

**Эх сурвалж:** Олон улсын санхүүгийн байгууллагууд

## 4.1. Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

### 4.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

2020 онтой харьцуулахад Монгол улсын экспортын үндсэн түүхий эдүүдийн үнэ өсөж, түүнчлэн хувийн секторын хөрөнгө оруулалт, тэр дундаа уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр Монгол Улсын эдийн засаг 2021 оны эхний улиралд огцом сэргэсэн. Гэвч инфляцийн өсөлт, хил гаалийн хориг ба хязгаарлалтууд, импортын саатал, экспортын тоо хэмжээний бууралт зэргээс шалтгаалан эдийн засгийн өсөлт 02 дугаар улирлаас эхлэн саарсаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь 2021 оны 04 дугаар улирлын байдлаар өмнөх оноос 1.4% хувиар өссөн байдалтай байв.

**График 1.** Монгол Улсын бодит ДНБ-ий өсөлт, 2018 - 2021, 2022 - 2024 оны төсөөлөл, хувиар




Эх сурвалж: Дэлхийн банк

Дэлхийн банкны 2022 оны 4 сарын таамаглалаар Монгол Улсын эдийн засаг 2022 онд бага зэрэг сэргэж 2.5%, 2023 онд 5.8%, 2024 онд 6.8% хувийн өсөлтүүд үзүүлэх төлөвтэй байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 сар 10 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

### 4.1.2. Гадаад худалдаа

2021 оны гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25 хувиар буюу 3,225 сая ам.доллароор өсөж, 16,096 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд, нийт экспорт 22 хувиар буюу 1,671 сая ам.доллароор, импорт 29 хувиар буюу 1,555 сая ам.доллароор өссөн. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 116 сая ам.доллароор өсөж, 2,398 сая ам.долларын эерэг тэнцэлтэй гарлаа.

2022 онд Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам ашиглалтад орсноор төмөр замаар тээвэрлэх нүүрс, зэсийн экспортын хэмжээ нэмэгдэж, БНХАУ-ын далайн боомтуудаар дамжин гуравдагч орон руу тээвэрлэлт хийх боломжтой болно хэмээн төлөвлөж байна. Энэ нь Монгол Улсын гадаад худалдаа, цаашлаад эдийн засагт эерэг нөлөөг үзүүлэх төлөвтэй байна.

**График 2.** Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, 2019 – 2021, сая ам.доллар, улирлаар




**Эх сурвалж:** Монголбанк

### 4.1.3. Инфляци

2021 оны эцэст Монгол улсын инфляци 14.8%-д хүрсэн. Инфляцийн энэхүү огцом өсөлтөд шатахууны үнийн өсөлт, импортын бараа бүтээгдэхүүний саатал, тээвэрлэлтийн салбар дахь үнийн нэмэгдэл, хорио болон хүндрэлүүд нөлөө үзүүлсэн. Дотоодын хэрэглээг импортын барааны тасалдалтай урсгал хангаж чадахгүй байгаагаас барилгын материал болон бусад бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ хурдацтай өсөж байна.

**График 3.** Монгол Улсын инфляц, 2020 – 2021, хувиар, сар бүрээр



| | 2020/IX | 2020/X | 2020/XI | 2020/XII | 2021/I | 2021/II | 2021/III | 2021/IV | 2021/V | 2021/VI | 2021/VII | 2021/VIII | 2021/IX | 2021/X | 2021/XI | 2021/XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Жилийн эхнээс | 1.9 | 2.3 | 2.9 | 2.3 | 1 | 2.4 | 3.1 | 5.5 | 6.3 | 7 | 8.4 | 8.9 | 9.2 | 10.4 | 12 | 14.8 |
| Жилийн | 1.7 | 2.4 | 3.5 | 2.3 | 2.4 | 2.6 | 2.5 | 5.6 | 6.2 | 6.6 | 7.4 | 8.9 | 9.6 | 9.3 | 10 | 14.8 |
| Сарын | (0.3) | 0.4 | 0.6 | (0.6) | 1 | 1.4 | 0.6 | 2.4 | 0.7 | 0.7 | 1.3 | 0.4 | 0.3 | (0.02) | 1.5 | 2.6 |

**Эх сурвалж:** Монголбанк

### 4.1.4. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2020 онд жилийн дүнгээр 787 сая долларын эерэг үзүүлэлттэй гарсан. Үүнд Дэлхийн эдийн засаг, худалдааны түнш орнуудын эдийн засгийн сэргэлт нөлөөлжээ. Харин 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 225 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. 2021 оны эхэнд Монголбанкнаас төлбөрийн тэнцлийг тухайн жилийн эцэст ашигтай гарна гэж тооцоолж байсан боловч хил гаалийн хязгаарлалт, тээвэр логистикийн асуудалтай холбоотойгоор нүүрс болон үндсэн түүхий эдүүдийн экспорт зорилтот дүндээ хүрээгүй нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг өсгөхөд нөлөөлжээ.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 Улаанбаатар хот



4

**График 4.** Монгол Улсын төлбөрийн тэнцэл, 2020 – 2021, сая ам.доллар, сараар




**Эх сурвалж:** Монголбанк

### 4.1.5. Гадаад өр

2022 - 2023 онуудад урсгал дансны алдагдлаас гадна бондын эргэн төлөлтүүд хийгдэхээр хүлээгдэж байна. Тухайлбал: "Чингис" бондын 140 орчим сая ам.доллар, "Гэрэгэ" бондын 540 орчим сая ам.доллар, "Самурай" бондын 300 орчим сая ам.долларын төлбөрүүд 2022, 2023 онуудад эргэн төлөгдөх хуваарьтай байна. Эдгээр бондуудыг дахин санхүүжүүлэх ажлыг хурдавчлах шаардлагатай байгаа ба санхүүжилтын эрсдэл үүсэх тохиолдолд гадаад тэнцэл алдагдах болзошгүй гэдгийг Монголбанк анхааруулж байна.

**Хүснэгт 3.** Монгол Улсын үндсэн бондын санхүүжилтүүдын тухай мэдээлэл

| Үнэт цаас гаргагч | Бонд | Валют | Дуусах огноо | Үндсэн төлбөрийн үлдэгдэл | Купон хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын Засгийн Газар | Mongol 2024 (Хуралдай) | ам.доллар | 2024/03/09 | 600 сая | 8.75% |
| | Mongol 2023 (Гэрэгэ) | ам.доллар | 2023/01/05 | 800 сая | 5.63% |
| | Mongol 2026 (Номад) | ам.доллар | 2026/07/04 | 600 сая | 5.13% |
| | Mongol 2022 (Чингис) | ам.доллар | 2022/12/05 | 799 сая | 5.13% |
| | Mongol 2027 | ам.доллар | 2027/06/28 | 500 сая | 3.50% |
| | Mongol 2031 | ам.доллар | 2031/06/28 | 500 сая | 4.45% |
| Хөгжлийн Банк | DBM' 23 (Самурай) | япон иен | 2023/12/25 | 30 тэрбум | 1.52% |
| | DBM' 2023 | ам.доллар | 2023/10/23 | 500 сая | 7.25% |
| "МИК ОССК" ХХК | MGMTGE' 2022 (Өүлэн) | ам.доллар | 2022/01/29 | 300 сая | 9.75% |
| Монголиан Майнинг Корпорэйшн | MMC' 2024 | ам.доллар | 2024/04/15 | 440 сая | 9.25% |

**Эх сурвалж:** Монголбанк

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭЛ-02

СЗХ

### 4.1.6. Мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүү

Монголбанк 2020 оны 11 дүгээр сард бодлогын хүүг 8 хувиас 6 хувь хүртэл бууруулсан бол 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 9 хувьд хүргэсэн билээ.

**График 5.** Монголбанкны бодлогын хүү, 2007 - 2021, хувиар

Эх сурвалж: Монголбанк




Монголбанк бодлогын хүүг 2020 оны 11 дүгээр сард 6% болгон бууруулсантай холбоотойгоор Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс 15 хувиар өсч 27.9 их наяд төгрөгт хүрч байсан. M2 мөнгөний жилийн өсөлтийн 9.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 6.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.5 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.4 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, (2.8) нэгж хувийг гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлж байсан байна.

**График 6.** Мөнгөний нийлүүлэлт, 2020 – 2021, их наяд төгрөг, сараар




Эх сурвалж: Монголбанк

### 4.1.7. Гадаад валютын нөөц

2022 оны эхнээс гадаад валютын нөөц өсөлттэй байсан хэдий ч 06 дугаар сараас аажмаар буурсан. Үүнд экспортын орлого багассан нь нөлөөлсөн ба Монголбанк валютын ханшийг тогтвортой байлгахын тулд интервенц ихээр гүйцэтгэсэн нь нөлөөлсөн билээ.

**График 7.** Гадаад валютын албан нөөц, 2021 – 2021, сая ам.доллар, сараар




Эх сурвалж: Монголбанк

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ

### 4.1.8. Зээл болон хадгаламжийн хүү

2022 оны 01 дүгээр сарын байдлаар арилжааны банкнууд сарын зээлийн хүүгээ 1.3% хувиас 1.2% болгон бууруулсан байв. Мөн төгрөгийн хадгаламжийн хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.3 нэгж хувиар, валютын хадгаламж 0.2 нэгж хувиар тус тус буурсан. 2022 оны хувьд төгрөгийн ханш сулрах болон мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах бодлого хэрэгжих төлөвтэй тулд зээл болон хадгаламжийн хүү цаашид буурахгүй, эсрэгээрээ өсөх хандлагатай байна хэмээн эдийн засагчид үзэж байна.

**График 8.** Жигнэсэн дундаж хүү, 2020 – 2022, хувиар, сараар




**Эх сурвалж:** Монголбанк

### 4.1.9. Чанаргүй зээл

Санхүүгийн зах зээлийн чанаргүй зээлийн эзлэх хувь 2017 оноос хойш буурах хандлагатай байгаа бөгөөд 2021 оны байдлаар ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн хувь банкны салбарынхаас бага гарсан сайн үзүүлэлттэй байна.

**График 9.** Банк болон ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн эзлэх хувь, 2017 – 2021, хувиар




**Эх сурвалж:** Монголбанк, СЗХ

## 4.2. Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжил

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн нийт активын хэмжээ 27.9 их наяд төгрөгөөс 50.4 их наяд төгрөг болж 81 хувиар өсжээ. Уг өсөлтийн дийлэнхийг банкны салбар бүрдүүлж байгаа хэдий ч бусад салбарын хурдтай өсөлтийн улмаас банкны салбарын санхүүгийн зах зээлд эзлэх хувь жилээс жилд буурч байна. Тухайн жилүүдэд Үнэт цаасны болон ББСБ-ын салбарын нийт активын хэмжээ, санхүүгийн зах зээлд активаараа эзлэх хувь эрчимтэй нэмэгдсэн. Тухайлбал, Үнэт цаасны салбарын нийт актив 306 хувиар нэмэгдэж санхүүгийн зах зээлд активаараа эзлэх хувь нь 11.9% болсон бол ББСБ-ын салбарын активын хэмжээ 244 хувиар өсч санхүүгийн зах зээлд эзлэх хувь нь 5.4% болон нэмэгджээ.



ИНВЕСКОР ББСБ ХК
InvesCore
6060854 · 1119286063
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ

**Хүснэгт 4.** Санхүүгийн салбарын үзүүлэлтүүд, 2016 – 2021

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | Сүүлийн 5 жилийн өсөлт % |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НИЙТ АКТИВ, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР** | | | | | | | |
| **Санхүүгийн салбар** | 27,920 | 32,580 | 37,382 | 40,871 | 42,360 | 50,421 | **81%** |
| Банк | 25,338 | 28,773 | 33,053 | 35,859 | 36,685 | 41,012 | **62%** |
| Үнэт цаас | 1,474 | 2,440 | 2,512 | 2,693 | 3,030 | 5,983 | **306%** |
| Даатгал | 208 | 245 | 332 | 366 | 382 | 425 | **105%** |
| ББСБ | 787 | 969 | 1,285 | 1,730 | 2,007 | 2,710 | **244%** |
| Хадгаламж зээлийн хоршоо | 113 | 153 | 200 | 223 | 256 | 291 | **158%** |
| **САЛБАРЫН НИЙТ АКТИВЫН ХЭМЖЭЭ САНХҮҮГИЙН САЛБАРЫН НИЙТ АКТИВД ЭЗЛЭХ ХУВЬ** | | | | | | | **Өөрчлөлт** |
| Банк | 90.8% | 88.3% | 88.4% | 87.7% | 86.6% | 81.3% | **-9.4%** |
| Үнэт цаас | 5.3% | 7.5% | 6.7% | 6.6% | 7.2% | 11.9% | **6.6%** |
| Даатгал | 0.7% | 0.8% | 0.9% | 0.9% | 0.9% | 0.8% | **0.1%** |
| ББСБ | 2.8% | 3.0% | 3.4% | 4.2% | 4.7% | 5.4% | **2.6%** |
| Хадгаламж зээлийн хоршоо | 0.4% | 0.5% | 0.5% | 0.5% | 0.6% | 0.6% | **0.2%** |

**Эх сурвалж:** СЗХ-ны үйл ажиллагааны тайлан, 2021 он

Энэхүү зах зээлийн тэлэлтэд ББСБ-ууд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр илүү идэвхтэй ажиллаж, шинэ сегмент, шинэ төрлийн үйлчилгээ нэвтрүүлсэн нь ихээр нөлөөлсөн.

"Инвескор ББСБ" ХК-ийн хувьд түргэн шуурхай шийдвэр гаргалт, уян хатан нөхцөлөөр шинэ харилцагчид татах, харилцагчдаа халамжлах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй сайжруулж, санал болгон ажилладаг. Мөн ББСБ-ын салбарын өрсөлдөөн эрчимжиж, хүүгийн маржин буурах хандлагатай байгаа зах зээлийн орчинд гадаад шинэ зах зээл рүү тэлэхэд онцгой анхаарал хандуулан Киргиз Улсад өөрийн салбараа нээсэн. Цаашлаад Төв Азийн бусад орнуудад салбаруудаа нээхээр ажиллаж байна.

## 4.3. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын төлөв байдал

ББСБ-ын салбар нь Монгол Улсын санхүүгийн зах зээлдээ хамгийн өндөр өсөлт үзүүлж байгаа салбаруудын нэг юм. 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 534 ББСБ үйл ажиллагаагаа явуулж байгаагаас хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 83, гадаадын хөрөнгө оруулалттай 28, мөн олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

**Хүснэгт 5.** ББСБ-ын салбарын үзүүлэлтүүд, 2016 – 2021, тэрбум төгрөгөөр

| Үзүүлэлт | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР** | | | | | | | | | | | | |
| Нийт актив | 787 | 26% | 969 | 23% | 1,285 | 33% | 1,730 | 27% | 2,007 | 23% | 2,709 | 35% |
| Зээлийн багц | 436 | 22% | 582 | 33% | 870 | 49% | 1,169 | 34% | 1,327 | 16% | 2,012 | 52% |
| Өөрийн хөрөнгө | 579 | 36% | 758 | 31% | 977 | 29% | 1,203 | 23% | 1,450 | 21% | 1,799 | 24% |
| ББСБ тоо | 208 | 15% | 534 | 3% | 539 | 1% | 539 | 0% | 532 | -1% | 534 | 0.4% |
| Харилцагчийн тоо /мян./ | 592 | -7% | 1,471 | 148% | 1,601 | 9% | 2,330 | 46% | 2,639 | 13% | 4,820 | 83% |

**Эх сурвалж:** СЗХ-ны үйл ажиллагааны тайлан, 2021 он

ББСБ-ын салбарын нийт актив сүүлийн 5 жилийн хугацаанд 3.4 дахин өсч 2.7 их наяд төгрөг, зээлийн багцын хэмжээ 4.6 дахин өсч 2 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө 3 дахин өсч 1.8 их наяд төгрөг болтлоо өссөн ба ББСБ-аар үйлчлүүлдэг харилцагчийн тоо давтагдсан тоогоор 8 дахин өсч 4.8 сая хүрсэн амжилтуудыг үзүүлсэн.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119266053
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02



### 4.3.1. Актив

Салбарын уг амжилтыг түүчээлж буй ББСБ бол "Инвескор ББСБ" ХК юм. Тодруулбал, сүүлийн 5 жилийн хугацаанд нийт ББСБ-ын салбарын нийт актив 244 хувийн өсөлтийг үзүүлсэн бол Үнэт цаас гаргагчийн нийт актив 4,563 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

**График 10.** ББСБ-ын салбарын болон Үнэт цаас гаргагчийн нийт активийн мэдээлэл, 2016 – 2021, тэрбум төгрөгөөр




**Эх сурвалж:** СЗХ-ны үйл ажиллагааны тайлан, 2021 он

### 4.3.2. Зээлийн багц

Монголбанкны хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого, арилжааны банкнуудын зээл олголтын процесс нь харьцангуй удаан бөгөөд зээлдэгчдэд тавигдах шаардлага ба нөхцөл, бүрдүүлэх материалуудын шаардлага нь өндөр байдаг зэрэг шалтгаануудаас үүдэн харилцагчид ББСБ-ыг түлхүү сонгож байна.

Үнэт цаас гаргагчийн хувьд зах зээлийн энэхүү орчинд хурдтай хөгжлийг авчирч, эрэлт хэрэгцээнд суурилсан чанартай бүтээгдэхүүн нийлүүлснээр үүсэн байгуулагдсан цагаасаа хойш зээлийн багцаа 3,985 хувиар өсгөж, 173 тэрбум төгрөгт хүргэсэн амжилттай байна.

**График 11.** ББСБ-ын салбарын болон Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын мэдээлэл, 2016 – 2021, тэрбум төгрөгөөр




**Эх сурвалж:** СЗХ-ны үйл ажиллагааны тайлан, 2021 он

### 4.3.3. Зээлийн чанар

ББСБ-ын салбарын хувьд зээлийн багц их хэмжээгээр нэмэгдэхийн зэрэгцээ чанаргүй зээлийн үзүүлэлт буурч байгаа нь зах зээл чанартай өсөлт үзүүлж байгааг илтгэж байна. Тодруулбал, 2016 онд салбарын чанаргүй зээлийн эзлэх хувь 12.4% байсан бол 2021 оны эцсийн байдлаар 7% болтлоо буурсан байна. Үүнд ББСБ-ууд харилцагчдынхаа санхүүгийн боловсролд анхаарч, илүү сахилга баттай харилцагчид болгоход хичээл зүтгэн ажиллаж байгаа нь нөлөөлжээ.

Үнэт цаас гаргагч нь бусад ББСБ-ын жишгээр харилцагчдынхаа санхүүгийн боловсролд анхаарахаас гадна хиймэл оюун ухаанд суурилсан Скорингийн системээр зээлийн судалгаагаа хийдэг. Энэ нь зээлийн шийдвэр гаргалтад зээл судалж буй ажилтны хувийн үзэмж, сонирхлын зөрчил нөлөөлөхөөс сэргийлэх давуу талтай. Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанаргүй зээлийн эзлэх хувь салбарын дунджаас тогтмол 5-7 нэгж хувиар бага байсаар байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 Д.1119286063
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 21
БҮРТГЭВ-02

СЗХ
2022 сар 11 . 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**График 12.** ББСБ-ын салбарын болон Үнэт цаас гаргагчийн зээлийн чанарын мэдээлэл, 2016 – 2021, хувиар




### 4.3.4. Өөрийн хөрөнгө

ББСБ-ын салбарын өөрийн хөрөнгө 2016 - 2021 хугацаанд 211 хувиар өсч, 1.8 их наяд төгрөгт хүрсэн бол Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө тус хугацаанд 3,048 хувиар өсч 76 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү өөрийн хөрөнгийн хурдацтай өсөлт нь салбарын өсөлтөөс хурдан байгаа нь ашигт ажиллагаагаа хурдтайгаар нэмэгдүүлж, хөрөнгөө илүү үр ашигтай удирдаж байгаагаар тайлбарлаж болно.

**График 13.** ББСБ-ын салбарын болон Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн мэдээлэл, 2016 – 2021, тэрбум төгрөгөөр




### 4.3.5. Ашигт ажиллагаа

ББСБ-ын салбарын ашигт ажиллагаа жилээс жилд нэмэгдэж, сүүлийн 5 жилийн хугацаанд 229 хувиар өсч, нийт салбарын цэвэр ашиг 210 тэрбум төгрөгт хүрсэн. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг энэ хугацаанд салбарын өсөлтөөс хурдтай байж, 2021 онд 19 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, салбарын нийт ашгийн 9 хувийг дангаараа бүрдүүлэх болсон байна.

**График 14.** ББСБ-ын салбарын болон Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн мэдээлэл, 2019 – 2021, тэрбум төгрөгөөр




"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

Монгол улсын санхүүгийн зах зээл жилээс жилд өсөн нэмэгдэж, тэр дундаа ББСБ-ын салбар илүү хурдацтай өсч санхүүгийн зах зээлд эзлэх хувиа бусад салбараас илүүтэйгээр нэмэгдүүлж байна. Үүнд ББСБ-ууд санхүүгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн хурдацтайгаар нэвтрүүлж, харилцагчдын эрэлт хэрэгцээнд суурилсан үйлчилгээ үзүүлж, финтек болон цахим шилжилтийг дэмжин амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа нь нөлөөлсөн.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21

ИНВЕСКОР
БОНД 2.

# 5. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа

5.1. Ерөнхий мэдээлэл

5.2. Үнэт цаас гаргагчийн зээлийн бүтээгдэхүүн

5.3. Зээл олгох процесс, зээлийн бодлого

5.4. Финтект суурилсан зээлийн үйлчилгээ

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore

# 5. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа

## 5.1. Ерөнхий мэдээлэл

"Инвескор ББСБ" ХК нь анх 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдөр үүсгэн байгуулагдаж СЗХ-ны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 тоот тогтоолоор "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлөө авсан бөгөөд өнгөрсөн хугацаанд хурдацтай өсөж, салбартаа шинэлэг шуурхай үйлчилгээ болон дэвшилтэд технологийг нэвтрүүлж харилцагчдынхаа санхүүгийн хариуцлагатай дэмжигч байх зорилго тавин ажилласаар салбартаа манлайлагч нь болж чаджээ.

Үнэт цаас гаргагч нь уламжлалт банк бус санхүүгийн зах зээл болон финтек буюу технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хослуулан үйл ажиллагаа явуулдаг онцлогтой бөгөөд одоогоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 6 төрлийн үйлчилгээ үзүүлж, төв оффисоос гадна Улаанбаатар хотод байрлах нийт 14, Эрдэнэт хотод 1, Киргиз улсын Бишкек хотод нийт 3 салбартайгаар, мөн мэргэжлийн өндөр ур чадвар бүхий нийт 268 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

"Инвескор ББСБ" ХК нь финтек бүтээгдэхүүнийг ирээдүйн хөгжлийн нэг тулгуур бүтээгдэхүүн хэмээн онцгойлон үзэж ирсэн ба урт хугацаандаа өрсөлдөөний давуу тал бүрдүүлэхийн тулд өөрийн мэдээлэл технологийн багийг үүсгэж, өөрийн финтек бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх зорилго тавин "Эй Ай Лаб" ХХК-ийг үүсгэн байгуулсан түүхтэй. Тус компанийн Монгол инженерүүдийн ур ухаан, шинэлэг шийдлээр бүтээгдсэн "Покет" аппликэйшнийг Үнэт цаас гаргагчийн 100% охин компани болох "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК нь 2020 оны 01 дүгээр сард зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. 2021 оны эцсийн байдлаар уг аппликэйшн нь зах зээлд хэдийнээ танигдан 1 сая гаруй татан авалт хийгдсэн, 350 мянга гаруй харилцагч бүртгүүлсэн, өдөр тутмын санхүүгийн хэрэгцээгээ хангаан идэвхтэй ашиглаж буй 95 мянга гаруй харилцагчтай финтек бүтээгдэхүүн болон өргөжин тэлжээ.

Үүнээс гадна үнэт цаас гаргагч нь салбартаа анхдагч болж, иргэд, аж ахуйн нэгжүүдэд шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх, үргэлж шинийг санаачлагч байгууллага байсаар байх зорилгынхоо хүрээнд бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зориулж эрэлт хэрэгцээнд нийцсэн бага хүүтэй валютын зээл, зээлийн шугам, гүүрэн зээл, хамтын санхүүжилт, кредит карт зэрэг зээлийн үйлчилгээг уламжлалт банк бус санхүүгийн зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна.

2021 онд чанаргүй зээлийн хувийг 2.7 дээр барин ажиллаж өмнөх оноос 0.3 хувиар бага үзүүлэлттэй байв. Үнэт цаас гаргагчийн чанаргүй зээлийн үзүүлэлт нь салбарын дундажтай харьцуулахад 2.6 дахин бага байна. Чанаргүй зээлийн эзлэх хувийг сүүлийн гурван жилд 3 хувиас доош барьж ажиллаж байгаа нь Үнэт цаас гаргагчийн зээлийн скоринг системийн хөгжүүлэлт ба харилцагчдын санхүүгийн чадамжийг оновчтой тооцоолж, зээл чанаргүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байгаатай холбоотой. Түүнчлэн, эрсдэлийн удирдлагын бодлого, механизмыг болон зээл олгох процессыг тасралтгүй сайжруулдаг нь зээлийн чанарыг өндөр байлгахад нөлөөлдөг. Цаашид богино болон дунд хугацаанд чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээг +/- 1 хувийн хэлбэлзэлтэй түвшинд хадгалах зорилттой байна.

**График 15.** Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн багцад хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн эзлэх хувь, 2016 – 2021, хувиар



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 21
БҮРТГЭВ-02





**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ /ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ/**

- Зээл олгох
- Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх
- Факторингийн үйлчилгээ үзүүлэх
- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
- Төлбөрийн баталгаа гаргах

**МОНГОЛ УЛС ДАХЬ САЛБАРУУД /НИЙТ 16/**

- Төв салбар
- Зуун айл салбар
- Да хүрээ салбар
- Авто цогцолбор салбар
- Нарантуул салбар
- 10-р хороолол салбар
- Дүнжингарав салбар
- Авто экспо салбар
- Хан-Уул салбар
- Энхтайван салбар
- Тэнгис салбар
- Баянзүрх салбар
- Шангри-Ла салбар
- Их Монгол салбар
- Яармаг салбар
- Эрдэнэт салбар

**АЖИЛТАНЫ ТОО** • 268

**БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ**

**1. ААН, БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЗЭЭЛ**

- Эргэлтийн хөрөнгийн зээл
- Хөрөнгө оруулалтын зээл
- Жижиг, дунд бизнесийн зээл
- Бизнесийн зээлийн шугам
- Төлбөрийн баталгаа
- Факторинг
- Дугааргүй авто машин барьцаалсан зээл

**2. ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ЗЭЭЛ**

- Цалингийн зээл
- Шуурхай зээл
- Автомашин худалдан авах зээл
- Итгэлцэл барьцаалсан зээл

**3. КРЕДИТ КАРТ**

- Инвескор хар кредит карт
- Инвескор цагаан кредит карт

**4. ФИНТЕК БҮТЭЭГДЭХҮҮН**

- Богино хугацаат санхүүгийн хэрэгцээг хангах зорилго бүхий покет зээл
- Хүү шимтгэлгүй хуваан төлөх нөхцөл бүхий Покет Зеро зээл /Buy Now Pay Later/

**ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА АШИГЛАЖ БУЙ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ**

- Төрийн мэдээллийн ХУР систем
- Өөрсдийн хөгжүүлсэн зээлийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан Смарт-ЛОС систем
- Хэрэглэгчийн үйлчилгээний менежмент (CRM), процессын болон хүний нөөцийн менежментийн автоматжуулалтын (Business automation) нэгдсэн платформ болох BITRIX24
- Хиймэл оюун ухаанд суурилсан кредит онооны систем
- Өөрсдийн хөгжүүлсэн зээлийн Покет аппликэйшн

**НЭВТРҮҮЛЭХЭЭР ЗОРЬЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ**

- Покет аппликэйшнд суурилсан урт хугацаат зээлийн бүтээгдэхүүн
- Зах зээлд амжилттай нэвтрүүлж, туршигдсан бүтээгдэхүүнийг Төв Азийн зах зээлд нийлүүлэх

**ЗОРИЛТОТ ХАРИЛЦАГЧИД**

- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид, иргэд
- Төв Ази буюу Киргиз, Казахстанд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид, иргэд

## 5.2. Үнэт цаас гаргагчийн зээлийн бүтээгдэхүүн

Үнэт цаас гаргагч нь уламжлалт болон финтект суурилсан төгрөг болон валютын (ам.доллар, япон иен) зээлийн үйлчилгээг зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлөөр харилцагч нартаа санал болгон ажиллаж байна.



"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 21
БҮРТГЭВ-02

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

**График 16.** Үнэт цаас гаргагчийн зээлийн багц болон харилцагчийн мэдээлэл, 2016 - 2021




2021 онд 2 салбар шинээр байгуулж тухайн онд нийт 15 салбараар дамжуулан 79,908 харилцагчдад үйлчилгээ үзүүлсэн байна. 2021 оны эцэст Үнэт цаас гаргагчийн зээлийн багц 173 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 82 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан ба 2016 оноос хойших зээлийн багцын нийлмэл өсөлт 110 хувьтай байна.

Үнэт цаас гаргагч нь 2020 онд ББСБ-ын зах зээлийн 7.2 хувийг эзэлж байсан бол 2021 онд зах зээлд эзлэх хувиа 1.6 хувиар нэмэгдүүлж, 8.6 хувийг эзэлж чадсан байна. IPO гаргах үед буюу 2019 онд дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг боловсруулж байхад зээлийн багцаа 2021 онд 146.3 тэрбум төгрөгт хүргэнэ гэж ажиллаж байсан бол төлөвлөгөөгөө 18 хувиар давуулан биелүүлж, амжилттай ажилласан байна. Төлөвлөгөөгөө давуулан биелүүлэхэд шуурхай үйлчилгээ, харилцагчдын эргэх холбоо, зах зээлд тохирсон зээлийн бүтээгдэхүүн тухай бүр санал болгож байсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн билээ.

"Инвескор ББСБ" ХК-ийн нийт зээлийн багцын дийлэнх буюу 41 хувийг бизнесийн зээл, үлдсэн хувийг автомашины, хэрэглээний, мөн Финтек зээл эзэлж байна. Нийт зээлийн бүтээгдэхүүний 81% нь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөөр баталгаажсан ба нийт барьцаа хөрөнгийн үнэлгээ 300 тэрбум төгрөг байна.

Зээлийн бүтээгдэхүүний дунд хугацааны төлөвлөгөөгөөр Үнэт цаас гаргагч нь бизнесийн зээлийг нэмэгдүүлж нийт багцын 50 хувьд хүргэж, түлхүү жижиг дунд бизнес эрхэлсэн харилцагчдад чиглэсэн шинэ бүтээгдэхүүн, хөтөлбөрийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хэрэглээний болон автомашины зээлийн бүтээгдэхүүнүүд олгох процессыг илүү автоматжуулах төлөвлөгөөтэй байна.

**График 17.** Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын бүрэлдэхүүн, бүтээгдэхүүний төрөл болон төрөл бүрийн нийт багцад эзлэх хувиар, 2021

| Бизнесийн зээл | Автомашины зээл | Финтек зээл | Хэрэглээний зээл |
|---|---|---|---|
| 41% | 29% | 20% | 9% |

## 5.3. Зээл олгох процесс, зээлийн бодлого

"Инвескор ББСБ" ХК нь зээлийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, эрсдэлийн удирдлагаа оновчтой хэрэгжүүлэх, тогтмол хяналт тавих бодлого хэрэгжүүлдэг. Зээл олгох тогтолцоо нь зээлийн хэмжээ, бүтээгдэхүүний онцлогоос хамааран өөр байдаг бөгөөд нийт 6 хүртэлх процессын үе шаттай байдаг. Зээл олголтын процессын хүрээнд удирдлагуудын эрх хэмжээг эрсдэлийн тооцоололд үндэслэн олгосноор үйлчилгээг түргэн шуурхай хугацаанд харилцагчдадаа хүргэж байна.

Үнэт цаас гаргагч нь зээлийн бодлогоороо дамжуулан зээлийн үйлчилгээг харилцагчдад хүргэхдээ хүндрэл чирэгдэл багатай, илүү уян хатан бөгөөд харилцагч төвтэй байхыг эрхэмлэдэг. Дотооддоо хөгжүүлсэн скоринг систем ашиглан зээлийн хэмжээг тогтоож үйлчилгээ үзүүлэх нь харилцагчдыг өрийн дарамтад оруулахаас сэргийлэх, нөгөө талдаа компанийн тасралтгүй үйл ажиллагааг дэмждэг. "Инвескор ББСБ" ХК нь харилцагчдын шаардлага хэрэгцээнд нийцэхүйц түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ... 1119286063
УЛААНБААТАР ХОТ

Финтекийн шийдэл, технологийг суурь болгон ашигладаг. Жишээлбэл, хэрэглээний зээлийг нэг өдрийн дотор, шуурхай зээлийг 30 минутын дотор олгож, том бизнесийн зээлийг ажлын 3-5 хоногийн дотор шийдвэрлэхийг зорин ажилладаг. Үнэт цаас гаргагч нь жижиг дунд бизнес эрхлэгчид, бизнесийн байгууллагуудад чанартай үйлчилгээ үзүүлэхийг зорьж ажиллах орчин, системийн шийдлийг бий болгосон ба дан зээлийн үйлчилгээ үзүүлэхээс гадна харилцагчдадаа 36 цагийн үнэгүй зөвлөгөө өгөх үйлчилгээг нэмэлтээр санал болгодог. Финтект суурилсан зээлийн үйлчилгээ нь гар аргаар хийх процессыг 80 хувь хүртэл бууруулснаар харилцагчийг илүү таньж мэдэх, оновчтой шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлж өгч байгаа юм.

### 5.3.1. LOS - Loan Origination System - Смарт-ЛОС

Арилжааны банкнуудын гүйлгээний системтэй холбогдсон Смарт-ЛОС нь зээлийн судалгаа, шийдвэр гаргалт, олголт, явцын хяналт, хаалт гэсэн үндсэн 5 үйл явцыг бүрэн автоматжуулсан зээлийн үйл ажиллагааны дотоод систем юм. Уг системээр дамжуулан харилцагчийн 22 төрлийн лавлагааны мэдээллийг албан ёсны эх сурвалжуудаас авч, зээлийн судалгаа шинжилгээ гүйцэтгэхэд ашигладаг. Энэхүү систем нь гар ажиллагаанаас хамааралтай алдааг 80 хувиар бууруулахын зэрэгцээ харилцагчдын мэдээллийн нууцлалыг өндөр түвшинд хамгаалах, харилцагчдад түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжийг олгодгоороо давуу талтай.

Скоринг систем нь хиймэл оюун ухаанд үндэслэн харилцагчийн санхүүгийн мэдээлэл болон бусад баталгаажсан мэдээллүүд дээр үндэслэн тооцоолол хийдэг давуу талтай. Харилцагчийн зээлийн мэдээлэл буюу давхар зээлүүдийн эргэн төлөгдөх дүнг тооцож, зохистой зээлжих эрхийг олгодог. Түүнчлэн, скоринг систем нь харилцагчийн эргэн төлөлт хийх чадварыг тооцоолж судалснаар харилцагчийг өрийн дарамтаас хамгаалах бөгөөд боломжит зээлийн хэмжээг мэдээлснээр харилцагчид өөрийн санхүүгийн чадамжаа мэдэх боломжтой болдог.

Ийнхүү зээлийн шийдвэр гаргалтад хүнээс хамаарал бүхий процессуудыг цөөн болгосон нь банк бус санхүүгийн салбарын уламжлалт зээлийн үйл ажиллагааг дараагийн шатанд хүргэсэн үйл явдал билээ.

"Инвескор ББСБ" ХК нь дээрх системүүдийг зээлийн үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж, зээл олгох үйл ажиллагааг оновчтой зохион байгуулсны үр дүнд 2021 оны эцсийн байдлаар нийт зээлийн чанаргүй багцын хувийг 2.7 хувь хүртэл бууруулж чадсан нь ББСБ-ын салбартай харьцуулахад 4.3 нэгж хувиар бага үзүүлэлт байна.

**График 18.** Үнэт цаас гаргагчийн чанаргүй зээлийн хувийг ББСБ-ын салбарынхтай харьцуулах нь, 2021 оны эцсийн байдлаар, хувиар

**Чанаргүй зээлийн хувь**




Эх сурвалж: СЗХ-ны үйл ажиллагааны тайлан, 2021 он

### 5.3.2. CBS - Core Banking System

CBS буюу Core Banking System нь Смарт-ЛОС системтэй холбогдон ББСБ-ын үндсэн үйл ажиллагааг түргэн шуурхай гүйцэтгэдэг. CBS системийг нэвтрүүлснээр Үнэт цаас гаргагч нь нэгдсэн нэг платформоос харилцагчийн бүх мэдээллийг хянах, зээлийн хүү болон итгэлцлийн өгөөжийг урьдчилан тооцоолох, зээл болон итгэлцлийн гэрээний загварыг системээс бэлтгэх, эргэн төлөлтийн гүйлгээг ухаалгаар таньж гүйлгээг автоматаар хийх, мэдээллийн санг ашиглан дүн шинжилгээ хийж дашбоард гаргах боломжтой болсон. Харилцагчдын хувьд гар утаснаасаа зээлийн дэлгэрэнгүй мэдээллээ хянах, төлбөр тооцоогоо хийх, онлайнаар зээл авах, итгэлцэл байршуулах хүсэлт илгээх, итгэлцлийн дүнгээ нэмж байршуулах зэрэг олон төрлийн үйлдэл, функцийг ашиглах боломж нээгдсэн.

CBS систем нь дараах давуу талуудтай. Үүнд:

#### Тусгайлан хөгжүүлэх боломж буюу customization

Системд зээлийн болон санхүүгийн тайлантай холбоотой хөгжүүлэлтүүдийг гүйцэтгэж болдог ба хөрөнгийн зах зээлд гаргасан нээлттэй ХБҮЦ-тай холбоотой бүх төрлийн тайланг CBS систем дээр шийдвэрлэсэн нь гар ажиллагааг бууруулах, тайланг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх боломжийг олгосон билээ. Түүнчлэн, шинэ хууль, журам өөрчлөгдөхтэй холбоотойгоор бүх төрлийн өөрчлөлтүүдийг дотооддоо түргэн шуурхай нэвтрүүлэх боломжтой болдог.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21

### Эрхийн зохицуулалт, хяналт

CBS системийг дан ганц дотоод хэрэгцээндээ ашиглахаас гадна бусад санхүүгийн байгууллага болон олон улсын салбар компаниудад зориулан эрхийн зохицуулалт хийх, хяналтын орчин бүрдүүлэх боломжтой. Түүнчлэн, системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарчмаа хадгалахаас гадна систем дээр ачаалал үүсэх аюулаас хамгаалах тогтолцоотой.

### Аналитик дашбоард

Гүйцэтгэх удирдлага болон зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар нэгжүүд нь өөрсдийн шаардлагатай мэдээлэл болон үйлдлүүдээ бодит хугацаанд хүлээн авч хяналт тавих боломжтой бөгөөд дашбоард дахь мэдээлэл дагуу төлөвлөгөө гаргах, ажил гүйцэтгэх бүрэн боломжтой.

### Гуравдагч системийн интеграци

CBS систем нь гуравдагч ERP (Enterprise Resource Planning) системүүдтэй интеграци хийгдсэн. Нэмэлт шаардлагатай системүүдийг холбох бүрэн боломжтой. CBS системээс мэдээлэл цуглуулж Tableau/Power BI хэрэгсэл ашиглан дүн шинжилгээг хийн график дүрслэлээр харуулах боломжтой бөгөөд байгууллагын удирдлагуудад цаг алдалгүй тус тайлан мэдээллийг хүлээн авч өдөр тутмынхаа шийдвэр гаргалтад ашиглах боломжийг олгож байна.

### Аюулгүй байдлын архитектор

Уг систем нь доорх хэсгүүдийг хамаарсан аюулгүй байдлын цогц хамгаалалтыг агуулсан:

- ✓ Хандалтын аюулгүй байдал;
- ✓ Сүлжээний аюулгүй байдал;
- ✓ Хэрэглээний аюулгүй байдал;
- ✓ Хост хамгаалалт;
- ✓ Мобайл хамгаалалт;
- ✓ Gateway хамгаалалт;
- ✓ Аюулгүй байдлын менежмент.

### Мобайл аппликэйшн

Харилцагчид гар утаснаасаа зээлийн дэлгэрэнгүй мэдээллийг хянах, төлбөр тооцоогоо хийх, итгэлцлийн дүнгээ нэмж байршуулах, онлайнаар зээл авах болон итгэлцэл байршуулах хүсэлтийг илгээх боломжтой.

Арилжааны банкнууд үндсэн үйл ажиллагаандаа ашигладаг CBS, зээл олголтын үйл ажиллагаандаа ашигладаг Смарт-ЛОС системүүдийг банк бус санхүүгийн салбарт нэвтрүүлэн ашиглаж буй анхны ББСБ нь "Инвескор ББСБ" ХК юм.

**Схем 5.** Смарт-ЛОС болон CBS системүүдийн диаграм, процесс зураглал




Системийг хурдан хугацаанд сайжруулах боломжийг дотооддоо бий болгосноор зээлийн үйл ажиллагааг хяналттай, эрсдэл суурьтай, процессын дараалалтай гүйцэтгэх нь "Инвескор ББСБ" ХК-ийн өсөлтийн чухал хүчин зүйл. Чанаргүй зээлийн хувийг санхүүгийн салбартаа хамгийн бага байлгаж байгаа нь скоринг системийн оновчтой тооцоолол, систем бүртгэлийн автоматжуулалт, мэргэжлийн хамт олны хүчин зүйлээс бүрдэж байна.

СЗХ
2022 сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

## 5.4. Финтект суурилсан зээлийн үйлчилгээ

### 5.4.1. Pocket – Покет Цахим хэтэвч, цахим зээлийн үйлчилгээ

Покет аппликэйшн нь Монголбанкны "Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл", Хорооны "Зээлийн үйл ажиллагаа", "Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах", "Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ" үзүүлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр 2020 оны 01 дүгээр сараас цахим зээл болон цахим төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлж байна.

2021 оны байдлаар 162 тэрбум төгрөгийн дүн бүхий 1 сая зээл олгож, зээлийн багцыг 34 тэрбум төгрөгт хүргэсэн нь өмнөх оноос 3.4 дахин өссөн үзүүлэлттэй байгаа юм. Түүнчлэн 2021 оны байдлаар аппликэйшн татан авалтын тоо 1,000,000-д хүрч, 95,000 гэрээт хэрэглэгч, 400,000 цахим хэтэвчийн бүртгэлтэй хэрэглэгчтэй болсон бөгөөд судалгааны байгууллагын дүгнэлтээр зах зээлд цахим зээлийн аппликейшн төрөлд "Тэргүүлэх брэнд" байр суурьтай болсон байна.

Мөн 2021 онд Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооны "Шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй ББСБ", "Шилдэг санхүүгийн хүртээмжтэй ББСБ" хос Алтан-Од шагналын эзэн болсон.

#### 5.4.1.1. Покет апплкэйшний бүтээгдэхүүний үйлчилгээний танилцуулга

Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг тогтмол нэмэгдүүлэн ажилладаг.

**1. Цахим зээлийн төв**

2021 оны 11 дүгээр сард системийн шинэчлэл хийж, Покет аппликэйшн нь нэгдсэн платформ байдлаар ажиллахаар "Цахим зээлийн төв" болсон. Ингэснээр зөвхөн өөрийн санхүүжилтээр зээл олгох бус Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагууд болон хэрэглэгчдийг холбосон платформ болох зорилгын хүрээнд шинэ хөгжүүлэлтийг хийсэн нь бусад банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад Покет аппликэйшнээр дамжуулан өөрсдийн зээлийн бүтээгдэхүүнээ санал болгох боломжийг нээж байна.

Уг Цахим зээлийн төвийг ашигласнаар санхүүгийн байгууллага бүр өөрсдийн финтект суурилсан хөгжүүлэлт шинээр хийх шаардлагагүй хөрөнгө мөнгө болон хүн цагаа хэмнэх давуу тал үүсэж байна. Түүнчлэн харилцагчдад таниулах хугацааг хэмнэж 250 мянга гаруй харилцагчийн багцтай Цахим зээлийн төвд элссэнээр санхүүгийн бүтээгдэхүүнээ шууд борлуулах боломжтой. Нөгөө талаас хэрэглэгч ч мөн адил олон санхүүгийн байгууллагын үүд хаалга таталгүйгээр нэг аппликейшн дотроос сонголтоо хийн зээлийн үйлчилгээгээ авах боломжтой болсон гэсэн үг юм.

Тогтмол маркетингийн ажил Цахим зээлийн төвөөс хийгдэх бөгөөд нэгдсэн санхүүгийн байгууллагуудын борлуулалтын зардалд хэмнэлт хийгдэх юм. Түүнчлэн, гишүүн байгууллагууд нь өөрсдийн бүтээгдэхүүнээ харилцагчдаа татах өөрсдийн нөхцөлүүдийг оруулж болох ба зах зээлд өрсөлдөх эрх чөлөөг нь хязгаарлахгүй юм.

Санхүүгийн байгууллагуудад дундын платформоор дамжуулж хэрэглэгчдэд төгс зохицсон санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх боломжийг энэхүү Цахим зээлийн төв нь бүрдүүлнэ.

**Зураг 1.** Цахим зээлийн төв




Цахим зээлийн платформ нь одоогийн байдлаар дараах төрлийн зээлийн бүтээгдэхүүнтэй:

**Хэрэглээний зээл**




10,000,000 төгрөг хүртэлх зээлийг 14 - 60 хоногийн хугацаанд барьцаагүй авах цахим зээлийн үйлчилгээ олгож байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

**Батлан даалттай зээл**
Гэр бүл, найз нөхдийн хүрээнд шаардлагатай тохиолдолд тодорхой шалгуур хангаж байвал нэгнийгээ батлан дааж, хэрэглээний зээлийн эрхээ нэмэгдүүлэн ашиглах боломжтой.

**Автомашин барьцаалсан зээл**
Цахим зээлийн төвд нэгдсэн санхүүгийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор автомашин барьцаалсан зээлийн хүсэлтийг дамжуулдаг.

**Урт хугацаатай зээл**
30,000,000 төгрөг хүртэлх зээлийг 12 сарын хугацаатай барьцаагүй олгох цахим зээлийн үйлчилгээ нэвтрүүлэхээр ажиллаж байна.

**Оюутан зээл**
Зөвхөн оюутнуудад зориулсан 500,000 төгрөг хүртэлх барьцаагүй цахим зээлийн үйлчилгээ

**Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл**
Цахим зээлийн төвд нэгдсэн санхүүгийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хүсэлтийг дамжуулдаг.

5

### 2. Pocket Zero – Покет Зеро – Дараа төлбөрт худалдан авалтын үйлчилгээ

pocket ZERO

Покет Зеро нь Buy now pay later (BNPL) буюу дараа төлбөрт худалдан авалтын үйлчилгээ бөгөөд урьдчилгаа төлбөр, шимтгэлгүйгээр хүссэн бараагаа худалдан аваад 30 – 90 хоногийн хугацаанд хуваан төлөх боломжтой.

400 орчим брэнд, байгууллагыг мерчантаар элсүүлсэн бөгөөд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай, албан ёсны эрхтэй байгууллагуудыг элсүүлж, мерчантын тоог 1,000-д хүргэх зорилготой ажиллаж байна.

2021 онд хамтрагч байгууллагуудынхаа борлуулалтыг дэмжих зорилгоор Зеро Экспо /Zero Expo/-г зохион байгуулсан бөгөөд 20,000 орчим хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулж, борлуулсан.




**Зураг 2.** Зеро Экспо, 2021 он

### 3. Цахим төлбөр тооцоо




Цахим төлбөр тооцооны шинэлэг шийдэл, түргэн шуурхай үйлчилгээг lifestyle байдлаар хэрэглэгчдэд санал болгодог. Үүнд:




**Покет купон**
Покет купон үйлчилгээ нь мерчантуудад өөрсдийн үйлчилгээ, бараагаа бага өртгөөр сурталчлан таниулах боломж олгодгоороо онцлогтой. Өнөө үед жижиг, том мерчантууд харгалзалгүй купон ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ таниулах нь маркетингийн чухал суваг болж байна. Ингэснээр аппликейшн хэрэглэгч нар нь 50-70%-иар хямд үнээр худалдан авалт хийх, шинэ бүтээгдэхүүн болон үйлчилгээ тухай мэддэг болох ба мерчант нь покет аппликейшний хэрэглэгчдийн өргөн бааз ашиглан хямд өртгөөр борлуулалтаа нэмэгдүүлэх боломжтой болдог.




**Дугтуй**
Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдээр найз нөхөд, гэр бүлдээ бэлэн бус хэлбэрээр мөнгийг мэндчилгээ хамт илгээх боломж илгээх боломжтой үйлчилгээ бөгөөд "дугтуй" үйлчилгээг ашиглан цар тахлын үед "цахим золголт" хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 200,000+ "дугтуй" илгээгдэж, зайнаас золгох боломжийг олгосон нь хэрэглэгчдийн таашаалд ихэд нийцсэн.

InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02




Зураг 3. Покет аппликэйшний цахим золголт




ЗУРАГ 4. Покет аппликейшний хуваалцъя үйлчилгээ

Төлбөр төлөх процессыг хялбарчлах, зугаатай болгох үүднээс нэвтрүүлсэн энэхүү үйлчилгээг ашиглан аппликэйшн хэрэглэгчид нь нэг төлбөрийг тэнцүү, хувиар тооцон эсвэл санамсаргүй /азаа үзэх/ байдлаар хуваан төлөх боломжтой. Энэ үйлчилгээг хоол, худалдан авалт, уулзалт цуглаан, арга хэмжээ, хандив, баяр тэмдэглэлт өдрүүд зэргээр ашиглах нь төлбөр төлөх, нэхэмжлэх процессыг хурдан бөгөөд хялбар болгодог. Найзууд хамт хооллоод төлбөрөө хэрхэн хуваахыг аппликэйшнээрээ шодох байдлаар шийддэг нь залуусын сонирхолд ихэд нийцдэг.

## 4. Бусад

### Хэрэглэгчийн loyalty зэрэглэл

Покет аппликэйшнийг өдөр тутамдаа ашигладаг хэрэглэгчдэд бонус оноо цуглуулан loyalty зэрэглэлээ ахиулах боломжийг олгодог бөгөөд зэрэглэл ахих тусам зээлийн эрх нь нэмэгдэж, шимтгэлийн хэмжээ буурах нөхцөлтэй байдаг.

### Олимп

2021 онд Токио-2020 Олимпын наадмын шууд дамжуулалтын алтан ивээн тэтгэгчээр ажилласан бөгөөд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн хөгжүүлэлтүүдийг Покет аппликэйшнд тогтмол хийж хэрэгжүүлсэн нь аппликэйшн хэрэглэгч олимп сонирхогчдыг тогтмол мэдээллээр хангах, Монгол улсын тамирчдаа дэмжих, хөгжөөнт үйлчилгээнд хамрагдах боломжуудаар хангасан. Олимпын наадмын үеэр дараах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн:

- ✓ Олимпын талаарх мэдээ мэдээллийг цаг алдалгүй аппликейшнээр дамжуулан авах;
- ✓ Дэмждэг тамирчиндаа хандив өгөх;
- ✓ Олимпын үеэр сонирхолтой таавруud таана бэлэг хожих;
- ✓ Монголын баг тамирчдын медалийн тоог тааж автомашины эзэн болох.

Зураг 5. Покет аппликэйшний Токио-2020 Олимпын наадмын үеэр нэвтрүүлсэн нэмэлт цэс



*"Монгол Улсын шигшээ багийн тамирчид Токио 2020 зуны Олимпоос ямар медалиудын эзэн болох вэ?" гэсэн асуултад медалийн өнгөнүүдийн тоог сонголтоор оруулж баталгаажуулна.*

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ... 11...
УЛААНБААТАР ХОТ

### 5.4.2. Инвескор Смарт Киоск төхөөрөмж

Үнэт цаас гаргагч нь 2020 оны 03 дугаар улиралд Смарт Киоск буюу зээлийн эдийн засагчийн үйл ажиллагааг орлох, ойрын ирээдүйд биет салбарыг бүхэлд нь орлох зорилготой технологийн шинэлэг шийдэл бүхий төхөөрөмжийг амжилттай нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар зарим худалдааны байгууллагуудтай хамтран бага дүнтэй лизингийн зээлийг Киоскоор дамжуулан шуурхай олгож байна. Киоск төхөөрөмжийг нэвтрүүлснээр зээлийн судалгаанд зарцуулах хугацааг 5 дахин бууруулж чадсан.

2022 оны байдлаар хэрэглэгчийн цагийг хэмнэх зорилгоор үйлчилгээ, худалдааны төвүүд дээр нийт 11 Киоск төхөөрөмжийг байршуулсан байна.

**Зураг 6.** Инвескор Смарт Киоск төхөөрөмжийн тухай мэдээлэл




МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

"ИНВЕСКОР ББСБ" ХК
6060854 1119296063
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2022
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 6. Дотоод тэлэлтийн бодлого

6.1. Үйлчилгээний дотоод тэлэлт

6.2. Салбарын тэлэлт

6.3. Орон нутгийн зах зээлийн тэлэлт

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

# 6. Дотоод тэлэлтийн бодлого

## 6.1. Үйлчилгээний дотоод тэлэлт

"Инвескор ББСБ" ХК нь зах зээлийн судалгаанд үндэслэн салбарын тоогоо нэмэгдүүлж, зээлийн бүтээгдэхүүний нөхцөлүүдээ зах зээлийн нөхцөл байдалд тохируулан санал болгодог. Түүнчлэн финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн болон үйлчилгээ байнга нэвтрүүлэхийг эрмэлздэг. Үүсгэн байгуулагдсан цагаасаа авхуулан зах зээлд гүүрэн зээл, шугамын зээл, факторинг зэрэг шинэ бүтээгдэхүүнүүд хөгжүүлэн нутагшуулж, харилцагчдадаа санал болгосоор иржээ.

Үнэт цаас гаргагч нь КОВИД-19 цар тахлын үед харилцагчдадаа зайнаас буюу цахимаар зээлийн хүсэлтээ өгөх, шаардлагатай тохиолдолд цаг товлож цахимаар уулзалт хийх, шаардлагатай бүх мэдээллээ цахимаар баталгаажуулах зэрэг боломжуудыг бий болгосноор зээл олголтыг нэг ч өдөр таслалгүй ажилласан. Түүнчлэн, 2021 оны 02 болон 04 дүгээр саруудад тогтоосон хатуу хөл хорионы үеэр давхардсан нийт тоогоор 615 харилцагчдад 4.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Цахим зээлийн Покет аппликейшнээр нийт 8.3 тэрбум төгрөгийн, давхардсан тоогоор 53 мянган харилцагчдад зээл олгосон байна.

2021 оны байдлаар нийт харилцагчдын тоо 79.9 мянга хүрсэн нь 2020 онтой харьцуулахад 42 хувийн өсөлттэй үзүүлэлт юм. Нийт харилцагчдын тоо болон зээлийн тоо жилийн дундаж 341 хувийн өсөлттэй байна. Финтект суурилсан бүтээгдэхүүнүүд, борлуулалтын сувгуудын тэлэлт нь харилцагчдын тооны өсөлтийн үндсэн шалтгаанууд гэж тайлбарлаж болно. Смарт Киоск, Покет аппликейшн, мөн цахим салбарууд нь харилцагчдын тоо үлэмж хэмжээгээр нэмэгдэх гол хүчин зүйл болсон бөгөөд дунд хугацааны стратегид хэрэглээний зээлээс гадна бизнесийн зээлтэй харилцагчид тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгч харилцагчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарч байна.

**График 19.** Үнэт цаас гаргагчийн харилцагч, зээлийн тооны мэдээлэл, 2016 - 2021




Эх үүсвэр: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

"Инвескор ББСБ" ХК-ийн эрэгтэй, эмэгтэй харилцагчдын хүйсийн харьцаа 49:51 байна. Нийгмийн тэгш эрх байдлыг дэмжин ажиллахын хүрээнд бизнесийн зээл авсан иргэдийн 44 хувийг эмэгтэй бизнес эрхлэгчид бүрдүүлж байна. Түүнчлэн, "Рио Тинто Монгол" ХХК-тай хамтарсан жижиг дунд үйлдвэрлэл дэмжих хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг, эх, мөн байгальд ээлтэй үйл ажиллагаа эрхлэгчид, эмэгтэй бизнес эрхлэгчдийг зорилтот харилцагч гэж үзэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

**График 20.** Үнэт цаас гаргагчийн зээлдэгчдийн хүйсийн харьцаа, 2021 оны эцсийн байдлаар



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ

## 6.2. Салбарын тэлэлт

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаагаа тэлэхэд “Smart Expansion” стратегийн хүрээнд 2023 он гэхэд 12 салбартай байх төлөвлөгөөтэй ажиллаж байсан бол 2021 оны эцсийн байдлаар Киргиз улсад 3 салбар, Монгол Улсад “Инвескор ББСБ” ХК-ийн 15 салбар, “Инвескор Хэтэвч ББСБ”-ийн 3 салбар, нийт 21 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулан, төлөвлөгөөгөө давуулж биелүүлэн ажиллаж байна.

**График 21.** Үнэт цаас гаргагчийн салбаруудын тоо болон тархалтын мэдээлэл, 2019 - 2021

| | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Нийт салбарын тоо: | 8 | ▲8 16 | ▲5 21 |
| Улаанбаатар | 7 | ▲5 12 | ▲2 14 |
| Орон нутаг | 1 | 1 | 1 |
| Покет | | 2 | ▲1 3 |
| Олон улс | | 1 | ▲2 3 |

## 6.3. Орон нутгийн зах зээлийн тэлэлт

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад ББСБ-ын зах зээлд бусад ББСБ-уудтай хамтран ажиллах, салбарыг олон улсын түвшинд хүргэж тогтвортой хөгжлийн замнал үүсгэх зорилготойгоор “Аллианс” хөтөлбөрийг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн. 21 аймаг тус бүрээс 1 гишүүн ББСБ элсүүлж санхүүгийн үйлчилгээ үзүүлж, ажилтан болон удирдлагын гишүүдийг сургалтад хамруулж, системийн шийдлүүд болон зөвлөх үйлчилгээг санал болгож ББСБ-ын салбарыг өргөжүүлэх нь энэхүү хөтөлбөрийн зорилго билээ.

“Аллианс” хөтөлбөрийн хүрээнд орон нутагт байгаа санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин санхүүгийн зөвлөгөө олгож, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан хамтын хөтөлбөрүүдэд хамруулах зэрэг ажлууд хийгдэж байна.

Энэхүү хөтөлбөр нь дараах чиглэлүүдээр ББСБ-уудад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна:

**Зөв засаглал, зөв менежмент**

Компанийн суурь хөгжлийн үндэс болох засаглал, менежментийн зөвлөгөө өгөх, үлгэр жишээ болох нь орон нутгийн ББСБ-уудын өсөлтийг нэмэгдүүлнэ. Зөвхөн гишүүн ББСБ-уд бус тэдний харилцагч жижиг дунд бизнес эрхлэгчдэд засаглал, менежментийн зөвлөгөө өгч хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

**Эрсдэл, комплаенсын удирдлага**

Эрсдэлд суурилсан үйлчилгээ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, хөрөнгөө зөв удирдахад өндөр дэмжлэг болох “Инвескор ББСБ” ХК-ийн эрсдэл, комплаенсын талаарх ноу-хау, туршлагаас хуваалцах боломжийг олгодог.

**Борлуулалтын удирдлага**

Зах зээлийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн гаргахад зөвлөгөө өгөх эсвэл хамтран ажиллаж боломцоог тогтмол эрэлхийлж байна. Мөн “Инвескор ББСБ” ХК-ийн цахим зээлийн борлуулалт хийж байгаатай холбогдуулан “Аллианс” хөтөлбөрийн хүрээнд борлуулалтын хувьд хамтрах боломцоог судлан, нээж ажиллаж байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭЭ-02

СЗХ
өдөр

## Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн санал хүсэлт, талархал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тал дээр туршлага солилцож харилцагчийн үйлчилгээний нэгдсэн стандарт нэвтрүүлэхэд хамтран ажиллаж байна.

## Тогтвортой эх үүсвэр

Байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээтэй дата мэдээлэл боловсруулах, системийн тогтвортой үйл ажиллагааг хангах тухай зөвлөгөө өгөхөөс гадна тогтвортой, найдвартай, хямд санхүүгийн эх үүсвэрээр хангаж байгаа нь нэн оновчтой дэмжлэг болж байна. Үнэт цаас гаргагч нь ирээдүйд өсөн тэлж хөгжих боломжтой ч өнөөдөр эх үүсвэр татахад хүндрэлтэй тулгарч буй ББСБ-уудад тогтвортой эх үүсвэрийг олгож байна. Урт хугацаанд тогтвортой санхүүгийн бусад эх үүсвэрийг татах боломж бүрдэх хүртэл дэмжих бодлогыг баримталж байна.

## Сургалт, зөвлөх үйлчилгээ

"Инвескор ББСБ" ХК нь Банк Санхүүгийн Академийн сургагч багшийн хөтөлбөрт хамрагдсан ба мэргэшсэн ажилчдаараа дамжуулан сургалт хийх, мэдээлэл хүргүүлэх, зөвлөгөө өгөх ажлуудыг гүйцэтгэж байна.

## Систем, програм хангамж

Дотооддоо хөгжүүлсэн финтек санхүүгийн систем, програм хангамжуудыг гишүүн ББСБ-уудтай хуваалцаж байна. Систем болон програм хангамжуудыг ашиглах нь орон нутгийн ББСБ-уудад ихээхэн зардлыг хэмнэх, санхүү удирдлагаа сайжруулах боломжуудыг олгож байгаа бөгөөд нэвтрүүлсэн системд үндэслэн гаргасан удирдлагын шийдвэр нь илүү хурдан, оновчтой, мэдлэгтэй шийдвэр байх юм.

## Хамтын санхүүжилт

2021 оны байдлаар Өмнөговь, Баянхонгор, Дорнод, Өвөрхангай аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй 4 ББСБ хөтөлбөрт элссэн байна. 2022 онд Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Дорноговь, Баян-Өлгий, Увс зэрэг 6 аймгуудын ББСБ-уудыг хамруулж, нийт 10 гишүүн ББСБ-тэй болох төлөвлөгөөтэй байгаа ба 2025 он хүртэл 21 аймгаас тус бүр 1 гишүүн элсүүлж байх төлөвлөгөөтэй байна.

Мөн "Инвескор ББСБ" ХК нь хамтын ажиллагаанд үргэлж нээлттэй байдаг бөгөөд хөрөнгийн зах зээлд анхны нээлттэй ХБҮЦ-ыг "Микро Кредит ББСБ" ХХК-тай хамтран МХБ дээр гаргаж арилжаалсан билээ. Бусад ББСБ болон байгууллагуудтай өрсөлдөхөөс илүүтэйгээр хамтын ажиллагааг өргөжүүлэх нь дотоодын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд илүү хувь нэмэртэй хэмээн бид үзэж байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР
БОНД 2.

# 7. Гадаад зах зээл дэх тэлэлтийн бодлого

7.1. Бүгд Найрамдах Киргиз Улс

7.2. Бүгд Найрамдах Казахстан Улс

7.3. Тэлэлт дагасан хүний нөөцийн бодлого

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore FINANCIAL INSTITUTION
6060854 1119286053
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

# 7. Гадаад зах зээл дэх тэлэлтийн бодлого

"Инвескор ББСБ" ХК нь өөрийн бизнесээ зөвхөн дотоод зах зээлээр хязгаарлахгүйгээр Монгол Улстай соёл болон бусад зүйлээрээ ижил төстэй хөгжиж буй орнуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ экспортлох бодлого баримталдаг.

Төв Азийн хөгжиж буй орнуудын зах зээлд өөрсдийн амжилт туршлага, финтек бүтээгдэхүүн, санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн давуу талаа ашиглан, салбар компани байгуулах төлөвлөгөөний дагуу 2020 онд Бүгд Найрамдах Киргиз Улсад хоёр охин компаниа байгуулж, үйл ажиллагааг нь амжилттай эхлүүлээд байна.

"Инвескор ББСБ" ХК-ийн хувьд гадаад зах зээлээ тэлэх үйл ажиллагааг **Төв Азийн зах зээлээр эхлэх болсон нь доорх шалтгаануудтай:**

Төв Азийн орнууд нь Монгол Улстай нийгэм, соёл, эрхзүйн орчин, эдийн засгийн бүтцийн хувьд харьцангуй ойролцоо тулд харилцан ойлголцох, хамтран ажиллахад илүү хялбар.

Өндөр хөгжсөн зах зээлд нэвтэрч өрсөлдөх нь хэцүү бөгөөд их хэмжээний урсгал зардал болон капитал хөрөнгө оруулалтыг шаардана. Харин Төв Азийн орнуудад үйл ажиллагаа явуулах дундаж өртөг, зардлууд харьцангуй бага байна

Төв Азийн орнуудын санхүүгийн зах зээл нь өсөж томрох асар их боломжуудыг агуулдаг. Үндэслэл нь үлэмж хэмжээний хөндөөгүй байгалийн баялаг; БНХАУ, ОХУ зэрэг том зах зээлүүдтэй ойр байрших геополитикийн давуу тал болон залуу демографик юм.

Зүүн Өмнөд Азийн зах зээлтэй харьцуулахад бичил санхүүгийн үйлчилгээ, Финтект суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд харьцангуй хөгжиж амжаагүй.

Төв Азийн дийлэнх орнууд 30 гаруй жилийн өмнө тусгаар тогтнолоо зарлаж чөлөөт эдийн засгийн тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон дэмжих чиглэлээр нээлттэй бодлого баримталж байна.

2022 онд Үнэт цаас гаргагч нь Төв Азийн зах зээл хариуцсан газрыг шинээр байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлсэн бөгөөд уг газар нь Төв Азийн зах зээл дэх хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг бүрэн хариуцаж бусад газар нэгжүүдтэй координаци хийх болон Инвескор Санхүүгийн Группийн хэмжээнд синержи үүсгэх чиг үүргийг хариуцан ажиллана.

## 7.1. Бүгд Найрамдах Киргиз Улс

### 7.1.1. Киргиз Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээл

Бүгд Найрамдах Киргиз Улс нь 6.7 сая хүн амтай бөгөөд 2021 оны эцсийн байдлаар ДНБ нь 8.5 тэрбум ам.доллар байна. Мөнгөний нэгж нь Киргиз сом бөгөөд 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэг Киргиз сом-той харьцах төгрөгийн ханш 35.5 байна. Киргиз Улсын эдийн засаг нь ОХУ-д ажилладаг иргэдээс орж ирэх валютын орлого болон Кумторын уурхайн алтны экспортын орлогод түлхүү түшиглэсэн байдаг. Мөн аялал жуулчлал, хөдөө аж ахуй, худалдааны салбарууд нь эдийн засагт чухал нөлөөтэй.

**Зураг 7.** Киргиз Улсын газар зүйн байршил




Киргиз Улсын эдийн засаг 2021 онд 3.6 хувиар өссөн бол 2022 онд 4.30 хувиар өснө гэж Азийн Хөгжлийн Банк таамагласан байна. *(Эх сурвалж: ОУВС)* Киргиз Улсын санхүүгийн салбар нь Монгол Улсынхтай төстэй буюу 90 хувь нь арилжааны банкнууд дээр тулгуурладаг. Сүүлийн 10 жилийн хувьд ББСБ-ын салбарын нийт актив жилд дунджаар 20-30 хувиар өссөн бөгөөд Төв банк нь Банк, ББСБ, Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-г хариуцаж хяналт тавьдаг учраас бодлогын уялдаа холбоо илүү сайн байх боломжтой.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore FINANCIAL INSTITUTION
6060854 1119286065
УЛААНБААТАР ХОТ

2022 оны 04 дүгээр сард Киргиз Улсын засгийн газар Центерра Гоулд компанитай удаан үргэлжилсэн маргааныг эцэслэж Кумторын алтны уурхайг 100 хувь эзэмших болсноор дунд хугацаандаа экспортын орлого огцом өсөх хүлээлтийг үүсгэж байна. Судлаачдын үзэж буйгаар ирэх 10 жилийн хугацаанд Кумторын ил уурхай хамгийн багадаа 160-200 тонн алт олборлож, 5 тэрбум ам.долларын орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр байна.

### 7.1.2. "Инвескор Си Эй МФК" ХК

Киргиз Улсын зах зээлд "Золотой Стандарт МКК" ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байсан бичил зээлийн байгууллагыг "Инвескор ББСБ" ХК нь 2020 онд худалдан авч 100% хувь эзэмших болсон бөгөөд өөрийн үйл ажиллагааны журам, процесс, систем болон ноу-хау зэргийг уг байгууллагад бүрэн нэвтрүүлж зах зээлд дахин байршуулалтыг амжилттай хийсэн болно. Үнэт цаас гаргагч нь тус охин компанидаа Киргиз Улсын тэргүүлэх зэрэглэлийн арилжааны банкнуудад ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүдийг элсүүлж авснаар "Золотой Стандарт МКК" ХХК-ийн зээлийн бодлого, эрсдэлийн бодлого болон борлуулалтын үйл ажиллагаанд томоохон ахиц дэвшил гарсан.

**Зураг 8.** Киргиз Улс дахь салбарын хамт олон, 2021




Мөн 2021 оны 11 дүгээр сард зохих ёсны шаардлагуудыг бүрэн хангаснаар "Золотой Стандарт МКК" ХХК нь Киргиз Улсын Төв банкнаас Бичил Санхүүгийн Компани буюу Микро Финанс Компани (МФК)-ийн тусгай зөвшөөрлийг авснаар Киргиз Улсын Бичил Санхүүгийн Компанийн тусгай зөвшөөрөл бүхий 10 компанийн нэг болсон ба албан ёсны нэрийг "Инвескор Си Эй МФК" ХК болгон өөрчилсөн болно. Уг тусгай зөвшөөрлийг авснаар компанийн нэг харилцагчид олгох зээлийн дээд хэмжээ 1 сая сомоос 3 сая сом болж нэмэгдсэн бөгөөд олон нийтэд нээлттэй хувьцаагаа санал болгох, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх эрхүүд мөн нээгдэж байгаа юм.

**Зураг 9.** Киргиз улс дахь салбар




"Инвескор Си Эй МФК" ХК-ийн гол санхүүгийн үр дүн, үзүүлэлтүүд (2021 оны эцсийн байдлаар):

| | |
|---|---|
| Үндсэн ажилтны тоо: 22 | Салбарын тоо: 3 |
| Нийт зээлийн багц 6.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 183% ▲ өссөн | Нийт хөрөнгө 7.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 167% ▲ өссөн |
| Нийт зээлийн тоо 832-т хүрч өмнөх оны мөн үеэс 228% ▲ өссөн | Нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээл: 2.6% |
| Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээл: 0.3% | |

### 7.1.3. "Покет КГ" ХХК

Үнэт цаас гаргагч нь Киргиз Улс дахь өөрийн 100% охин компани, "Покет КГ" ХХК-ийг 2020 оны 08 дугаар сард шинээр үүсгэн байгуулсан бөгөөд уг компани нь Монгол Улсад амжилттай нэвтэрч зах зээлийг тэргүүлэх болсон Покет аппликэйшний Киргиз Улсын зах зээлд зориулсан хувилбарыг хөгжүүлж нэвтрүүлэхээр ажиллаж байна. 2021 онд эдийн засгийн орчин, зах зээлийн судалгаа, системийн хөгжүүлэлт, туршилт зэрэг ажлуудыг амжилттай хийж дуусгасан бөгөөд 2022 оны эхний хагаст багтаан цахим хэтэвч, цахим төлбөр тооцоо болон дижитал зээлийн бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна.

**Зураг 10.** Покет Киргиз – Киргиз Улсын хэрэглэгчдэд зориулсан цахим хэтэвч




Ингэснээр Покет аппликэйшн нь Киргиз Улсын хувьд хамгийн анхны цахим хэтэвчид суурилсан дижитал зээлийн бүтээгдэхүүнийг харилцагч нарт санал болгож буй бүтээгдэхүүн болно. "Покет КГ" ХХК нь Монголд хэрэгжиж буй бизнес загвартай адилхан байдлаар буюу "Цахим зээлийн төв" хэлбэрээр зээлийн багцын эх үүсвэрийг бусад банк, санхүүгийн байгууллагуудаар бүрдүүлүүлж хүү, шимтгэл хуваах нөхцөлтэйгээр ажиллана. Уламжлалт байдлаар зээл олгодог байгууллагууд нэг аппликейшнээр дамжуулан өөрийн цахим зээлийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд илүү хялбар арга замаар хүргэх ба цаашид зөвхөн зээлээс гадна бусад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг Покет аппликэйшн дээр нэвтрүүлснээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд төгс нийцсэн санхүүгийн платформ болох юм.

## 7.2. Бүгд Найрамдах Казахстан Улс

Үнэт цаас гаргагч нь Киргиз Улсад амжилттай хэрэгжсэн туршлагаа хөрш орон болох Бүгд Найрамдах Казахстан Улсад нэвтрүүлэхээр ажиллаж байгаа ба тус улсад банк бус санхүүгийн буюу ижил төсөөтэй үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг авч, үйл ажиллагаа явуулахаар бэлтгэж шинэ компаниа байгуулаад байна. Покет аппликэйшны хувьд Казахстан Улсын зах зээлд ажиллаж буй цахим төлбөр тооцоо болон дижитал зээлийн аппликэйшнуудаас ялгарах онцлог нь байнгын тогтвортой эх үүсвэр, олон жилийн туршлага тооцоолол дээр үндэслэсэн авто кредит скоринг систем, төрийн байгууллагуудын цогц холболт, зээлийн сайн түүхтэй харилцагч нарт чиглэсэн олон төрлийн бонус урамшуулал зэрэгт оршино.

## 7.3. Тэлэлт дагасан хүний нөөцийн бодлого

Үнэт цаас гаргагч нь олон улсад үйл ажиллагаа явуулж, тэлэлт хийх стратеги баримтлан ажиллах хүрээнд хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, гадаад хамтрагчидтай хамтран ажиллах чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх бодлого баримталж буй бөгөөд 2023 онд байгууллагын албан ёсны хэлийг Англи хэл болгохоор төлөвлөн ажиллаж байна. Мөн Орос хэлтэй ажилтнуудын тоог нэмэгдүүлж, Төв Азид удаан хугацааны томилолтоор очиж ажиллах ажилтнуудыг бэлтгэж байна.

2022 .11. 09 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 21

ИНВЕСКОР
БОНД 2.

# 8. Үнэт цаас гаргагчийн санхүүжилтын эх үүсвэр татах үйл ажиллагаа

8.1. Хувьцааны санхүүжилт

8.2. Өрийн хэрэгслийн санхүүжилт

8.3. Итгэлцлийн үйлчилгээ

8.4. Гадаадын хөрөнгө оруулалт, эх үүсвэр

8.5. Бусад эх үүсвэр

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore FINANCIAL INSTITUTION
6060854 1119288063
УЛААНБААТАР

# 8. Үнэт цаас гаргагчийн санхүүжилтын эх үүсвэр татах үйл ажиллагаа

"Инвескор ББСБ" ХК-ийн хурдтай өсөлтийг дэмжиж, санхүүжүүлж буй эх үүсвэр нь итгэлцлийн үйлчилгээ, дотоод банк санхүүгийн байгууллагууд, гадаад санхүүгийн байгууллагууд, үнэт цаасны буюу бондын санхүүжилт болон бусад эх үүсвэр гэсэн хэсгүүдээс бүрддэг. Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн СЗХ-оос баталсан санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасаар ирсэн ба эх үүсвэрүүдээ төрөлжүүлж, санхүүжилтын боломжуудаа бүрэн ашиглах замаар өөрийн хөрөнгөө тасралтгүй нэмэгдүүлж, харьцаа үзүүлэлтүүдээ улам сайжруулан үйл ажиллагаагаа өргөжүүлж байна.

## 8.1. Хувьцааны санхүүжилт

Үнэт цаас гаргагч нь 2019 онд анх удаа компанийн хувьцаагаа олон нийтэд зарлаж, компанийн сайн засаглал, жишиг менежментийг банк бус санхүүгийн салбарт тогтоох зорилготойгоор нийт хувьцааны 15 хувийг олон нийтэд анх удаа санал болгон гаргаж, МХБ дээр бүртгүүлсэн билээ.

"Инвескор ББСБ" ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад нийт 336 хувь хүн, аж ахуйн нэгжүүд оролцсон ба нийт 2,899,735,069 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх доод дүнгээс 15.9 хувь давсан үзүүлэлт болсон. Харин стратегийн 14 хөрөнгө оруулагчдаас нийт 16,004,292,500 төгрөгийн хувьцаа худалдан авах санал ирүүлсэн нь стратегийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх доод дүнгээс 6.1 хувь давсан бөгөөд уг стратегийн хөрөнгө оруулагчдыг гадаадын хөрөнгө оруулагчид, тэр дундаа Японы хөрөнгө оруулагчид бүрдүүлж байсан билээ.

**Зураг 11.** Үнэт цаас гаргагчийн хувьцааны арилжааг нээх цан цохих ёслол, 2019 он



Нийт татан төвлөрүүлсэн 18.6 тэрбум төгрөгийг зээлийн үйл ажиллагаа болон дотоод системийн хөгжүүлэлтэд зарцуулсан ба үр дүнд нь зээлийн багцаа 78 хувиар, нийт хөрөнгөө 110 хувиар өсгөсөн амжилтыг үзүүлсэн. Түүнчлэн, 2019 онд эздийн өмчийг 191 хувиар нэмэгдүүлсэн нь итгэлцлийн болон бусад эх үүсвэр татан төвлөрүүлэх хэмжээгээ нэмэгдүүлэх боломжийг бий болгож өнөөдрийн өсөлтөд нөлөөлөх хамгийн том хүчин зүйлсийн нэг болсон юм.

2019 онд анх МХБ-ийн гуравдугаар самбарт бүртгүүлж байсан бол түүнээс хойш 2020 онд Топ 20 ААНБ-д багтах болж, 2021 онд МХБ-ийн нэгдүгээр самбарт ахиж амжилт үзүүлсэн билээ. МХБ нь бүртгэлтэй компаниудыг самбар ахиулахад санхүүгийн тайлан, хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээ, мөн ашигт ажиллагааны шалгуурыг харгалзан үздэг тул энэ нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны амжилтыг харуулж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

2019 оны хоёрдугаар хагас жилд хувьцааны арилжааны дүн 2.6 тэрбум төгрөг байсан нь МХБ-ийн нийт хувьцааны арилжааны 6 хувийг бүрдүүлсэн. 2020 онд "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаа МХБ дээрх хамгийн идэвхтэй арилжаалагдсан хувьцаа болж байсан ба жилийн турш нийт 6 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь МХБ-ийн нийт хувьцааны арилжааны 10 хувийг бүрдүүлж байв.

Үнэт цаас гаргагч нь олон нийтийн хувь эзэмшил болон өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгын хүрээнд ТУЗ-ийн 2022 оны 4 сарын 7-ны өдрийн 11 тоот тогтоолоор нийт 82,000,000 ширхэг зарласан хувьцааны эргэлтэд гараагүй 10,272,082 ширхэг хувьцаанаас 4,000,000 ширхэг хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгон арилжаалахаар шийдвэрлэсэн бөгөөд үнэт цаасны танилцуулгыг холбогдох бусад материалуудын хамт Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлсэн.

Монголын Хөрөнгийн Бирж нь 2022 оны 6 сарын 3-ны өдрийн А/52 тоот тушаалаар Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй нийт 4,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж бүртгэн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 6 сарын 8-ны өдрийн 310 тоот тогтоолоор Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй нийт 4,000,000 ширхэг хувьцааг нэг бүрийн үнийг нь 4155 төгрөгөөр олон нийтэд санал болгож анхдагч зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн байна.



**График 22.** Үнэт цаас гаргагчийн хувьцааны арилжааны түүх, 2019 – 2022 оны 01 дүгээр улирал




**Эх сурвалж:** Монголын Хөрөнгийн Бирж

2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр МХБ дээр хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 1,640 төгрөгөөр нээгдсэн бол 2021 оны эцсээр хувьцааны ханш анх олон нийтэд зарлаж байсан ханшаас 145 хувиар өсч, 4,043 төгрөгийн үнэ дээр хаагдаж байсан юм.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

САХ
өдөр 2022 оны 11, 03 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

**График 23.** Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийн өсөлт, 2019 – 2022 оны 01 дүгээр улирал, хаалтын ханшаар




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж



**График 24.** Үнэт цаас гаргагчийн нийт актив болон эздийн өмчийн өгөөж, 2019 - 2021, хувиар




## 8.2. Өрийн хэрэгслийн санхүүжилт

Санхүүгийн байгууллагын тогтвортой өсөлтийн хөшүүрэг болдог санхүүгийн хэрэгсэл бол компанийн өрийн бичиг буюу компанийн бонд юм. Үнэт цаас гаргагч нь 2021 онд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, нээлттэй бонд зэрэг үнэт цаасыг олон нийтэд түлхүү санал болгож МХБ-ээр дамжуулан хөрөнгийн зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан. 2020 оноос эхлэн хаалттай болон нийтэд нээлттэй хүрээнд нийт 4 өрийн хэрэгсэл гаргасан. Цаашид ч мөн адил тогтмол өрийн бичиг гаргах төлөвлөгөөтэй байгаа ба өрийн хэрэгсэл гаргах нь хөрөнгө оруулагчдын хувьд өндөр өгөөжтэй, төлөвлөхөд харьцангуй хялбар хөрөнгө оруулалт байдаг тул хөрөнгө оруулагч болон Үнэт цаас гаргагчид давуу байдал үүсгэдэг.



"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

### 8.2.1. Монголын Хөрөнгийн Бирж дээр хэрэгжүүлсэн нээлттэй өрийн хэрэгсэл

"Инвескор ББСБ" ХК нь 2021 онд Монголын хөрөнгийн зах зээл дээр анх удаа Бондын хөтөлбөр хэрэгжүүлж, 20 тэрбум төгрөгийг нээлттэй зах зээлээс татан төвлөрүүлсэн. Бондын хөтөлбөрийг гурван транчаар буюу 3 хэсэгчилж гарсан ба бүх транчийн захиалга 100 хувийн биелэлттэй байсан. Үнэт цаас гаргагч нь уг 20 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн 55 хувийг бизнесийн зээл, 45 хувийг хэрэглээний зээл олгоход зарцуулсан ба энэ нь 2021 оны нийт зээл олголтын 7 хувийг бүрдүүлсэн. 2021 онд эхний транчийн хүүгийн төлбөр болох 495 сая төгрөгийн төлөлт хийж, хөрөнгө оруулагчдад амласан өгөөжөө өгсөн бөгөөд 2022, 2023 онуудад нийт 4.7 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлж, 2023 онд хэсэгчлэн 20 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийгдэх хуваарийн дагуу ажиллаж байна.

**График 25.** Үнэт цаас гаргагчийн 2021 онд МХБ дээр нээлттэй хүрээнд арилжаалсан 20 тэрбум төгрөгийн бондын хөтөлбөрийн эргэн төлөлтийн хуваарь, сая төгрөгөөр




### 8.2.2. Хаалттай өрийн хэрэгсэл

Үнэт цаас гаргагч нь 2020 онд хаалттай хүрээнд санал болгон арилжаалах зорилгоор 8.2 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл хаалттай хүрээнд гаргаж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө зээлийн үйл ажиллагаагаа тэлсэн. Тухайн үнэт цаас нь хөрөнгө оруулагч нарт уян хатан хугацаа санал болгосон, хүүгийн өгөөжийн хувьд онцлогтой бүтээгдэхүүн байсан билээ. "Инвескор ББСБ" ХК нь 2020 оноос хойш өрийн хэрэгслийн хүүгийн төлбөрт 267 удаагийн, нийт 6.3 тэрбум төгрөгийн төлөлтийг цаг тухайд нь төлсөн байна. 2022 онд нийт 4 тэрбум төгрөгийн 63 удаагийн төлөлт хийгдсэнээр бүрэн төлөгдөж барагдуулах байна.

**График 26.** Үнэт цаас гаргагчийн 2020 онд хаалттай хүрээнд санал болгон арилжаалсан 8.2 тэрбум төгрөгийн бондын эргэн төлөлтийн хуваарь, 2022 онд, сая төгрөгөөр




### 8.2.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)

2021 оны 01 дүгээр сард Монголын хөрөнгийн зах зээлд хувийн хэвшлийн анхны ХБҮЦ-ыг нэвтрүүлсэн ба уг шинэ төрлийн үнэт цаасаар 4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн билээ. "Инвескор ББСБ" ХК нь "Микро Кредит ББСБ" ХК-тай хамтран энэхүү ХБҮЦ-ыг гаргасан ба анхдагч зах зээлийн захиалга 2 дахин давж биелсэн. Үнэт цаас нь автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсанаараа онцлогтой, найдвартай хөрөнгө оруулалтуудын бүтээгдэхүүнүүдийн тод жишээ болж чадсан билээ. 2021 оны эцсийн байдлаар хүү болон үндсэн төлбөрөөс 3 удаагийн 1.9 тэрбум төгрөгийг цаг тухайд нь төлсөн байна. 2022 онд 2.3 тэрбум төгрөг, 2023 онд 518 сая төгрөг тус тус үндсэн болон хүүгийн төлөлт хийх төлөвлөгөөтэй байна.

**График 27.** Үнэт цаас гаргагчийн 2021 онд МХБ дээр нээлттэй хүрээнд арилжаалсан 4 тэрбум төгрөгийн ХБҮЦ-ны эргэн төлөлтийн хуваарь, сая төгрөгөөр




"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ

### 8.2.4. Биржийн Бус Зах Зээлийн үнэт цаас

2021 онд ББЗЗ-ийн зохицуулалт батлагдсанаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдад ББЗЗ дээр үнэт цаас гаргах, арилжаалах дэд бүтэц бүрдсэн ба "Инвескор ББСБ" ХК нь Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны дэргэдэх ББЗЗ-ийн ОТС платформ дээр нийт 10 тэрбум төгрөгийн бондын хөтөлбөр хэрэгжүүлж буйгаас эхний транч болох 3.7 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд санал болгон амжилттай гаргаж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа өргөжүүлсэн билээ. 2022 онд үндсэн болон хүүгийн 4.3 тэрбум төгрөг, 2023 онд нийт 7.1 тэрбум төгрөгийн төлөлт хийгдэх хуваарьтай байна.

**График 28.** Үнэт цаас гаргагчийн Биржийн бус зах зээл дээр хаалттай хүрээнд санал болгож буй 10 тэрбум төгрөгийн бондын хөтөлбөрийн эргэн төлөлтийн хуваарь, сая төгрөгөөр




## 8.3. Итгэлцлийн үйлчилгээ

ББСБ-ууд нь СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд итгэлцлийн үйлчилгээгээр харилцагчдаасаа эх үүсвэр татан төвлөрүүлдэг ба "Инвескор ББСБ" ХК нь байгуулагдсан үеэсээ энэхүү үйлчилгээг тогтвортой хэрэгжүүлж, харилцагчдадаа тогтвортой санхүүгийн үр өгөөжийг өгч байгаа билээ. Энэхүү үйлчилгээний хүрээнд харилцагчид итгэлцэлд байршуулсан хөрөнгөө жил бүр нэмэгдүүлэх хандлага ихэссээр байгаа нь "Инвескор ББСБ" ХК-д итгэх итгэл нэмэгдэж байгаагийн бас нэг илрэл юм.

"Инвескор ББСБ" ХК-ийн итгэлцлийн хугацаа 6 сараас дээш ба даатгалд хамруулах, хүүгийн хувьд өрсөлдөхүйц, ашигтай хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагчдад санал болгодог бөгөөд уг үйлчилгээг 15 салбараараа дамжуулан олгож байна.

## 8.4. Гадаадын хөрөнгө оруулалт, эх үүсвэр

"Инвескор ББСБ" ХК нь гадны хөрөнгө оруулагч, краудфандинг, хөгжлийн банкнуудтай харилцаагаа өргөжүүлж эхний санхүүжилт татан төвлөрүүлж ажиллах зорилгын хүрээнд гадаадын байгууллагаас урт хугацааны хөрөнгө оруулалт татах зорилгыг баримтлан ажиллаж байгаа ба энэ нь урт хугацаандаа эх үүсвэрийн зардлыг бууруулж, ашигт ажиллагаанд эергээр нөлөөлнө хэмээн төлөвлөсөн.

Мөн Үнэт цаас гаргагч нь жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор "Рио Тинто Монгол" ХХК-тай хамтран бага хүүтэй зээлийн хөтөлбөр 2021 онд хэрэгжүүлсэн билээ. Хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд үргэлжилж 1,000 гаруй ажлын байрыг хамгаалах зорилготой бөгөөд

Үнэт цаас гаргагч нь итгэлцлийн үйлчилгээгээр гурван төрлийн (төгрөгийн, ам.долларын, япон иений) валютаар дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдаас эх үүсвэр татдаг бөгөөд 2021 оны эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг 52.3 тэрбум төгрөгт хүрээд байна.

2021 оны эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий 43 ББСБ-уудаас "Инвескор ББСБ" ХК нь салбарын нийт итгэлцлийн үйлчилгээний 29 хувийг дангаар бүрдүүлсэн нь хөрөнгө оруулагчдын дунд тус компанийн нэр хүнд, итгэл өндөр байгааг илтгэж байна. *(Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо, ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн танилцуулга)*

250 хүртэлх компаниуд хамрагдах бөгөөд зээл хүсэгчид АНУ-ын хөгжлийн агентлаг, мэргэшсэн бизнес, санхүүгийн сургалтуудад үнэ төлбөргүй хамрагдах өргөн боломжтой гэдгээрээ онцлогтой юм.

Үнэт цаас гаргагч нь 2021 оны 09 дүгээр сард 100 гаруй улсын 2,000 гаруй санхүүгийн байгууллагуудын зэрэглэл, рейтинг тогтоож байсан "MicroFinanza Rating" SRL байгууллагаас Монгол Улсдаа хамгийн өндөр "A- High" үнэлгээ авсан нь санхүүжилт татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг даах, зээлдэгч нарт илүү хямд бүтээгдэхүүн санал болгох боломжийг нээсэн үйл явдал юм.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ


MFR

INSTITUTIONAL RATING

The MFR Rating Committee assigns to

**InvesCore NBFI - Mongolia**

Grade: α- High

Good outlook for financial sustainability, which may be affected by a deterioration of the operations or economic conditions. Good fundamentals.

Milan, September 2021

Зураг 12. Үнэт цаас гаргагчийн үнэлгээний "A- High" батламж

Үүний дараа "Инвескор ББСБ" ХК нь "EMF MICROFINANCE FUND"-с 3 сая ам.долларын урт хугацаат зээлийн санхүүжилт амжилттай татаж чадсан билээ.

2022 оны 04 дүгээр сард Нидерланд улсын Hands-on B.V "Lendahand" нэртэй краудфандинг платформоос 2.5 сая ам.долларын урт хугацаат хөрөнгө оруулалтыг хэсэгчлэн татаж эхэлсэн ба уг хөтөлбөрийн хүрээнд "Микро Кредит ББСБ" ХХК-тай хамтран ажиллаж байна. Энэхүү платформ нь жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг ААН, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой ба 2022 оны байдлаар нийт 2,900 гаруй төсөлд хөрөнгө оруулалт татаж, 9,500 гаруй ажлын байр бий болгож, 120 сая еврогийн хөрөнгө оруулалт татаж чадсан амжилттай байна.

## 8.5. Бусад эх үүсвэр

Үнэт цаас гаргагч нь зээлийн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаатай уялдуулан арилжааны банкнууд болон бусад санхүүгийн байгууллагуудаас зээл, шугамын зээлийн эх үүсвэрүүдийг бүрдүүлж, жил бүр багцаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Уг зорилгын хүрээнд богино хугацаанд мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлэх, эх үүсвэрээ нэмэх шаардлага гардаг тул борлуулалтын өсөлтөө хүртээмжтэй байлгах зорилгоор зээлийн шугамаа богино хугацаанд ашиглах зохицуулалтуудыг хийж байгаа болно.

СЗХ
оны сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21

ИНВЕСКОР
БОНД 2.

# 9. Үйл ажиллагааны зохистой удирдлага

9.1. Хүний нөөц

9.2. Судалгаа болон хөгжүүлэлт

9.3. Хамтын ажиллагаа

9.4. Маркетинг

9.5. Мэдээллийн аюулгүй байдал

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК

# 9. Үйл ажиллагааны зохистой удирдлага

## 9.1. Хүний нөөц

### 9.1.1. Хүний нөөцийн бодлого

Үнэт цаас гаргагч нь дотоод соёлдоо "Инвескорлог сэтгэл" буюу эерэг хандлага, зөв үйлдэл, өсөлтөт сэтгэлгээ, хамтын амжилтын төлөө мэргэжлийн түвшинд өөрийн хувь нэмрээ бүрэн ашиглаж, дайчлах хүсэл зориг, тэмүүлэлтэй хүний нөөцийг бий болгохыг зорьдог. Чадварлаг баг, хамт олон бүрдүүлэн, тэднийг тасралтгүй хөгжүүлж, дэвшүүлж, идэвхжүүлэн, мерит зарчмыг баримталж, гүйцэтгэлд суурилсан цалин урамшуулал олгож, эрүүл мэндийг нь хамгаалж, аюулгүй орчинд тогтвортой, бүтээмжтэй, сэтгэл хангалуун ажиллуулах хүний нөөцийн бодлого баримталдаг бөгөөд үйл ажиллагаандаа дараах бодлогуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Цалин, урамшууллын бодлого
- Сургалт, хөгжлийн бодлого
- Ажилтнуудыг идэвхжүүлэх, дэвшүүлэх бодлого
- Түлхүүр ажилтнуудыг тогтвортой ажиллуулах бодлого
- Гүйцэтгэлийн үнэлгээний удирдлага
- Ажилтан сонгон шалгаруулах бодлого

Түүнчлэн ажилтан бүрт тэнцвэртэй, шударга үйлчлэх, компанийн дотоод дүрэм журам, холбогдох хууль, журмын дагуу мэргэжлийн түвшинд ажиллах, ажилтнуудын хэрэгцээ шаардлагыг мэдэрч, дэмжих, зөвлөх, туслах чиг үүрэгтэй чадварлаг хүний нөөцийн газар, баг хамт олонтой. Хүний нөөцийн газар нь 2021 оны сүүлийн байдлаар 158 ажилтны ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тулгамдаж буй асуудлуудыг нь шийдвэрлэн ажилласан бол 2022 онд шинээр 40 ажлын байр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаагаас 40% нь салбаруудын хүний нөөцийн тэлэлт байна. Төв оффист нэмэгдэх ажлын байрууд нь системийн хөгжүүлэлт, дэмжлэг, бизнесийн шинжилгээ, мэдээллийн аюулгүй байдал, маркетингийн багийн өргөжилттэй холбоотой төлөвлөгдсөн. 2022 оны эцэс гэхэд үндсэн ажилтны тоо 198 болох төлөвлөгөөтэй ба 55% нь салбарын ажилтнууд бол 45% нь төв оффист харьяалагдана.

**График 29.** Үнэт цаас гаргагчийн үндсэн ажилтнуудын тоо, 2016 – 2021, 2022 оны төлөвлөгөө

| 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | 16 | 36 | 101 | 107 | 160 | 198 |

Үнэт цаас гаргагч нь ажилтны тоог нэмэгдүүлэхээс илүү нэг ажилтны бүтээмж, чанарыг эрхэмлэх бодлогыг мөн баримталж байна. Бодлогын хэрэгжилтийг хангахаар 2021 оны 04 дүгээр улиралд хийсэн цалин, гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын системийн судалгаанд үндэслэн цаашид компанийн хэмжээнд ажилтны цалинг дунджаар 15-25 хувиар нэмэгдүүлж, банк санхүүгийн байгууллага дотроо өрсөлдөхүйц хэмжээний цалин, урамшуулал олгох зорилготой ба нэгж ажилтны бүтээмжид түлхүү анхааран, бүтээмж гүйцэтгэл өндөртэй ажилтанд өндөр цалин олгох зорилготой.

Ажилтнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулах, автомашины хөнгөлөлттэй зээл авах, спортоор хичээллэх болон спортын наадамд оролцох, сонирхлын клубуудыг дэмжих зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21 БҮРТГЭВ

"ИНВЕСКОР ББСБ" ХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

Мөн Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн хувьд тогтвортой, ажилтнуудынхаа ажлын байрны найдвартай байдлыг хангахад өндөр ач холбогдол өгч ажилладаг бөгөөд КОВИД-19 болон эдийн засгийн хямрал зэрэг нийгэм эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын үед ажилтнуудынхаа ажлын байрыг хадгалах, цалин урамшуулал болон ажлын байрыг дордуулахгүй байх зарчмыг баримтлан арга хэмжээ, төлөвлөгөөг авч хэрэгжүүлсэн. Компани нь уг зарчмын хүрээнд 2020 - 2021 онууд дахь КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралыг амжилттай давсан.

#### 9.1.2. Сургалт хөгжил

Үнэт цаас гаргагчийн Хүний нөөцийн газраас ерөнхий ур чадвар, сэтгэл зүйн чиглэлийн сургалтуудыг зохион байгуулахаар 2022 оны сургалтын төлөвлөгөөндөө багтаасан ба газар, нэгж бүр ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтууд төлөвлөөд байна. Мөн компани дотроо 10 дотоод сургагч багш нарыг Банк Санхүүгийн Академитай хамтран бэлтгэсэн ба дотоод сургалтын төлөвлөгөө гарган, сургагч багш нараараа ажилтнуудаа сургалт зохион байгуулах, тэднийг тасралтгүй хөгжүүлэх, нэмэгдэл хөлс олгох зарчмаар дотоод сургалтын нөөцийг бататгах зорилготой ажиллаж байна. 2021 онд ажилтнуудынхаа санаачилсан төсөл хөтөлбөрт 120 гаруй сая төгрөгийг сургалтад зарцуулсан байна.

### 9.2. Судалгаа болон хөгжүүлэлт

#### 9.2.1. Судалгаа болон хөгжүүлэлтийн бодлого

Үнэт цаас гаргагч нь Төслийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд үр дүнд нь цаашид Project Management Body of Knowledge (PMBOK) стандартын дагуу нийт төсөл, хөгжүүлэлтийг хийх ба тэсрэлт хийх технологи болон процессын судалгааг мөн стандартын дагуу үнэлж, эхлүүлэх эсэхээ шийдвэрлэдэг байх бодлого баримталж байна. Үнэт цаас гаргагчийн Бизнес хөгжил, инновацын газар нь сар бүр банк, санхүүгийн салбарт гарч буй технологийн дэвшлүүдийг судлан дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлт, дүгнэлт боловсруулдаг бөгөөд урт, дунд, богино хугацаанд гаргасан үйл ажиллагааны болон бизнесийн төлөвлөгөөнд нийцүүлэн нэмж оруулах, эсхүл цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан уг төлөвлөгөөг өөрчлөх арга хэмжээг авч ажилладаг.

| СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДЛЫН ШАЛГУУРУУД | | ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН БОЛОМЖИЙН ШАЛГУУРУУД | |
|---|---|---|---|
| БИЗНЕСИЙН ӨСӨЛТ | ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО | НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДАЛ | ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА |
| АШИГТ АЖИЛЛАГАА | ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЯЛГАРАЛТ | БИЗНЕС ПРОЦЕССЫН ТАНИЛ БАЙДАЛ | СИСТЕМ, ТЕХНОЛОГИЙН ТАНИЛ БАЙДАЛ |
| ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ | | НЭВТРҮҮЛЭЛТИЙГ УДИРДАХ БОЛОВСОН ХҮЧИН | |

#### 9.2.2. Аутсорсинг

Үнэт цаас гаргагч нь "Эй Ай Лаб" ХХК болон "Дижитал Воркс" ХХК-ийн хөгжүүлсэн бизнесийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой систем, программ хангамжийг ашигладаг ба жил бүр төлөвлөгөөний дагуу бизнес шаардлагаа гарган нэмэлт хөгжүүлэлт хийлгэж, туршиж, хүлээн авдаг. Мөн "Эй Ай Лаб" ХХК-тай хамтран зах зээлд тэсрэлт хийх технологи болон процессын судалгааг хийдэг.

СЗХ Он сар өдөр ХҮРГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21
"ИНВЕСКОР ББСБ" ХК InvesCore 6060854 УЛААНБААТАР ХОТ

## 9.3. Хамтын ажиллагаа

### 9.3.1. Хамтын ажиллагааны бодлого

Үнэт цаас гаргагч нь Бизнес харилцаа, хамтын ажиллагааны газраараа дамжуулан хамтран ажиллах гэрээт байгууллагуудтай харилцаагаа үргэлжлүүлэх, шинээр гэрээт байгууллагууд татах, борлуулалтын суваг нэмэх, ашигт ажиллагаа болон зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан хамтын ажиллагааг хөгжүүлэн авч явдаг. "Инвескор ББСБ" ХК нь зах зээл, харилцагчийн бүтцийг улирал бүр судалж бизнесийн онцлог, зах зээлийн боломжоо тодорхойлон, бүрэн ашиглах, харилцагчаа таних, борлуулалтын суваг нэмэх боломжийг тухай бүр үүсгэх ажиллагааг хийдэг бөгөөд эдгээр ажиллагааг хийж гүйцэтгэсний үндсэн дээр бизнесийн болон нийгмийн хамтын ажиллагааг бий болгон үргэлжлүүлэхэд өндөр ач холбогдол өгдөг.

Үнэт цаас гаргагч нь бүх боломжит хамтрагч байгууллагуудыг ижил шалгуураар дүгнэж, хамтын ажиллагааны харилцаа үүсгэх зорилгоор хамтран ажиллагч байгууллагуудад тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлсон байна. Тухайн шалгууруудаас жишээ дурдвал:

- ✓ Харилцаа, хамтын ажиллагаа нь өөрийн туршлагад тулгуурласан ил тод, шударга зарчимд суурилсан хамтран ажиллах бодлого баримталдаг байх;
- ✓ Сүүлийн 2 жилийн хугацаанд аливаа гэрээний үүрэг ноцтой зөрчсөн, эсвэл биелүүлээгүй зөрчил гаргаагүй байх.

Үнэт цаас гаргагч нь орон нутагт хэрэгжүүлж буй "Аллианс" хөтөлбөрт хамрагдах ББСБ-д дараах боломж, үр дүнг бий болгон, харилцан ашигтай хамтран ажиллах бодлоготой байна. Үүнд:

- ✓ Орон нутаг дахь жижиг ББСБ-аас бүрдсэн франчайзингийн сүлжээг бий болгох ба санхүүгийн зах зээлийг хамтдаа хөгжүүлэх;
- ✓ Үнэт цаас гаргагчийн арын албаны систем, финтек шийдлүүдийг өөрийн ББСБ-д нэвтрүүлэн ажиллах боломжийг олгон давуу тал үүсгэх;
- ✓ Үнэт цаас гаргагч нь тухайн аймгийн зөвхөн нэг ББСБ-ыг сонгон өөрийн системийн шийдэл, дотоод бодлого журмын зааварчилгааг өгч, хамтран ажиллах бөгөөд сонгогдсон ББСБ-д зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, бизнесийн цар хүрээгээ өргөжүүлэх боломжийг "Аллианс" хөтөлбөрөөрөө дамжуулан олгох ба "Инвескор ББСБ" ХК-ийн бизнесийн ноу-хау ба санхүүгийн тасралтгүй эх үүсвэр үүнд багтана.

Хөтөлбөрт тухайн орон нутагт үүсгэн байгуулагдсан, орон нутагтаа бүртгэлтэй, удирдлага нь хувь хүний болоод бизнесийн өндөр ёс зүйтэй, орон нутгийн зах зээлдээ тэргүүлэгч байх зорилготой, СЗХ-оос тавигддаг шаардлагыг хангасан ББСБ-уудыг хамруулдаг бөгөөд тус ББСБ-уудтай хамтын ажиллагаагаа өдөр өдрөөр тэлсээр байна. Мөн хөтөлбөрт хамрагдсан ББСБ-ууд нь Үнэт цаас гаргагчаас бизнес, санхүү, эрсдэл, үйлчилгээний стандарт, зах зээлийн судалгаа гэх мэт олон салбарт зөвлөгөө авч, өөрсдийн чадавхийг сайжруулан ажиллаж байна.

### 9.3.2. Хамтын ажиллагааны санамж бичгүүд

Үнэт цаас гаргагч нь бизнесийн болон нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа хамтран явуулах байгууллагуудтай хамтран ажиллах цар хүрээгээ тодорхойлж, бодит ажил хэрэг болгох зорилгоор санамж бичиг байгуулах замаар хамтын ажиллагаа хэрэгжүүлдэг. Жишээ дурдвал: Рио Тинтогийн сайн дурын сангийн эх үүсвэрээр бичил, жижиг, дунд бизнес болон хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсний зэрэгцээ тухайн бизнесүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, дэмжих зорилгоор "Хөгжлийн Шийдэл" ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан ба хөтөлбөрийн харилцагчдад зөвлөгөө үзүүлэн эргэх холбоотой ажиллаж байна.




Зураг 13. Хамтын ажиллагааны санамж бичиг



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21 БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР ББСБ" ХК УЛААНБААТАР ХОТ



Мөн дотоодын эрчимжсэн мал аж ахуйн зах зээл, үр шимийг дэмжих зорилготой "Олны Хүч" төслийн хэрэгжүүлэгчдийн нэг бөгөөд Монголын Сүүний Холбоо болон "Юнайтед Дэйри" ХХК-тай гурван талт хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулж, талуудын үйл ажиллагаа явуулах цар хүрээ, эрх үүргийг нарийн тодорхойлсон байна.

**Зураг 14.** Монголын Сүүний Холбоо болон "Юнайтед Дэйри" ХХК-тай гурвалсан хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан нь

## 9.4. Маркетинг

### 9.4.1. Маркетингийн бодлого

Үнэт цаас гаргагч нь 2022 онд салбаруудын брэндийн стандартыг шинэчлэн гаргаж, стандартын дагуу гадаад дотоод өнгө төрхийг шинэчлэх бодлого баримталж байна. Мөн хөрөнгө оруулагчид болон харилцагчдын сегментийг тодорхойлж, тухайн сегментэд тохирох маркетингийн стратеги төлөвлөн гаргаж, борлуулалтаа нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, мэдээлэл түгээх сувгуудыг нэмэгдүүлэн, хөгжүүлэх бодлоготой. Харилцагчийн сегментийн хувьд том бизнес, жижиг дунд бизнес, бизнес эрхлэгч иргэн, өндөр орлоготой иргэд, дундаж орлоготой иргэд гэсэн ангилалд хуваан ангилал бүрд тохирох үйлчилгээний мэдээллийг цаг алдалгүй тохиромжтой сувгаар нь таниулан, харилцагчаа халамжлах төлөвлөгөөтэй.

Үнэт цаас гаргагч нь финтек салбарт өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх стратегийг баримтлах бөгөөд уг зах зээлд тэргүүлэгч компаниудын нэгэн адил стандартын үйлчилгээг хэрэглэгчиддээ үзүүлэхээс гадна бусдаас ялгарах элемент, сурталчилгаа, мессеж, өнгө аясыг бүтээх, өрсөлдөгч компаниудаас өөр үйлчилгээг нэвтрүүлэх зорилготой болно.

Финтек салбарт баримтлах стратегийг амжилттай хэрэгжүүлснээр доорх үр дүнд хүрэхээр ажиллаж байна.

**График 30**. 2021 оны гэрээт харилцагчийн замнал




**График 31**. 2022 оны гэрээт харилцагчийн замнал




Үнэт цаас гаргагч нь хөндлөнгийн судалгаа хийлгүүлэх, судалгааны үр дүнд суурилсан урт болон дунд хугацааны маркетингийн стратегийн шилжилт, өөрчлөлт, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.

### 9.4.2. Олон нийтэд чиглэсэн маркетинг

Үнэт цаас гаргагч нь хүний эрх, нийгмийг хамгаалах тогтвортой хөгжлийн зорилтыг олон нийтэд чиглэсэн маркетингийн бодлогынхоо суурь болгон ажилладаг бөгөөд өөрийн сонгож, ивээн тэтгэж буй төслүүдийг иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, тэгш, хүртээмжтэй байдлыг дэмжихэд чиглэсэн байх шаардлага тавьдаг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2

"Инвескор ББСБ" ХК нь спорт, урлагийн арга хэмжээнүүдийн нийгэмд бий болгох нөлөөлөл, ач холбогдлыг боломжит хэмжээнд үнэлэн, эрэмбэлэх замаар ивээн тэтгэх, олон нийтэд хүргэж бодлого баримталдаг. Үүний нэг томоохон жишээ нь Үнэт цаас гаргагч 2021 онд болсон Токио-2020 зуны олимпын наадмын шууд дамжуулалтын алтан ивээн тэтгэгчээр ажилласнаар олон нийтийн спортын боловсролыг дэмжихэд хувь нэмрээ оруулахаас гадна олон улсад зохион байгуулагддаг хамгийн том арга хэмжээг цаг алдалгүй үзэж, Монголын тамирчдаа дэмжих боломжийг олгоход хувь нэмрээ оруулсан.

**Зураг 15.** Инвескор Санхүүгийн Групп Токио-2020 зуны Олимпын ивээн тэтгэгч




9

Олон нийтэд чиглэсэн, нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлэх, цаашид хэрэгжүүлэх төслийн нэг жишээ нь Монгол Улсын ховордсон амьтдын нэг болох минж үржүүлгийн сан бөгөөд уг зорилгын хүрээнд Покет аппликэйшний маскот болгон минжийг сонгосон болно. "Инвескор ББСБ" ХК нь уг төслийг цогц эко системийн хэмжээнд хэрэгжүүлэхээр зорьж буй ба ингэснээр минжний тоо толгойг нэмэгдүүлэхээс гадна гол мөрний ай савын экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, дэмжих үр дүнтэй юм.




**Зураг 16.** Покет аппликэйшний маскот Покет минж

### 9.4.3. Покет аппликэйшний маркетинг

Покет аппликэйшн нь бүх төрлийн сувгуудаар дамжуулан харилцагч нарт тогтмол мэдээлэл хүргэдэг. Түүнчлэн, мерчант байгууллагуудтай хамтарсан маркетинг хөтөлбөр хэрэгжүүлж хамтын ажиллагаа эрхэмлэдэг.

| | |
|---|---|
| +2,500,000 | Хэрэглэгчид мэдээлэл хүргэсэн |
| +100,000 | Хэрэглэгч рүү и-мэйл, мессеж |
| +200,000 | Секундын TV реклам |
| +800 | Онлайн сурталчилгаа |
| +30 | Хамтарсан маркетинг |

**Зураг 17.** Покет аппликэйшний гэрээт борлуулагчид болон агентуудын тархацын мэдээлэл

Харилцагчтай ойртох, гэрээ байгуулах процессыг хялбар болгох, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс Монгол Улсын 15 аймагт Покет зээлийн гэрээт борлуулагч нар буюу агентууд тогтмол ажиллаж байна.



"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ... 1119286063
УЛААНБААТАР ХОТ

## 9.5. Мэдээллийн аюулгүй байдал

### 9.5.1. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

Үнэт цаас гаргагч нь 2021 онд Мэдээллийн Аюулгүй Байдлын Удирдлагын Тогтолцоо (МАБУТ) ISO27001:13 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж буй бөгөөд стандартын батламжаа 2022 ондоо багтаан авахаар ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын хууль, зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагуудыг хангаж, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, дэвшилтэт технологи, автоматжуулалтад суурилсан санхүүгийн үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ хүлээлтээс давсан гүйцэтгэлд тэмүүлж ажиллах бодлогыг тодорхойлсон. Мөн хувьцаат компанийн хувьд шаардлагатай мэдээллүүдийн үнэн зөв, ил тод, нээлттэй хүртээмжтэй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ олон улсын шилдэг туршлагад суралцаж, Чанар болон Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулна.

Мэдээлэл болон мэдээллийн систем дэх олон төрлийн хандалтын тоо хэмжээ нь байгууллагын үйл ажиллагаа тэлэхийн хэрээр улам нэмэгддэг. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын зах зээл нь өндөр өсөлттэй зах зээлүүдийн нэг тул санаатай халдлага, аюул тулгарч, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл нэмэгдэж байна. Иймд "Инвескор ББСБ" ХК нь урт хугацаандаа зохистой, системтэй удирдах зорилгоор МАБУТ ISO27001:13 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн гүйцэтгэсэн байна.

Үнэт цаас гаргагч нь халдлага, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлд үйл ажиллагааны онцлогоос хамааруулан дараах болзошгүй тохиолдлуудыг сонгон тодорхойлж, удирдахаар зорин ажилладаг байна. Үүнд: техникийн гэмтэл гарах, хууль бусаар сүлжээнд нэвтрэх, кибер халдлага, нууц үгээ алдах, эвдэх, цахим шуудан, мессеж, вэб хуудсаар халдлагад өртөх, сүлжээ, зөөврийн хэрэгслийн вирус, хандах эрхийн зохицуулалт, хяналт хэрэгжихгүй байх гэх мэт эрсдэлүүд багтана.

МАБУТ нь байгууллагын удирдлагын тогтолцооны хэсэг бөгөөд эрсдэлийг үнэлэн мэдээллийн аюулгүй байдлыг бий болгох, хяналтыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, хянах, ажиглах, дүн шинжилгээ хийх, хэвшүүлэх болон сайжруулах үндсэн бүрдэл хэсгүүдтэй.

МАБУТ ISO27001:13 стандартыг амжилттай хэрэгжүүлэн, албажуулахын тулд Үнэт цаас гаргагч нь доорх багц журмыг батлуулан, хариуцагч талуудад таниулж, хэвшүүлсэн байна. Үүнд:

- Мэдээллийн аюулгүй байдлын журам;
- Хандах эрхийн удирдлагын журам;
- Системийн үйл ажиллагааны журам;
- Цахим харилцааны журам;
- Цэвэр ширээ, цэвэр дэлгэцийн заавар;
- Мэдээллийн аюулгүй байдлын тохиол, зөрчил удирдах журам;
- Зөөврийн төхөөрөмжийн ашиглаж журам;
- Зайнаас ажиллах журам;
- Биет орчны аюулгүй байдлын журам;
- Ханган нийлүүлэгчтэй ажиллах журмууд байна.

Үнэт цаас гаргагч нь мэдээллийн аюулгүй байдлын тохиол болон мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн талаар нарийвчилсан ойлголтуудыг ажилтнууддаа шат дараалалтай сургалт хийдэг ба мэдээллийн аюулгүй байдлын хяналт хэрэгжихгүй эсхүл үр дүнгүй байх, мэдээллийн өмчийн нууцлал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдал алдагдсан эсхүл алдагдах эрсдэл үүсэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор ажилтнууд санаатай болон санамсаргүй алдаа гаргах, мэдээллийн аюулгүй байдлын батлагдсан журмыг зөрчих, биет орчны аюулгүй байдал алдагдах, хяналтгүй эсхүл зөвшөөрөлгүй мэдээллийн системд өөрчлөлт оруулах, программ хангамж болон техник хангамжийн эвдрэл, гэмтэл, тасалдал үүсэх, хандах эрхтэй холбоотой зөрчил үүсэх зэргээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ цаг алдалгүй авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР ББСБ" ХК

### 9.5.2. Финтек системийн сайжруулалт, тасралтгүй ажиллагаа

Покет аппликэйшн болон холбоот системүүдийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах үүднээс олон улсын төлбөрийн системийн аюулгүй байдлын Payment Card Industry Data Security Standard буюу PCI DSS V3.2.1 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2022 стандарт нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр системийн найдвартай байдлаас гадна хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг бүх түвшинд хангах юм.

Түүнчлэн аппликэйшний хувьд хөгжүүлэлт, системийн сайжруулалтыг тогтмол хийж байгаа бөгөөд 2021 оны байдлаар App store дээр 62 удаагийн шинэчлэл /update/, Play Store дээр 84 удаагийн шинэчлэл хийсэн.


pocket — SISA

| | |
|---|---|
| Name of Company | Invescore Wallet NBFI LLC |
| Certificate Number | PCI/COC/ICW27021 |
| Address | 15th Floor, Twin Tower 1, Seoul Street, 2nd Khoroo, Sukhbaatar District, Ulaanbaatar, Mongolia - 14251 |
| Scope | Pocket Application |
| Type of Certification | PCI DSS v3.2.1 (Level 1 Service Provider) |
| Category | Service Provider |
| Certification Status | Active |

SISA PCI DSS Certified

Disclaimer

SISA Information Security makes no representation or warranty as to whether the validated or certified company systems are secure from either an internal or external attack or whether cardholder data is at risk of being compromised. SISA Information Security makes no representations or warranties on the business activities or operations of the said company. Please contact the company displaying the seal if you have questions about their products, services or customer support.

Copyright © 2003-2021 SISA. Ph +1 209 497 4504 info@sisainfosec.com

**Зураг 18.** PCI DSS стандартын батламж

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 10. Эрсдэлийн хүчин зүйлс ба Удирдлага

10.1. Эрсдэлийн хүчин зүйлс

10.2. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлого

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
Оны сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

# 10. Эрсдэлийн хүчин зүйлс ба Удирдлага

## 10.1. Эрсдэлийн хүчин зүйлс

### 10.1.1. Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн буюу системийн эрсдэл гэдэгт Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл дээрх томоохон хэмжээний өөрчлөлт, сөрөг өөрчлөлт болон үнийн хэлбэлзлээс эдийн засгийн үнэ цэнэ, орлогын хэмжээнд учирч болох алдагдлыг ойлгоно.

Зах зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Үнэт цаас гаргагч нь доорх алхмуудыг авч хэрэгжүүлнэ.

- ✓ Гадаад улс орнуудад шинэ зах зээл нээж, санхүүгийн экспорт хийх;
- ✓ Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл болон харилцагч нарын сегментийг төрөлжүүлэх;
- ✓ Эх үүсвэр татах арга хэрэгслүүдээ төрөлжүүлэх;
- ✓ Эдийн засаг болон улс төрийн нөхцөл байдлыг тогтмол ажиглаж, бодитой үнэлэлт дүгнэлт өгөх;
- ✓ Зах зээлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохицуулагч байгууллагууд болон мэргэжлийн холбоонуудтай хамтран ажиллах.

Зах зээлийн эрсдэлээс үүдэн гарч санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг гол эрсдэл нь хүүгийн болон ханшийн эрсдэл юм.

### 10.1.2. Хүүгийн эрсдэл

Хүүгийн эрсдэл нь санхүүгийн байгууллагын актив пассивын хүүгийн зохистой харьцаа алдагдсанаар байгууллагын ашигт ажиллагаа эсвэл зах зээлд эзлэх хувь хэмжээ буурах эрсдэл юм.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн удирдлага болон салбарын удирдлага хариуцсан нэгжүүд нь зээлийн болон итгэлцлийн бүтээгдэхүүний ерөнхий нөхцөлийг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулж шинэчлэх ба холбогдох өөрчлөлтийг батлах эрх бүхий хороонд танилцуулж батлуулна.

Инфляци болон дотоодын төгрөгийн ханшийн уналтаас сэргийлж бодлогын хүүг нэмэгдүүлэх нь банк бус санхүүгийн байгууллагын дундаж эх үүсврийн зардлыг өсгөх эрсдэлтэй. Уг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Үнэт цаас гаргагч нь дотоодын болон гадаадын санхүүгийн байгууллагуудаас татах эх үүсвэрээ аль болох урт хугацаатай татах мөн актив пассивын төлөгдөх хугацаагаар нь тааруулж аль болох бага зөрүү гаргахыг зорьж ажилладаг.

### 10.1.3. Ханшийн эрсдэл

Ханшийн эрсдэл гэдэг нь гадаад валютын актив, пассивын зөрүү болон худалдан авсан санхүүгийн хэрэгслийн ханшийн бууралтаас үүдэн санхүүгийн байгууллагад үүсэх эрсдэлийг хэлнэ.

Уг эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Үнэт цаас гаргагч нь гадаад валютын позиц, богино хугацаат хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө оруулалтуудын хувьд СЗХ-ноос тогтоосон бүх шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлын удирдлагад Актив, пассив эрсдэлийн удирдлагын хороо ажилладаг бөгөөд сар бүр хуралдан санхүүгийн үр дүн, гол харьцаа үзүүлэлтүүдийг хянаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай шийдвэрүүдийг гаргадаг.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

#### 10.1.4. Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэж санхүүгийн байгууллага харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гаргах нөхцөл байдал үүсэхийг хэлнэ.

Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах болон урьдчилан сэргийлэхийн тулд Үнэт цаас гаргагч нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Өөрийн хөрөнгө буюу эздийн өмчийг үе шаттайгаар нэмэгдүүлэх;
- ✓ Арилжааны банкны зээлийн шугам нээлгэх, тухай бүр сунгах;
- ✓ Урт хугацаат зээл болон бондын нийт эх үүсвэрт эзлэх хувийг нэмэгдүүлэх;
- ✓ Мөнгөн урсгалын төсөөллийг сар бүр шинэчилж харьцаа үзүүлэлтүүдийг таамаглах;
- ✓ Хөрвөх чадвар өндөртэй санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх санал гаргах;
- ✓ Болзошгүй хямралын үед хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөө боловсруулах буюу стресс тест хийх зэрэг байнгын хяналтын арга хэмжээнүүд байна.

#### 10.1.5. Зээлийн эрсдэл

Харилцагчид олгосон нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувь хэмжээ нэмэгдэх нь банк бус санхүүгийн байгууллагад учирдаг гол эрсдэл юм. Уг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор СЗХ-ны дүрэм, журам шаардлагын дагуу зээлийн эрсдэлийн санг тогтмол бүрэн байгуулж ажилладаг. Мөн жил бүрийн эцэст эрсдэлийн санг байгуулахдаа хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч олон улсын стандартад нийцсэн зах зээлийн хандлагын аргыг ашигладаг.

Зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга хэрэгсэл нь зээлийн судалгааны чанар, процессыг хамгийн өндөр түвшинд хүргэж харилцагчийн зээлээ эргэн төлөх чадварыг бодитоор үнэлж дүгнэх юм. Үнэт цаас гаргагчийн хувьд зээлийн барьцаа хөрөнгөөс илүү харилцагчийн зээлээ эргүүлэн төлөх чадамж буюу ирээдүйн орлого, мөнгөн урсгал дээр онцгой анхаарч шийдвэр гаргадаг тул нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээг санхүүгийн салбарын хэмжээнд хамгийн бага түвшинд байлгаж чадаж байна.

Мөн зээлийн судалгаанаас, зээл олголт хүртэлх бүхий л үйл ажиллагааг автоматжуулсан, төрийн байгууллагуудтай шууд холбогдож харилцагчийн мэдээллийг авдаг Смарт-ЛОС системийн тусламжтайгаар зээлийн процесс дэх хүний оролцоог багасгаж зээлийн эрсдэлийг бууруулж байна.
Уг систем нь хэрэглээний жижиг дүнтэй зээлүүд дээр автоматаар скоринг бодож зээлийн эрхийг тогтоодог нь харилцагч болон Үнэт цаас гаргагчийн цаг хугацаа, зардлыг хэмнэхээс гадна зээлийн эрх тогтоох процесст учрах хүний хүчин зүйл буюу гарч болзошгүй алдааг хамгийн бага түвшинд хүртэл бууруулж байна.

Үнэт цаас гаргагч нь зээл олгох үйл ажиллагааны чиглэлүүдийг зээлийн бодлогоороо нарийвчлан тодорхойлсон байдаг бөгөөд энэхүү бодлогыг нэн тэргүүнд баримтлах зарчим болгон зээлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Үнэт цаас гаргагч нь хууль бус үйл ажиллагааг ямар ч хэлбэрээр дэмждэггүй, санхүүжүүлдэггүй бөгөөд зээлийн хүсэлтэд анхан шатны шалгалт хийх явцад хууль бус үйл ажиллагаа эсвэл хууль бус үйл ажиллагаа явуулдаг гэсэн сэжиглэх үндэслэл бүхий үйл ажиллагааг хүлээн авахгүй, татгалздаг.

#### 10.1.6. Үйл ажиллагааны эрсдэл

Үнэт цаас гаргагч нь бизнесийн үйл ажиллагааг дэмжих, процессыг оновчтой зохион байгуулах, процессыг хөнгөвчлөх, үйл ажиллагааны уялдаа холбооны нийцлийг хангуулах, бизнесийн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, давхар болон дараалсан хяналт, мониторингийг оновчтой хэлбэрээр зохион байгуулж үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоогоо улам бэхжүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагааны эрсдэлийг бий болгодог үндсэн хүчин зүйлийн нэг болох дотоод процесс болон ажилтнаас шалтгаалсан эрсдэлийг бууруулахтай холбоотойгоор процесст суурилсан сэтгэлгээ, үйл явцыг бий болгох, ажилтнуудын мэдлэг чадамж, нөөцтэй холбоотой эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

### 10.1.7. КОВИД-19 холбоотой эрсдэл

Үнэт цаас гаргагч нь КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор шинээр батлагдсан хууль болон зохицуулагч байгууллагын гаргасан журам, зөвлөмжийг үйл ажиллагаандаа цаг алдалгүй хэрэгжүүлэн ажиллаж байгаагаас гадна компанийн сайн засаглал, манлайллын хүрээнд өөрийн дотоод шийдвэрүүдийг гарган харилцагч, зээлдэгч нарынхаа бизнесийн үйл ажиллагааг дэмжих, нөхцөл байдалд бодит дүн шинжилгээ хийх, байнгын эргэх холбоотой ажилласны зэрэгцээ зээлийн нөхцөл өөрчлөх, сунгахтай холбоотой процессуудыг цаг үед, нөхцөл байдалд тохируулан оновчтой арга замаар авч хэрэгжүүлснээр КОВИД-19 холбоотой эрсдэлийн хамгийн бага түвшинд барьж ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны тасалдалгүй байдал, ажилтнуудын эрүүл аюулгүй ажиллах нөхцөлийг хангах ажиллахтай холбоотойгоор КОВИД-19 үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг нөхцөл байдал бүрд тохирох хувилбар бүрээр урьдчилан боловсруулж, авах арга хэмжээг шат дараатай, уялдаа холбоотойгоор зохион байгуулан ажилласны зэрэгцээ нөхцөл байдлыг удирдах багийг томилж, багийн чиг үүрэг, авах арга хэмжээг тодорхойлж өгснөөр цаг алдалгүй хурдан шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, нөхцөл байдалд дасан зохицож, бизнесийн тасалдалгүй, ажлын байрны цомхотгол хийх болон ажилтнуудын ажлын байрны нөхцөлийг дордуулахгүйгээр, ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжин нөхцөл байдлыг даван тууллаа.

### 10.1.8. Хууль, эрх зүйн орчны эрсдэл

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа хуульд нийцүүлэх зорилгоор жил бүр хуулийн нийцлийн үнэлгээг гүйцэтгэж, хуулийн нийцлийг хангаж ажилладаг. ББСБ-ын үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомжид өөрчлөлт орох, шинээр хууль тогтоомж батлагдах зэргээр зохицуулалтын өөрчлөлт орсны улмаас үйл ажиллагаа тасалдах, дотоод дүрэм, журам болон процесс хууль тогтоомжид нийцэхгүй байх эрсдэл үүсэж боломжтой.

Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийг баталсан бөгөөд 2020 - 2024 оны хооронд хэрэгжүүлэхээр тусгажээ. Уг стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах, шинээр хуулийн төсөл өргөн барих ажлууд хийгдэхээр тусгагдсан байна. УИХ-ын 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн сайжруулахаар чиглэл өгсний дагуу Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, олон нийтээс санал авч байна.

Үнэт цаас гаргагчийн хувьд өөрийн үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомжийн төсөлтэй танилцаж, санал өгөх ажлыг тогтмол хийдэг мөн батлагдаж болзошгүй зохицуулалтуудад үйл ажиллагаагаа нийцүүлэх хуулийн нийцлийн тайланг урьдчилан гаргаж, шаардлагатай арга хэмжээг урьдчилан авч хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлдэг.

### 10.1.9. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

2021 онд банк бус санхүүгийн салбарт анх удаа ББСБ-ын үндсэн үйл ажиллагааг хамруулан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 27001:2013 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. Уг стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд ББСБ-ын мэдээллийн аюулгүй байдлыг хариуцах чиг үүрэг бүхий нэгж, ажилтныг томилох, мэдээллийн аюулгүй байдлын багц журмуудыг боловсруулж үйл ажиллагаанд нэвтрүүлэх, ББСБ-ын мэдээллийн өмчийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг хангах тогтолцоог бий болгох ажлууд хийгдээд байна.

Түүнчлэн, кибер болон биет орчны аюулгүй байдлыг хангахтай холбоотой хяналт, зохицуулалтын тогтолцоо бүхий заавар журмуудыг боловсруулаад байна. Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бий болгох нь харилцагчийн болон байгууллагын үнэ цэнэтэй мэдээллийн нууцлал, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, улмаар харилцагчийн сэтгэл ханамжийг өндөр байлгах, мэдээллийн аюулгүй байдлыг байгууллагын соёл болгоход чухал ач холбогдолтой.

### 10.1.10. Технологийн эрсдэл

Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэх болон бизнесийн үндсэн болон дэмжих үйл явцуудад үүсэх технологийн эрсдэлүүд буюу систем болон дотоод сүлжээний алдаа, доголдол, тасалдал, мэдээллийн болон кибер аюулгүй байдлын улмаас үүдэх эрсдэлийг Үнэт цаас гаргагчийн Мэдээллийн аюулгүй байдлын болон Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд эрсдэлд суурилсан хандлагад суурилан урьдчилан тодорхойлох, эрсдэлийн түвшнийг үнэлэх, бууруулах арга замаар удирдан ажилладаг. Мэдээллийн технологийн үйл ажиллагааны тасалдалгүй байдлыг хангахад чиглэн Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөг боловсруулан үйл ажиллагаандаа дагаж мөрддөг.

### 10.1.11. Хүний нөөцийн эрсдэл

Хүний нөөцийн эрсдэл нь ажилтан, байгууллын соёл, засаглал зэрэг хүчин зүйлээс хамааран бизнесийн орчинд тодорхой бус байдал үүсгэн, компанийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх эрсдэлтэй гэж тодорхойлов. Аливаа компанийн үйл ажиллагаанд дараах төрлийн хүний нөөцийн эрсдэлүүд учрах магадлалтай. Үүнд:

- ✓ Чанаргүй хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт;
- ✓ Мэдээллийн урсгал буруу, эсвэл дутагдалтай;
- ✓ Ёс зүйн зөрчил, доголдол;
- ✓ Ажилтнуудын эргэц хэт өндөр байх;
- ✓ Чадваргүй удирдлагын арга барил;
- ✓ Ур чадварын дутагдал, сургалт хөгжлийн доголдол.

Үнэт цаас гаргагч нь чанаргүй хүний нөөцийн бүрдүүлэлт, мэдээллийн урсгал буруу эсхүл дутагдалтай, ёс зүйн доголдол өндөр, хүний нөөцийн эргэц хэт өндөр байх зэрэг эрсдэлүүдийг бууруулах, урьдчилан сэргийлэхээр компанийн хэмжээнд дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Хүний нөөцийн бүрдүүлэлтийн сувгийг өргөжүүлэх, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох тест авах, өмнөх ажлын байрны тодорхойлолт авах;
- ✓ Дотоод мэдээллийн интранет сайтыг хөгжүүлэн, нэвтрүүлэх;
- ✓ Шүгэл үлээх журмыг таниулан, сургалт хийх, ажилтнуудад тодорхой давтамжтай танилцуулах;
- ✓ Цалин, урамшууллыг гүйцэтгэлд тулгуурлан нэмэгдүүлэн тогтоох, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, сургалт хөгжил зохион байгуулах;
- ✓ Удирдлагын үнэлгээ хийж, танилцуулах;
- ✓ Сургалт хөгжлийн төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, ур чадварын үнэлгээг хийж, сургалт хөгжлийн хэрэгцээг тодорхойлох хөтөлбөрүүд байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

### 10.1.12. Нийлүүлэгчдийн эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, материалын ханган нийлүүлэлтийн үйл явцад тасалдал гарах, гүйцэтгэл хангалтгүй байх, улмаар харилцагчдадаа өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой хүргэх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг удирдах, бууруулах хэрэгцээ шаардлага үүсдэг. Энэхүү шаардлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд ханган нийлүүлэгчидтэй харилцах харилцааг тодорхойлох, нийлүүлэлтийн тасалдал, гүйцэтгэлд хяналт, үнэлгээ хийх, ханган нийлүүлэгчдэд тавигдах шаардлагуудыг тодорхойлох гэх мэт асуудлуудыг зохицуулах дотоод журмуудыг боловсруулан батлуулж үйл ажиллагаандаа дагаж мөрдөн ажиллаж байна.

### 10.1.13. Нэр хүндийн эрсдэл

Үнэт цаас гаргагчийн ажилтан бүр Бизнесийн болон ажилтны ёс зүйн дүрэм болон харилцагчийн үйлчилгээний нэгдсэн стандартыг мөрдөн ажилладаг бөгөөд байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээ, ажилтнуудын харилцаа, хандлагаас үүдэн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болохуйц аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Гүйцэтгэх удирдлага болон салбар, нэгжийн удирдлагууд нь ажилтнууддаа ББСБ-ын нэр хүнд, үнэ цэний талаарх ойлголт мэдээллийг өгөх, сургалт, таниулах ажлуудыг тогтмол хийдэг бөгөөд ажилтан бүр байгууллагын бизнес, үйл ажиллагаа, нэр хүндэд халдсан эсвэл учирч болзошгүй аюул занал байгааг илрүүлсэн, мэдсэн даруй өөрийн удирдлагад эсвэл Хууль, Эрсдэлийн удирдлагын газар болон Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх үүргээ хэрэгжүүлж, тухайн эрсдэлээс сэргийлж, бууруулах ач холбогдлыг ойлгон ажилладаг.

### 10.1.14. Давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл

ББСБ-ын үйл ажиллагаанд улс төрийн тогтворгүй байдал, жагсаал цуглаан дайн, газар хөдлөлт, байгалийн гамшигт үзэгдлээс болж үйл ажиллагаа, эрчим хүч, интернэт доголдох зэрэг эрсдэлийн нөлөөлөл маш өндөр боловч магадлалын хувьд бага байна. Гэсэн хэдий ч "Бизнесийн тасралтгүй ажиллагаа"-ны төлөвлөгөөгөөр учирч болзошгүй эдгээр эрсдэлүүдийг үнэлж, эрсдэлийн түвшинд тулгуурлан авах арга хэмжээ, оролцогчдын чиг үүргийг тодорхойлсон байдаг ба энэхүү төлөвлөгөөг нийт ажилтнуудад таниулан, сургалт мэдээллээр тогтмол хангадаг.

### 10.1.15. Хувьцааны үнийн эрсдэл

Аливаа нээлттэй хувьцаат компанийн хувьцааны зах зээлийн үнэ буюу хөрөнгийн бирж дээрх ханш буурах нь тухайн компанидаа санхүүгийн шууд нөлөө үзүүлэхгүй ч гэсэн зах зээлийн үнэлгээг бууруулж хувьцаа эзэмшигчдийн шаардах өгөөж нэмэгдэж байгааг илтгэх дохио болдог. Мөн зах зээлийн үнэ нь хувьцааны бодит үнэ цэнээс хэт өндөр байх нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийг нэмэгдүүлдэг. Үнэт цаас гаргагчийн хувьд нээлттэй хувьцаат компанийн хууль, журмаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнгүүдээ олон нийтэд ил, тод үнэн зөв, цаг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. Мөн өөрийн вэбсайт болон олон нийтийн сүлжээ хуудсаар Үнэт цаас гаргагчийн талаарх мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэж, хөрөнгө оруулагч нартайгаа байнгын эргэх холбоотой ажилласнаар хувьцааны зах зээлийн ханшийн эрсдэлийг тодорхой хэмжээгээр бууруулж байна. Мөн Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны дийлэнх хэсгийг толгой компани болон стратегийн хөрөнгө оруулагч нар эзэмшиж байгаа тул хувьцааны ханшид учирч болзошгүй гэнэтийн шок нөлөөг бууруулж, цаашид хувьцааны ханш тогтвортой өсөх суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

## 10.2. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлого

### 10.2.1. Эрсдэлийн удирдлага

"Инвескор ББСБ" ХК нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгон өдөр тутмын үйл ажиллагаандаа идэвхтэй хэрэгжүүлж ажилладаг. Хамгаалалтын 3 бүсийн зарчимд суурилан эрсдэлээ удирдах нь аливаа байгууллага эрсдэлийг үр дүнтэй удирдах, хяналт, хариуцлагын тогтолцоог урт хугацаанд тогтвортой бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг. Түүнчлэн, "Инвескор ББСБ" ХК нь өөрийн үйл ажиллагаанд хамаарал бүхий хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн бодлого, журмуудаа шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

СЗХ
Он сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02



**Схем 6.** Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тухай

**ТУЗ**

**Гүйцэтгэх удирдлага**

**Хамгаалалтын I бүс**

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, бууруулах, удирдах чиг үүрэгтэй байна.

**Эрсдэлийг хариуцах**

**Хамгаалалтын II бүс**

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, бодлого журам боловсруулах, шинэчлэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм, хэмжээг хянах чиг үүрэгтэй, Хамгаалалтын I бүсэд эрсдэлийг үр дүнтэй удирдахад зөвлөмж чиглүүлэг өгөх чиг үүрэгтэй.

**Эрсдэлийг хянах**

**Хамгаалалтын III бүс**

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт дүгнэлт өгөх чиг үүрэгтэй байна.

**Хараат бус баталгаажуулалт**

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны гол зорилго нь эрсдэлийн төрөл тус бүрээр хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тодорхойлох, үр дүнтэй, үр ашигтай удирдах бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүн, хэрэгжилтийг ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд улирал бүр, Гүйцэтгэх Удирдлагын хороонд сар бүр тайлагнан ажиллаж байна.

### 10.2.2. Эрсдэлийн соёл

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд эрсдэлийн соёлын бат бөх үндэс суурийг тавих, тасралтгүй сайжруулах, бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой байдаг. "Инвескор ББСБ" ХК нь Гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтнууд дунд эрсдэлийн соёлыг бэхжүүлэх зорилго бүхий "Эрсдэлийн соёл"-ыг түгээх аян болон шат дараалсан сургалтууд жил бүр зохион байгуулах, ажилтан бүр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг эрсдэлийн менежер байх соёлыг түгээн ажиллаж байна.

"Инвескор ББСБ" ХК-ийн эрсдэлийн удирдлагын засаглал нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

**Схем 7.** Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын засаглалын тухай

**ТУЗ**

**Хамгаалалтын 3 бүс**

Эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа

**Засаглалын бичиг баримтууд**

Эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох эрсдэлүүдийг удирдах ерөнхий журмууд болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журам, стандарт болон заавар

**Засаглалын хороод**

ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих хороод

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119200063
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч нь Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогоо ТУЗ-өөр батлуулан мөрдөн ажилладаг. Энэхүү бодлогоор ББСБ-ын хувьд удирдах боломжтой эрсдэлийн төрлүүдийг тодорхойлсон бөгөөд тэдгээрийг хариуцах эзэн болон холбогдох бодлого журмуудыг тодорхой заасан байдаг. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд суурилсан байдаг бөгөөд хамгаалалтын бүсүүд дараах чиг үүрэгтэй байдаг. Үүнд:

- Эрсдэлийн эзэн буюу эрсдэлийг илрүүлэх, тайлагнах, бууруулах, залруулах болон урьдчилан сэргийлж ажиллах чиг үүрэг бүхий хамгаалалтын нэгдүгээр бүс;
- Эрсдэлийг удирдах тогтолцоог ажиллуулах, эрсдэлийг бодлого журмын засаглалын дагуу удирдах, байгууллагын хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тогтоох, түүний хэрэгжилтийг хангуулах, мониторинг хийх, хяналтын тогтолцооны үр дүнтэй байдлыг хангуулах чиг үүрэг бүхий хууль, эрсдэл, мониторингийн чиг үүргийг хариуцдаг хамгаалалтын хоёрдугаар бүс;
- Хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүсийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдлыг хараат бусаар үнэлж, баталгаажуулалт хийх чиг үүрэг бүхий Дотоод аудитын газар буюу хамгаалалтын гуравдугаар бүс.

Хамгаалалтын гурван бүсийн тогтолцоо үр дүнтэй хэрэгжиж байгаа байдлыг дараах байдлаар хэмждэг. Үүнд:

- Эрсдэлийн холбогдох журмуудын хэрэгжилтийн үнэлгээг жил бүр хийж, түүний үр дүнд тулгуурлан холбогдох өөрчлөлтийг оруулах, батлуулах, таниулах, хэрэгжилтийг хангуулсан байдал;
- Байгууллагад эрсдэлийн соёл бий болсон буюу ажилтан бүр эрсдэлийг бууруулах, мэдээлэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг ойлголттой эсэх, түүнийгээ хэрэгжүүлдэг эсэхэд мониторинг хийх, сургалт мэдээллээр тогтмол хангаж байгаа эсэх;
- Эрсдэлийн тайлан болон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний үзүүлэлтүүдийн хэрэгжилт болон байгууллагын эрсдэлийн төлөв байдлын талаар сар бүр тайлагнах процесс буюу эрсдэлийн удирдлагатай холбоотой асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргах Актив Пассив, Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа.

### 10.2.3. Журмын жагсаалт, тайлбар

***1. Эрсдэлийн удирдлагын бодлого*** – Хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлан эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллах, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, засаглал, хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, эрсдэлийн тайлагналт болон Үнэт цаас гаргагчийн удирдах эрсдэлийн төрлүүдийг тодорхойлсон.

***2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого болон дотоод хяналтын хөтөлбөр*** – Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагаанд баримтлах бодлого, зарчмыг тодорхойлсон.

***3. Зээлийн эрсдэлийн ерөнхий журам*** – Зээлийн эрсдэлийг удирдахад баримтлах зарчим, хамгаалалтын бүсүүдийн чиг үүрэг, зээлийн багцын удирдлага, зээл хүсэгч болон барьцаа хөрөнгийн шаардлага, зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн нөхцөлүүд, зээл шийдвэрлэх эрх хэмжээ болон зээлийн хяналттай холбоотой харилцааг зохицуулсан.

***4. Үйл ажиллагааны эрсдэлийн журам болон процессын эрсдэлийн үнэлгээний журам*** – хамгаалалтын гурван бүсийн чиг үүрэгт тулгуурлан үйл ажиллагааны эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд удирдах тогтолцоо болон процессын эрсдэлийн үнэлэх, хяналтын орчныг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулсан.

***5. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын журам*** – Үнэт цаас гаргагчийн санхүүгийн эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, хяналт тавих, бууруулах, урьдчилан сэргийлэх замаар санхүүгийн эрсдэлүүдийг зохистой түвшинд удирдахтай холбоотой харилцааг зохицуулсан.

***6. Шүгэл үлээх журам*** – Шүгэл үлээх үйл ажиллагаа, баримтлах зарчим, шүгэл үлээх процесс, зөрчил шалган шийдвэрлэх, шүгэл үлээгчийн мэдээллийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан.

***7. Хөрөнгө завших, залилангийн эсрэг журам –*** Хөрөнгө завших, залилангийн шинжтэй үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хамгаалалтын бүсүүдийн чиг үүрэг болон тэдгээр үйлдлийг илрүүлэх, мэдээлэх, шалгах, арга хэмжээ авахтай холбоотой харилцааг зохицуулна.

***8. Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөө –*** Үнэт цаас гаргагчийн бизнесийн тасралтгүй байдалд хохирол учруулж болзошгүй аюулыг бууруулах, эрсдэлийн удирдах, аюултай байдалд бэлтгэх, түүнээс богино хугацаанд зайлсхийх, онцгой байдал үүссэн үед үр дүнтэй шуурхай хариу үзүүлэх, үйл ажиллагааг хурдан хугацаанд буцаан сэргээх зэрэг бизнесийн тасралтгүй байдлыг хангаж удирдахтай холбоотой үндсэн төлөвлөгөө.

***9. Эрх зүйн баримт бичгийн удирдлагын журам –*** Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг байнга, тогтвортой зохицуулах байгууллагын хэмжээнд мөрдөгдөх бодлого журамтай холбоотой үйл ажиллагаа, эрсдэлийн бодлого журмуудын хэрэгжилтийн үнэлгээг хийх чиг процессыг тодорхойлсон.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР БОНД 2.

# 11. Байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглалын тогтвортой хөгжлийн бодлого

11.1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх тухайд баримтлах бодлого

11.2. Нийгмийн хариуцлага болон тогтвортой санхүүжилтын тухайд баримтлах бодлого

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ... 1119286
УЛААНБААТАР ХОТ

# 11. Байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглалын тогтвортой хөгжлийн бодлого

Хүснэгт 7. Үнэт цаас гаргагчийн байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглалын тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн онцлох үйл явдлууд

| ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ | ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮЖИЛТ | БАЙГАЛЬ, НИЙГЭМД ЭЭЛТЭЙ |
|---|---|---|
| Монгол Улсын тогтвортой санхүүжилтын 8 зарчмыг баримтлан ажиллаж байна. | Зээлдэгчдийн санхүүгийн хүртээмж, мэдлэг боловсролыг байнга нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна. | 2021 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 17.5% нь ногоон зээл байна. |
| КОВИД-19 халдварын үед бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн олгож 300 гаруй ажлын байр хадгалахад нөлөөлсөн. | Орон нутгийн ББСБ-уудыг тогтвортой хөгжил зорьж, зээлдэгчдийн санхүүгийн боловсрол болон хүртээмжийг нэмэгдүүлэхийг дэмжих хөтөлбөр санаачлан хэрэгжүүлж байна. | Покет аппликейшний маскот Төв Азийн минж хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлж байна. |
| КОВИД-19 халдварын үед:<br>✓ Хугацаа хэтэрсэн зээлийн нэмэгдүүлсэн хүүг зогсоосон.<br>✓ Зээл олголтыг нэг өдөр ч зогсоолгүй ажилласан.<br>✓ Покет аппликэйшнээр авсан зээлээ хэдэн ч удаа сунгах боломжтой болгож, системийн өөрчлөлт хийсэн. | 2018 оноод "SMB Сэмбий" хөтөлбөр хэрэгжүүлэн бизнесийн харилцагчдад зориулсан үнэ төлбөргүй сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлж байна. | Покет аппликэйшнээр зээлийг цахимжуулснаар:<br>✓ 12 тонн цаас хэмнэсэн.<br>✓ 31,250 хүн/өдөр хэмнэсэн.<br>✓ Нэмэлт замын түгжрэл үүсгэхгүй байх, агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй байх зэрэг эерэг нөлөөллүүдийг үзүүлэн ажиллаж байна. |
| Байгаль орчин, нийгэм ба засаглалын эрсдэлийг өндөр дүнтэй зээлийн судалгаанд заавал багтаан үнэлдэг байхаар үнэлгээний аргачлалыг боловсруулж байна. | | 2022 онд "Тэнцвэр" аяныг өрнүүлж, экологийн тэнцвэрийг хадгалах, санхүүгийн тэнцвэрийг хангах, эрүүл мэндийн тэнцвэрийг хадгалах гэх мэт байгаль экологи болоод хэрэглэгчийн амьдралд ээлтэй цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.<br>2030 он хүртэл 1 сая мод тарьж ургуулах төлөвлөгөөтэй. |

## 11.1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх тухайд баримтлах бодлого

Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор ус, цахилгаан, цаас, шатах тослох материалын хэрэглээг багасгах арга хэрэгсэл, бүтээгдэхүүнийг сонгон ашиглаж байна. Түүнчлэн 2030 он гэхэд хүлэмжийн хийг дорвитой бууруулж, шингээх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан 1 тэрбум мод тарьж ургуулан, арчлах амлалтыг дэмжин 1 сая мод тарьж ургуулан, арчлах амлалт өгсөн байна. Хувийн хэвшлийн компаниудаас Монгол Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамнаас батламж гардан авсан анхдагчдын нэг болсон.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 21
БҮРТГЭВ-02

Зураг 19. Ногоон санхүүжилт бүс нутгийн чуулган, 2022 он



## 11.2. Нийгмийн хариуцлага болон тогтвортой санхүүжилтын тухайд баримтлах бодлого

Үнэт цаас гаргагч нь "Байгаль орчин нийгмийн хариуцлагын хүрээнд баримтлах зарчим"-ыг тодорхойлсноор Тогтвортой санхүүжилт олгох эх үүсвэр бий болгох, тухайн эх үүсвэрээр хүртээмжтэй санхүүжилтыг хэрэгжүүлэх бодлого баримталж байна. Хүртээмжтэй санхүүжилтыг бий болгох бодлогын хүрээнд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудад "Инвескор ББСБ" ХК-ийн технологийн шийдэл болон ноу-хау-г санал болгон "Аллианс" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь технологид суурилсан санхүүгийн хүртээмжийн чанар, агуулгыг дэмжих нэгэн сонирхолтой шийдэл болсон байна.

Тогтвортой санхүүжилтын эх үүсвэр бий болгож хүртээмжтэй санхүүжилтыг олгосон хамгийн эхний бөгөөд томоохон жишээ нь КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес болон хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хамтын ажиллагааны гэрээнд "Рио Тинто Монгол" ХХК-ийн Монгол дахь Үйл ажиллагаа хариуцсан захирал Х.Амаржаргал, "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нар гарын үсэг зуржээ.

Зураг 20. Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхээр "Рио Тинто Монгол" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Х.Амаржаргал, "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нар Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан нь



"Рио Тинто Монгол" ХХК-ийн сайн дурын сангаас 2.9 тэрбум буюу 1 сая ам.долларын эх үүсвэрээр бичил, жижиг, дунд бизнес болон хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба Үнэт цаас гаргагч нь 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн Покет зээлийн аппликейшнээр дамжуулан зорилтот бүлгийн зээлийн хүсэлтүүдийг хүлээн авч 2021 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хөтөлбөрийн санхүүжилтыг олгосон байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт ААН-ийн 70 гаруй хувь нь жижиг, дунд бизнес эрхлэгчид байгаа *(Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо)* бөгөөд цар тахлын нөлөөлөлд өртөж үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон бизнесийг дэмжих, ажлын байрыг хадгалах боломжийг бүрдүүлэхэд энэ хөтөлбөр чиглэсэн. Түүнчлэн эмэгтэй бизнес

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

эрхлэгчид болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийг энэхүү хөтөлбөрт хамруулж эдийн засгийн удаашралтай үед санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьсон. Энэхүү зээл нь жилийн 4.8 хувийн хүүтэй бөгөөд зээлийн дээд хязгаар нь 30 сая төгрөг байгаа нь ердийн үеийн санхүүжилт, бусад ижил төстэй зээлийн бүтээгдэхүүнүүдтэй харьцуулахад зээлдэгчдийн хувьд бага өртөгтэй нөхцөл юм. Төсөл хэрэгжсэнээр бид доорх үр дүнг бий болгосон:

**91+**
Батлагдсан зээлийн тоо

**600+**
Нөлөөлөл үзүүлсэн хүний тоо

**300+**
Ажлын байр хадгалсан

**График 32.** Хөнгөлттэй зээлд хамрагдсан зорилтот бүлгүүдийн бүтэц болон нийт хөтөлбөрийн багцад эзлэх хувь

| 55% | 49% | 8% | 2% | 2% |
|---|---|---|---|---|
| Импортыг орлох бүтээгдэхүүн үйлчилгээ | Эмэгтэй бизнес эрхлэгч | Хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч | Байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч | Өрх толгойлсон эцэг/эхийн бизнес |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 12. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, шинжилгээ

12.1. Үйл ажиллагаанд онцлох нөлөө бүхий хүчин зүйлс

12.2. Нягтлан бодох бүртгэлийн стандарт баримтлал

12.3. Орлого үр дүнгийн тайлан

12.4. Санхүү байдлын тайлан

12.5. Мөнгөн гүйлгээний тайлан

12.6. Ногдол ашгийн бодлого

12.7. Аудитлагдсан тайлангийн тухай

12.8. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тогтвортой, зохистой байдал

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
Үнэт цаас гаргагч
6060854 ☎ 11192860003
УЛААНБААТАР ХОТ

# 12. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, шинжилгээ

## 12.1. Үйл ажиллагаанд онцлох нөлөө бүхий хүчин зүйлс

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөө бүхий хүчин зүйлст эдийн засгийн өсөлт, салбарын өсөлт, зээлийн багц буюу нийт активын өсөлт, түүнтэй уялдсан эх үүсвэр, капиталын бүтэц, хүүгийн орлого, зарлага зэрэг багтана.

## 12.2. Нягтлан бодох бүртгэлийн стандарт баримтлал

Үнэт цаас гаргагчийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, тайлант оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) болон СТОУС 10-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй ба нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан СТОУС болон СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дагуу бэлтгэсэн байна. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөх;
- ✓ Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;
- ✓ Нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэх;
- ✓ Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулах.

## 12.3. Орлого үр дүнгийн тайлан

**Хүснэгт 8.** Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн орлогын тайлан, 2019 – 2021, мянган төгрөгөөр

| "ИНВЕСКОР ББСБ" ХК (нэгтгэсэн) | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 19,362,985 | 29,147,505 | 41,122,071 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | 4,192,760 | 6,755,193 | 12,814,237 |
| *Бусад хүүгийн зардал* | 2,107,869 | 2,649,860 | 5,336,908 |
| *Итгэлцлийн үйл ажиллагааны зардал* | 2,084,891 | 4,105,333 | 7,477,329 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | 56,963 | 1,297,947 | 743,455 |
| Хүүгийн цэвэр орлого | 15,113,262 | 21,094,365 | 27,564,379 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 2,600,157 | 450,277 | 8,886,652 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (зардал) | 159,154 | 86,738 | (157,173) |
| Нийт хүүгийн бус цэвэр орлого | 2,759,311 | 537,015 | 8,729,479 |
| Нийт үйл ажиллагааны орлого | 17,872,573 | 21,631,380 | 36,293,858 |
| Ажиллагсадтай холбогдолтой зардал | 3,000,568 | 3,170,017 | 5,672,623 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 3,664,400 | 4,116,052 | 6,542,508 |
| Нийт үйл ажиллагааны зардал | 6,664,968 | 7,286,069 | 12,215,131 |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) | 16,463 | (440,215) | (368,409) |
| **Татварын өмнөх ашиг** | **11,224,068** | **13,905,096** | **23,710,318** |
| Орлогын албан татвар | 2,548,913 | 2,285,987 | 4,518,782 |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | **8,675,155** | **11,619,109** | **19,191,536** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | (55,928) | (165,585) |
| Нийт дэлгэрэнгүй орлого | - | 11,563,181 | 19,025,951 |

"ИНВЕСКОР ББСБ" ХК
6060854 УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21 БҮРТГЭВ-02
СЗХ

### 12.3.1. Онцлох харьцаа үзүүлэлтүүд

**Хүснэгт 9.** Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, 2019 – 2021, хувиар

| | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Зардал орлогын харьцаа (ҮАЗ/ҮАЦО) | 38% | 32% | 33% |
| Цэвэр хүүгийн орлогын маржин | 68% | 71% | 55% |
| Үйл ажиллагааны ашгийн маржин | 81% | 73% | 73% |
| Цэвэр ашгийн маржин | 39% | 39% | 38% |

**График 33.** Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, 2019 - 2021, хувиар




Сүүлийн 3 жилийн тайлант хугацааны дүнгээс үзэхэд нийт зээлийн түвшин хурдацтай өссөн ч Үнэт цаас гаргагч зээлийн багцаа үр дүнтэй удирдаж, цэвэр ашгийн маржинг салбарын түвшинд буюу дунджаар жилийн 39%-д хүргэн ажиллаж байгаа нь чадварлаг мэргэжилтнүүд салбарын өсөлтийг бодитой тооцоолон компанийн өсөлтөө уялдуулж төлөвлөлт, удирдлагаа алдаагүй хийж байгаагаар тайлбарлаж болно. 2021 онд салбарын дундаж үйл ажиллагааны ашгийн маржин 55% байсан бол Үнэт цаас гаргагчийн маржин даруй 18 хувиар өндөр байгаа нь финтек салбарт хүчтэй өрсөлдөгч болж, хүүгийн бус орлогоо нэмэгдүүлснээр тайлбарлагдаж байна. Финтек зээлийн салбар дахь зах зээлийн хувиа нэмэгдүүлэх боломж байгаа нь үйл ажиллагааны маржингийн түвшин хадгалагдах боломжтойг илтгэж байна.

**График 34.** Үнэт цаас гаргагчийн болон МХБ-д бүртгэлтэй ББСБ-уудын ашигт ажиллагааны харьцуулалт, 2019 - 2021, хувиар




**Эх сурвалж:** Монголын Хөрөнгийн Бирж, Хувьцаат компанийн санхүүгийн тайлан

Цэвэр ашгийн маржин өндөр байгаа нь өрийн санхүүжилтын эх үүсвэрийн зардлыг зохистой түвшинд хадгалж байгааг мөн харуулж байна. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн маржин МХБ-д бүртгэлтэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй компаниудын үзүүлэлтээр төлөөлүүлсэн салбарын дунджаас тогтмол өндөр бөгөөд тогтвортой байна.

Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн өгөөжийн харьцаа, 2019 - 2021, хувиар

| | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Активын өгөөж (ROA) | 10.6% | 8.5% | 9.0% |
| Эздийн өмчийн өгөөж (ROE) | 21.5% | 22.0% | 25.4% |
| Чанаргүй зээлийн хувь | 2.6% | 3.0% | 2.7% |

График 35. Үнэт цаас гаргагчийн активын болон эздийн өмчийн өгөөжийн харьцаа, 2019 – 2021, хувиар




График 36. Үнэт цаас гаргагчийн болон бусад ББСБ-уудын эздийн өмчийн өгөөжийн харьцуулалт, 2019 - 2021, хувиар




Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн өгөөжийн харьцаа үзүүлэлтүүд салбарын үзүүлэлтээс өндөр байгаа нь хөрөнгийн үр өгөөжтэй ашиглалт, үйл ажиллагааны үр ашигт байдлаар тайлбарлагдаж байна. Тухайлбал 2021 онд Үнэт цаас гаргагчийн нийт активын өгөөж нь салбарын дундаж болох 7.7%-иас даруй 1.3 нэгжээр өндөр байгаа нь зах зээлд тэргүүлэгчийн хувьд эх үүсвэрээ маш үр дүнтэй удирдаж, зээл олголтын оновчтой байдал болон эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлснийг илэрхийлнэ. Нийт эздийн өмчийн өгөөж 25.4% буюу салбарын дунджаас 2.17 дахин их байгаа нь үйл ажиллагааны чанар болон өр төлбөрийн сайн удирдлагыг хэрэгжүүлж байгааг илтгэж байна. (Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн танилцуулга)

Хүснэгт 11. Дью Понтын шинжилгээ, 2019 - 2021

| Dupont шинжилгээ | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Эздийн өмчийн өгөөж (ROE) | 21.5% | 22.0% | 25.4% |
| Цэвэр ашгийн маржин | 39% | 39% | 38% |
| Нийт хөрөнгийн эргэц | 0.27 | 0.22 | 0.23 |
| Санхүүгийн хөшүүрэг | 2.03 | 2.58 | 2.81 |

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн аудитлагдсан тайланд Дью Понтын шинжилгээ гүйцэтгэхэд өмнө дурдсанчлан эздийн өмчийн өгөөж нь 2021 онд СЗХ-с тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ салбарын дунджаас 2.17 дахин, МХБ-д бүртгэлтэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй компаниудын үзүүлэлтээр төлөөлүүлсэн салбарын дунджаас 43%-иар өндөр байгаад цэвэр ашгийн маржинг тогтвортой сайн түвшинд барьж ажилласан нь нөлөөлсөн байна. Мөн эздийн өмчийн өгөөжийн өндөр өсөлтийг сүүлийн 3 жилд санхүүгийн хөшүүрэг нэмэгдсэнээр тайлбарлаж болох ба ийнхүү өрийн санхүүжилтын эх үүсвэр хурдтай нэмэгдсэн нь дотоод, гадаадын байгууллагаас эрсдэлийн шалгуурыг тогтмол хангаж, санхүүгийн хөшүүргийг зохистой ашиглаж ажилласныг харуулж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21 БҮРТГЭВ-02
СЗХ 2022 он 11 сар 09 өдөр
"ИНВЕСКОР ББСБ" ХК InvesCore УЛААНБААТАР ХОТ

## 12.4. Санхүү байдлын тайлан

Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүү байдлын тайлан, 2019 - 2021, мянган төгрөгөөр, нийт хөрөнгөд эзлэх хувиар

| **"Инвескор ББСБ" ХК** (нэгтгэсэн) | 2019 | 2020 | 2021 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 5,146,145 | 26,588,675 | 24,638,751 | 6.3% | 19.5% | 11.6% |
| Хөрөнгө оруулалт | 3,599,750 | 591,122 | 183,583 | 4.4% | 0.4% | 0.1% |
| **Харилцагчдад олгосон зээл-цэвэр** | **62,307,875** | **96,409,802** | **175,508,816** | **76.1%** | **70.9%** | **82.7%** |
| *Нийт зээл* | *61,950,468* | *95,290,686* | *173,192,374* | 75.6% | 70.0% | 81.6% |
| *Эрсдэлийн сан* | *1,305,152* | *2,742,355* | *3,146,865* | 1.6% | 2.0% | 1.5% |
| *Хүүний авлага* | *1,662,559* | *3,861,471* | *5,463,307* | 2.0% | 2.8% | 2.6% |
| Авлага | - | 1,534,115 | 3,274,706 | 0.0% | 1.1% | 1.5% |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | 1,055,576 | 821,892 | 783,568 | 1.3% | 0.6% | 0.4% |
| Бусад актив | 2,309,789 | 492,217 | 1,980,060 | 2.8% | 0.4% | 0.9% |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 7,483,027 | 9,606,490 | 5,852,811 | 9.1% | 7.1% | 2.8% |
| **Нийт хөрөнгийн дүн** | **81,902,162** | **136,044,313** | **212,222,295** | **100.0%** | **100.0%** | **100.0%** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 19,933,800 | 42,209,511 | 56,477,725 | 24.3% | 31.0% | 26.6% |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 14,515,976 | 14,100,200 | 34,396,459 | 17.7% | 10.4% | 16.2% |
| Бонд | - | 7,878,886 | 27,620,907 | 0.0% | 5.8% | 13.0% |
| Бусад өглөг | 7,063,692 | 19,055,130 | 18,210,441 | 8.6% | 14.0% | 8.6% |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **41,513,468** | **83,243,727** | **136,705,532** | **50.7%** | **61.2%** | **64.4%** |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | | | | | | |
| Хувьцаат капитал | 16,282,237 | 16,282,237 | 16,282,237 | 19.9% | 12.0% | 7.7% |
| Нэмж төлөгдсөн капитал | 15,377,738 | 15,377,738 | 15,377,738 | 18.8% | 11.3% | 7.2% |
| Хоёрдогч өглөг | - | (51,671) | 4,972,070 | 0.0% | 0.0% | 2.3% |
| Хуримтлагдсан ашиг /(алдагдал) | 8,728,719 | 21,192,282 | 38,884,718 | 10.7% | 15.6% | 18.3% |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **40,388,694** | **52,800,586** | **75,516,763** | **49.3%** | **38.8%** | **35.6%** |
| **Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө** | **81,902,162** | **136,044,313** | **212,222,295** | **100.0%** | **100.0%** | **100.0%** |
| **ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ** | | | | | | |
| Зээл / Нийт хөрөнгө | 75.6% | 70.1% | 81.3% | | | |

### 12.4.1. Онцлох харьцаа үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн байдлын тайланд босоо шинжилгээ гүйцэтгэхэд үндсэн ба биет бус хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 9.1%-аас 2.8% болж буурсан нь биет бус хөрөнгийн өгөөжийг дээшлүүлж, ажилтнуудын бүтээмж нэмэгдсэнээр тайлбарлагдана.

Өр төлбөрийн хувьд өрийн үнэт цаас буюу бондын эзлэх хувь 0%-аас 13% болж сүүлийн 3 жилд өссөн байна. Үнэт цаас гаргагч нь МХБ-ээр дамжуулан нээлттэй бондын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд ББЗЗ дээр мөн бондын санхүүжилтыг амжилттай татан төвлөрүүлсэн нь энэхүү өсөлтийг тайлбарлана. Бондын санхүүжилтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх нь Үнэт цаас гаргагчид уян хатан байдлыг бий болгох, зохицуулагч байгууллагын шаардлагуудыг биелүүлэн үйл ажиллагааны зохистой харьцааг улам хариуцлагатайгаар хангах ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

Хуримтлагдсан ашгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 10.7%-аас 18.3% болж өссөн нь ашигт ажиллагаа тогтмол өндөр байсныг илэрхийлнэ.

Санхүүгийн салбарын чухал үзүүлэлт болох хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэнд харуулсан байна. 2021 онд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн харьцаа 2.4 хүртэл өсч, өмнөх оны үзүүлэлтээс илүү байсан нь актив, пассивын удирдлага сайжирч, богино хугацаат өрийн дүн буурснаар тайлбарлагдана.

**Хүснэгт 13.** Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд, 2019 - 2021

| Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Эргэлтийн харьцаа | 1.9 | 1.8 | 2.4 |
| Мөнгөн хөрөнгийн харьцаа | 6.3% | 19.6% | 10.9% |

**Хүснэгт 14.** Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, 2019 - 2021

| Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Зээлийн эргэц | 0.31 | 0.31 | 0.24 |
| Нийт хөрөнгийн эргэц | 0.27 | 0.22 | 0.23 |

## Өр төлбөрийн шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн өрийн харьцаа үзүүлэлтүүд 2021 онд өмнөх оноос өссөн байна. Хуримтлагдсан ашиг нэмэгдсэн ч Үнэт цаас гаргагч 2019 онд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээс хойш нэмэлт хувьцаа гаргаагүйн улмаас капиталын бүтэц өөрчлөгдөж, өрийн харьцаа нэмэгдэх шалтгаан болсон байна. Эсрэгээрээ уг шалтгаанаас болж хүү төлөх чадварын харьцаа буурсан байна.

**Хүснэгт 15.** Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн харьцаа үзүүлэлтүүд, 2019 - 2021

| Өрийн харьцаа үзүүлэлтүүд | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Өрийн харьцаа | 51% | 61% | 65% |
| Өр/эздийн өмчийн харьцаа | 1.03 | 1.58 | 1.81 |
| Эх үүсвэрийн зардлын харьцаа | 12.2% | 10.5% | 10.8% |
| Хүү төлөх чадварын харьцаа | 3.7 | 3.1 | 2.9 |
| Өрийн үйлчилгээний харьцаа | 0.83 | 0.96 | 1.06 |

СЭЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР

## 12.5. Мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 16. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, 2019 - 2021, мянган төгрөгөөр

| "Инвескор ББСБ" ХК (нэгтгэсэн) | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Татварын өмнөх ашиг | 11,207,604 | 13,905,096 | 23,710,318 |
| **Тохируулга:** | | | |
| Элэгдэл, хорогдлын зардал | 131,648 | 1,130,802 | 1,694,572 |
| Валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй гарз, (олз) | (185,273) | (102,864) | 123,605 |
| ӨБҮХХ-ийн үнэ цэнийн бууралтын гарз | 279,702 | 257,434 | (210,864) |
| ӨБҮХХ-ийн борлуулалтаас үүссэн олз | - | (53,715) | - |
| Зогсоосон үйл ажиллагааг борлуулсан ашиг | 2,387 | 791,641 | - |
| Зээлийн авлагын хүлээгдэж буй алдагдал | 56,963 | 1,297,947 | 520,045 |
| Санхүүгийн хөрөнгө дах үнэ цэнийн бууралт | - | 212,713 | 30,181 |
| Хөрөнгө борлуулсны гарз (олз) | - | - | 2,052 |
| Санхүүгийн зардал | 4,072,393 | 6,841,116 | 12,814,237 |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал | 120,367 | 140,236 | 130,592 |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны алдагдал** | **15,685,791** | **24,420,406** | **38,814,738** |
| Бусад санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийн (өсөлт)/бууралт | (3,168,886) | 1,816,470 | (3,228,434) |
| Харилцагчдад олгосон зээлийн өсөлт (бууралт) | (27,591,562) | (33,917,829) | (79,099,014) |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн өсөлт (бууралт) | - | - | 38,324 |
| Бусад санхүүгийн болон санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (бууралт) | 3,097,888 | (2,110,544) | 2,331,420 |
| **Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгө** | **(18,063,448)** | **(9,791,497)** | **(41,142,966)** |
| Төлсөн орлогын албан татвар | (1,874,209) | (2,563,993) | (3,370,954) |
| Төлсөн хүү | (1,220,971) | (5,954,688) | (14,201,992) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(21,158,628)** | **(18,310,178)** | **(58,715,912)** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Худалдан авсан үндсэн хөрөнгө | (1,430,895) | (972,822) | (1,064,183) |
| Борлуулсан үндсэн хөрөнгө | 668,729 | 681,757 | - |
| Түрээсээр олж эзэмшсэн хөрөнгө ашиглах эрх | - | (586,434) | 796,632 |
| Худалдан авсан биет бус хөрөнгө | (583,625) | (2,221,000) | (119,793) |
| Борлуулсан хөрөнгө оруулалт | - | 1,676,444 | 591,122 |
| Худалдан авсан хөрөнгө оруулалт | - | (3,424,218) | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,345,791)** | **(4,846,273)** | **203,778** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Хувьцаа гаргалт | 17,820,073 | - | - |
| Бонд гаргалтаас хүлээн авсан | - | 7,927,398 | 25,000,000 |
| Бондын эргэн төлөлт | - | (319,000) | (4,349,000) |
| Бусдаас авсан зээл | 2,641,586 | 18,742,671 | 47,137,957 |
| Зээлийн эргэн төлөлт | (3,740,000) | (10,720,209) | (22,600,918) |
| Харилцагчаас татсан итгэлцэл | 17,660,744 | 34,791,900 | 27,558,198 |
| Харилцагчид төлсөн итгэлцэл | (9,135,930) | (6,749,897) | (20,949,042) |
| Хоёрдогч өглөгөөр татсан өр төлбөр | - | - | 5,000,000 |
| Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлөлт | - | 999,587 | (130,592) |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21
"ИНВЕСКОР ББСБ" ХК InvesCore FINANCIAL INSTITUTION Үнэт цаас гаргагч 6060854 УЛААНБААТАР ХОТ

Хүснэгт 16. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, 2019 - 2021, мянган төгрөгөөр /Үргэлжлэл/

| Инвескор ББСБ ХК (нэгтгэсэн) | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **25,246,473** | **44,672,450** | **56,666,603** |
| Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн гадаад валютын ханшийн тэгшитгэл | 83,968 | (73,468) | (104,393) |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **2,742,054** | **21,442,531** | **(1,949,924)** |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **2,320,122** | **5,146,144** | **26,588,675** |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **5,146,144** | **126,588,675** | **24,638,751** |

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн мөнгөн гүйлгээний тайлангаас үзэхэд үйл ажиллагааны мөнгөн урсгал сөрөг утгатай, өндөр тэлэлттэй бол санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал эерэг утгатай, мөн өндөр тэлэлттэй байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа хурдацтай тэлж байгааг илэрхийлж байна.

## 12.6. Ногдол ашгийн бодлого

Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлогын бичиг баримт нь Компанийн тухай болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд уг бодлогын төслийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн № А/05-Т тоот тогтоолоор баталсан байна. Үнэт цаас гаргагч нь 2019 онд анх удаа олон нийтэд хувьцаагаа санал болгохдоо бизнесийн өндөр өсөлтийн жилүүдэд ногдол ашиг тараахгүй гэж тусгасан бол 2021 оноос эхлэн цэвэр ашгийн 5 хувь, дараах жилүүдэд нийт ашигт харьцах хувийг нэмэгдүүлэн ногдол ашиг тараах бодлого баримтлан ажиллаж байна. Улмаар 2020 оны цэвэр ашгийн 5% буюу 1,219,374,606 төгрөгийг 2021 онд, 2021 оны цэвэр ашгийн 9.61% буюу 1,793,197,950 төгрөгийг 2022 онд тус тус ногдол ашигт хуваарилсан байна.

## 12.7. Аудитлагдсан тайлангийн тухай

"Грант Торнтон Аудит" ХХК нь Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага бөгөөд "Инвескор ББСБ" ХК болон түүний охин компаниудын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах санхүүгийн тайлангуудад аудит хийсэн. Үүнд:

- ✓ Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- ✓ Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй;
- ✓ Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан;
- ✓ Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан;
- ✓ Бусад тайлбар тодруулгууд.

Дүгнэлтээр, "Инвескор ББСБ" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн Нэгтгэсэн санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна. Аудитор нь Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Үнэт цаас гаргагчаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж үзсэн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

## 12.8. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тогтвортой, зохистой байдал

**График 37.** Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, 2016 - 2021, сая төгрөгөөр




"Инвескор ББСБ" ХК-ийн нийт хөрөнгийн дүн 2021 онд өмнөх онтой харьцуулахад 56 хувиар өссөн бол 2016 – 2021 онуудын жилийн дундаж өсөлт 116 хувь байна. Нийт хөрөнгийн 82 хувийг харилцагчдад олгосон зээлийн багц бүрдүүлж байна.

**График 38.** Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө, 2016 - 2021, сая төгрөгөөр




Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө 2021 онд өмнөх онтой харьцуулахад 43 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2016 – 2021 оны хооронд өөрийн хөрөнгийн жилийн дундаж өсөлт нь 99% байна. 2021 оны өөрийн хөрөнгийн өсөлтийн 5 тэрбум төгрөг нь толгой компаниас олгосон хоёрдогч өглөгийн санхүүжилт бол үлдсэн хэсэг нь хуримтлагдсан ашгийн өсөлт байна.

**График 39.** Үнэт цаас гаргагчийн хүү болон шимтгэлийн орлого, 2016 - 2021, сая төгрөгөөр




Үнэт цаас гаргагчийн хүү болон шимтгэлийн орлого нь 2021 онд өмнөх онтой харьцуулахад 69 хувиар өссөн байна. 2016 оноос хойших хүү болон шимтгэлийн орлогын жилийн дундаж өсөлт нь 136 хувь байна. 2021 оны хувьд нийт хүү шимтгэлийн орлогын 28 хувийг цахим зээлийн шимтгэл, хүүгийн орлого бүрдүүлсэн байна.

**График 40.** Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг, 2016 - 2021, сая төгрөгөөр




Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг 2021 оны эцэст өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65 хувиар өссөн амжилттай байна. 2016 оноос хойших цэвэр ашгийн жилийн дундаж өсөлт нь 117 хувь байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны хөтөлбөр болох 50 тэрбум төгрөгийн бондын эргэн төлөлттэй холбоотойгоор өрийн харьцаа, хүү төлөх чадварын харьцаа, өрийн үйлчилгээний харьцаа зэрэг үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөхийг доорх графикаас харна уу.

**График 41.** Үнэт цаас гаргагчийн өрийн харьцаа, гүйцэтгэл 2019 - 2021, төсөөлөл 2022 - 2024, хувиар




Үнэт цаас гаргагч нь шинээр гаргаж буй 50 тэрбум төгрөгийн бондыг үндсэн үйл ажиллагаандаа буюу зээл олгох үйл ажиллагаанд 100% зарцуулна. Энэ нь үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгөд ихээхэн хувь эзлэх зээлийн багцыг төдий чинээ нэмэгдүүлэх тул өрийн харьцаанд сөргөөр нөлөөлөхгүй байхаар харагдаж байна.

**График 42.** Үнэт цаас гаргагчийн хүү төлөх чадварын харьцаа, гүйцэтгэл 2019 - 2021, төсөөлөл 2022 - 2024, хувиар




Хүү төлөх чадварын харьцаа 2022 онд 2.8 гарах төлөвтэй байгаа бол 2023 болон 2024 онд тус тус 3.4 болон 3.5 болон нэмэгдэх хүлээлттэй байна. Үүнд одоо шинээр гаргах бондын хөтөлбөр нь 2023 онд бүрэн хэрэгжиж дуусах ба уг бондоор олгосон зээлийн хүүгийн орлого 2023 оноос бүрэн орж ирэх тул цэвэр ашгийг нэмэгдүүлж, улмаар тус харьцааг өсгөхөд нөлөөлж байна.

**График 43.** Үнэт цаас гаргагчийн өрийн үйлчилгээний харьцаа, гүйцэтгэл 2019 - 2021, төсөөлөл 2022 - 2024, хувиар




Өрийн үйлчилгээний харьцаа нь тухайн жилд төлөгдөх бондын нийт төлбөр болон банк, санхүүгийн байгуулагаас татсан зээлийн нийт төлбөрийг үйл ажиллагааны орлогоороо хэрхэн барагдуулах харьцаа юм. Нэмэлт бонд гаргаснаар зээлийн үйл ажиллагааны орлого нэмэгдэж, ашигт ажиллагаа хангалттай хэмжээнд өсөхөөр байгаа ба 50 тэрбум төгрөгийн нээлттэй бондын хөтөлбөр нь өрийн үйлчилгээний харьцааг төдийлөн нэмэгдүүлэхгүй болох нь харагдаж байна. Тодруулбал тус харьцаа 2022 онд 0.71, 2023 онд 0.58, 2024 онд 0.69 байх төсөөлөлтэй байна.

Үнэт цаас гаргагч нь 2023 болон 2024 онд нийт бонд болон банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн 47%, 36%-ийг тус тус дахин санхүүжүүлэх шаардлагатай гэсэн үг.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

**Хүснэгт 17.** Үнэт цаас гаргагчийн өрийн үйлчилгээний харьцаа болон холбоотой санхүүгийн мэдээлэл, гүйцэтгэл 2019 - 2021, төсөөлөл 2022 - 2024, тэрбум төгрөгөөр, хувиар

| | 2019 | 2020 | 2021 | 2022Т | 2023Т | 2024Т |
|---|---|---|---|---|---|---|
| Бонд, банк санхүүгийн байгууллагаас татсан зээлийн нийт төлбөр | 15.98 | 17.11 | 27.32 | 75.10 | 146.24 | 193.56 |
| Үйл ажиллагааны орлого /EBIT, итгэлцлийн үйлчилгээний хүүгийн төлбөрөөс бусад/ | 13.33 | 16.50 | 29.05 | 53.33 | 85.02 | 132.88 |
| Өрийн үйлчилгээний харьцаа | 0.83 | 0.96 | 1.06 | 0.71 | 0.58 | 0.69 |
| Дахин санхүүжүүлэх шаардлагатай бонд, банк санхүүгийн зээл | 2.64 | 0.61 | (1.73) | 21.76 | 61.21 | 60.68 |

Үнэт цаас гаргагч нь бондын эх үүсвэрээр зээлийн багцаа нэмэгдүүлж, зээлийн болон хүүгийн төлөлтөөс орж ирэх мөнгөн урсгалаар бондын хүүгийн болон үндсэн эргэн төлөлтөө төлөх ба нийт гаргасан бондын төлбөр, нийт гаргасан зээлийн төлөлтүүдийн улирлаар нь жишээ болгон төлөвлөж, доорх хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 18.** Үнэт цаас гаргагчийн зээл, өрийн бичгийн эргэн төлөлт, гүйцэтгэл 2019 - 2021, төсөөлөл 2022 - 2024, тэрбум төгрөгөөр, хувиар

| "Инвескор ББСБ" ХК | 2019 | 2020 | 2021 | 2022Q1 | 2022Q2* | 2022Q3* | 2022Q4* |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт зээлийн төлөлт | 62 | 95.3 | 173.2 | 205.9 | 238.6 | 271.3 | 304 |
| Үндсэн зээлийн эргэн төлөлт | 0 | 0 | 161.1 | 56.9 | 66.7 | 86.3 | 86.3 |
| Зээлийн хүүгийн төлөлт | 0 | 0 | 35.4 | 12.5 | 14.7 | 19 | 19 |
| **НИЙТ ЭРГЭН ТӨЛӨЛТ** | **0** | **0** | **196.5** | **69.4** | **81.3** | **105.3** | **105.3** |
| Нээлттэй бонд /20 тэрбум/ | 0 | - | 0.9 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.6 |
| Хаалттай бонд | 0 | 1.1 | 0.6 | 0.3 | 0.3 | 0.4 | 7.2 |
| Нээлттэй бонд /50 тэрбум/ | 0 | - | - | - | - | - | 0.5 |
| **НИЙТ БОНДЫН ТӨЛБӨР** | **0** | **1.1** | **1.5** | **0.9** | **1** | **1** | **8.3** |
| Нийт бондын төлбөр зээлийн хүүгийн эргэн төлөлтөнд эзлэх хувь | - | 0 | 4.20% | 7.40% | 7.00% | 6.10% | 43.80% |
| Нийт бондын төлбөр нийт зээлийн эргэн төлөлтөнд эзлэх хувь | - | 0 | 0.80% | 7.40% | 1.30% | 1.10% | 7.90% |

| "Инвескор ББСБ" ХК | 2023Q1 | 2023Q2* | 2023Q3* | 2023Q4* | 2024Q1 | 2024Q2* | 2024Q3* | 2024Q4* |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт зээл | 343.5 | 383 | 422.5 | 462 | 526.7 | 591.4 | 656.1 | 720.8 |
| Үндсэн зээлийн эргэн төлөлт | 97.1 | 109 | 120.8 | 132.7 | 148.3 | 167.7 | 187.1 | 206.5 |
| Зээлийн хүүгийн төлөлт | 21.4 | 24 | 26.6 | 29.2 | 32.6 | 36.9 | 41.2 | 45.4 |
| **НИЙТ ЭРГЭН ТӨЛӨЛТ** | **118.5** | **132.9** | **147.4** | **161.9** | **180.9** | **204.6** | **228.3** | **252** |
| Нээлттэй бонд /20 тэрбум/ | 0.6 | 8.6 | 6.4 | 6.2 | - | - | - | |
| Хаалттай бонд | 3.1 | - | - | - | - | - | - | |
| Нээлттэй бонд /50 тэрбум/ | 0.9 | 1.4 | 1.8 | 2.3 | 12.3 | 12.3 | 12.3 | 12.3 |
| **НИЙТ БОНДЫН ТӨЛБӨР** | **4.7** | **10** | **8.2** | **8.4** | **12.3** | **12.3** | **12.3** | **12.3** |
| Нийт бондын төлбөр зээлийн хүүгийн төлөлтөнд эзлэх хувь | 21.80% | 41.70% | 30.80% | 28.90% | 37.50% | 33.20% | 29.80% | 27.00% |
| Нийт бондын төлбөр нийт зээлийн төлөлтөд эзлэх хувь | 3.90% | 7.50% | 5.60% | 5.20% | 6.80% | 6.00% | 5.40% | 4.90% |

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
6060854
УЛААНБААТАР

Дээрх графикаас харахад үнэт цаас гаргагчийн зээлийн эргэн төлөлтөөс орж ирэх мөнгөн урсгал нь бондын хүү болон үндсэн төлөлтийг төлөхөд хангалттай хүрэлцэх нь харагдаж байна. Учир нь орж ирэх мөнгөн урсгалын 3 - 8 хувийг бондын хүү болон үндсэн төлөлт эзэлж байна. 2022 оны 4 улирал болон 2023 онуудад тус хувь өндөр байгаа шалтгаан нь 2022 онд үнэт цаас гаргагчийн хаалттай бондууд төлөгдөж дуусах бол 2023 онд өмнөх нээлттэй бондын төлбөр бүрэн төлөгдөж дуусахтай холбоотой.

## 12.9. Бондын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

Үнэт цаас гаргагч нь 50 тэрбум төгрөгийн бондын санхүүжилт олон нийтээс татан төвлөрүүлэн өөрийн харилцагчдад олгох зээлийн багцыг санхүүжүүлэх байдлаар төсөөлөл гаргалаа. Тус зээлүүдийг олгох жигнэсэн дундаж хүү харгалзан 2.52% байхаар таамагласан болно. Иймээс 18 сарын хугацаанд нийлмэл хүүгийн аргаар тооцоход 28.2 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олохоор байна. Үүнээс бондын хүүгийн зардал болох 13.5 тэрбум төгрөгийг хасахаар тус бондыг татан төвлөрүүлэн ашигласнаар 14.7 тэрбум төгрөгөөр цэвэр ашгийг олох төлөвлөгөөтэй байна.

**Хүснэгт 19.** Үнэт цаас гаргагчийн бондын зарцуулалт, олох ашгийн төсөөлөл, 2022 - 2023, сая төгрөгөөр, хувиар

| Зээлийн төрөл | Эзлэх хувь | Дүн | ЗЖДХ /сар/ | Хугацаа | Хүүгийн орлого | Бондын хүүгийн зардал | Бондоос олох ашиг | Бондоос олох ашиг 2022 он | Бондоос олох ашиг 2023 он |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зээлийн багц | 100% | 50,000 | 2.52% | 24 | 28,247 | 13,500 | 14,747 | 1,417 | 13,330 |
| | Үнэт цаас гаргагчийн төлөвлөсөн нийт ашиг | | | | | | | 32,026 | 53,082 |

Дээрх ашгийн 1.4 тэрбум төгрөг нь 2022 онд, үлдсэн 13.3 тэрбум төгрөгийг 2023 онд олохоор төлөвлөсөн байна. Энэ нь харгалзан тухайн он тус бүрийн төлөвлөсөн ашгийн 4.4 болон 25.1 хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилийн ашгийн эзлэх хувь өндөр байгаа шалтгаан нь сар бүрийн зээлийн хүүгийн эргэн төлөлтийг зээл болгон буцаан олгох учраас хүүнээс хүү тооцох аргачлалаар тооцсонтой холбоотой.

"Инвескор ББСБ" ХК (тусдаа) нь анх байгуулагдсан цагаасаа хойш СЗХ-ны тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тасралтгүй хангасаар ирсэн болно.

**Хүснэгт 20.** Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдал, 2019 - 2021

| ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | Байх ёстой | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 47.6% | 39.1% | 30.6% |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 47.6% | 39.1% | 33.0% |
| 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 50.1% | 37.3% | 31.6% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас доошгүй | 10.9% | 34.5% | 16.1% |
| Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / өөрийн хөрөнгө | 30%-аас хэтрэхгүй | 9.4% | 7.7% | 11.7% |
| ББСБ-с гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | 0.0% | 0.0% |
| Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / өөрийн хөрөнгө | 25%-аас хэтрэхгүй | 0.6% | 0.6% | 0.4% |
| Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / өөрийн хөрөнгө | 10%-аас хэтрэхгүй | 0.1% | 0.1% | 0.0% |
| Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө | 50%-аас хэтрэхгүй | 9.7% | 12.4% | 8.6% |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | +/-40%-аас хэтрэхгүй | 13.9% | 18.4% | 18.1% |
| Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 46.0% | 78.1% | 74.9% |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 0.0% | 15.3% | 39.0% |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 7.8% | 3.5% | 0.9% |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 13. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги, төлөвлөгөө

13.1. Дотоод зах зээлд баримтлах стратеги: Ухаалаг тэлэлт

13.2. Гадаад зах зээлд баримтлах стратеги: Санхүүгийн экспорт

13.3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
Үнэт цаас гаргагч
6060854 ☎1119286063
УЛААНБААТАР ХОТ

## 13. Дунд хугацааны стратеги, төлөвлөгөө

**Хүснэгт 21.** ББСБ-ын салбарын үзүүлэлтүүдийн төсөөлөл, 2022 – 2024, тэрбум төгрөгөөр

| Үзүүлэлтүүд | 2022Т | 2023Т | 2024Т |
|---|---|---|---|
| Эдийн засгийн өсөлт, хувиар | 2.5% | 5.8% | 6.8% |
| Санхүүгийн секторын актив | 44,266 | 46,700 | 49,036 |
| Санхүүгийн секторын активын өсөлт, хувиар | 5.9% | 5.5% | 5.0% |
| ББСБ салбарын актив | 3,315 | 4,276 | 5,303 |
| ББСБ активын өсөлт, хувиар | 26% | 29% | 24% |
| ББСБ салбарын эзлэх хувь | 7.5% | 9.2% | 10.8% |
| ББСБ салбарын зээлийн багц | 2,545 | 2,780 | 3,392 |
| ББСБ зээл / актив | 70% | 65% | 64% |
| ББСБ зээлийн багцын өсөлт, хувиар | 27% | 25% | 24% |

Төрөөс Банкны салбар давамгайлсан санхүүгийн зах зээлийн цаашдын чиг хандлага, банкны салбарт баримталж буй бодлого, банкны салбар дахь бүтцийн өөрчлөлт, хэрэглээний зээлийн хязгаарлалт, зээлийн болон хадгаламжийн хүүгийн бууралт, СЗХ-оос тавьж буй ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээний шаардлага зэрэг олон хүчин зүйлсийг тооцож үзэхэд 2024 он гэхэд ББСБ-ын салбарын нийт актив 2 дахин өсч, 5.3 их наяд төгрөгт хүрч санхүүгийн зах зээлийн 10 орчим хувийг бүрдүүлнэ гэх төсөөлөлд хүрч байна. Дэлхийн бусад орнуудын хувьд Банк бус санхүүгийн зах зээл нь нийт Санхүүгийн зах зээлийн 10-15 хувийг бүрдүүлж байгаа тул Монгол Улсын ББСБ-ын салбар цаашид улам хурдацтай тэлэн хөгжих боломжтой байна. Өөрөөр хэлбэл, ББСБ-ууд шинэ зах зээлийг нээж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр илүү идэвхтэй ажиллаж байгааг илэрхийлж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьд 2022 онд банкны сайн зээлдэгчдийг түргэн шуурхай шийдвэр гаргалт, уян хатан нөхцөлөөрөө татах мөн давтан зээлдэгчидтэйгээ урт хугацааны харилцааг бэхжүүлж, илүү сайн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож ажиллахаас гадна ББСБ-ын салбарын өрсөлдөөн ширүүсч байгаа энэхүү орчинд хүүгийн ахиуц буурах хандлага ажиглагдаж байгаа тул гадаад шинэ зах зээл рүү тэлэн нэвтрэхэд онцгой анхаарал хандуулан ажиллана.

### 13.1. Дотоод зах зээлд баримтлах стратеги: Ухаалаг тэлэлт

"Инвескор ББСБ" ХК-ийн дотоод зах зээлд баримтлах гол стратеги нь илүү зардал багатай ухаалаг тэлэлт хийх бөгөөд ингэснээр хувьцаа эзэмшигчдэд очих өгөөжийг бууруулахгүйгээр зээлийн хүүгээ буулгах боломжтой болох юм. Өөрөөр хэлбэл үр дүнтэй хөрөнгө оруулалт, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх замаар дотоодын зах зээлд бага зардлаар, өндөр үр ашигтай ажиллах бүтцийг бий болгох юм.

"Инвескор ББСБ" ХК-ийн хувьд ухаалаг тэлэлтийн стратегийг доорх хоёр чиглэлээр хэрэгжүүлж байна. Үүнд:

#### 13.1.1. Финтек бүтээгдэхүүн, үйлчилгээ

Харилцагчийн цаг хугацаа, хүч хөдөлмөрийг хэмнэсэн бүх төрлийн цахим зээл, цахим төлбөр тооцоо, дата шинжилгээнд суурилсан санхүүгийн зуучлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бүрэн дэмжиж ажиллана. Финтект суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ нь харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээс гадна байгууллагын үйл ажиллагааны зардлыг бууруулж байна.

Охин компани болох "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК-ийн Покет аппликейшнийг санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн платформ буюу экосистем болгож хөгжүүлэх нь дунд хугацааны гол зорилго бөгөөд Инвескор Санхүүгийн Групп дэх компаниуд нэгдсэн стратегийн хүрээнд синержи үүсгэж экосистемийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

Иргэдийн бага дүнтэй хэрэглээний зээлүүдийг бүрэн автоматжуулснаар их хэмжээний хүний нөөц болон үйл ажиллагааны зардлыг хэмнэх бөгөөд хүн хүчээ илүү нарийн судалгаа, ажиллагаа шаардсан бизнесийн зээл рүү түлхүү хуваарилна.

Мөн факторинг, зээлийн баталгаа гэх мэт зээлээс бусад үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан өргөжүүлж, шимтгэлийн орлогын эзлэх хувийг өсгөхөөр ажиллаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

### 13.1.2. Хамтарсан түншлэлийн хөтөлбөр

***Инвескор "Аллианс" хөтөлбөр***

"Аллианс" хөтөлбөрт хамрагдсан ББСБ-ууд нь "Инвескор ББСБ" ХК-тай мэдлэг, туршлагаа солилцож хамтран ажилласнаар бүтээгдэхүүн үйлчилгээгээ шинэ түвшинд гаргаж хөтөлбөрийн хүрээнд нэгдсэн нэг стандарт, систем нэвтрүүлж байгаагаараа онцлогтой.

Үнэт цаас гаргагч нь "Аллианс" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн ББСБ-уудыг чадваржуулж, шаардлагатай эх үүсвэрийг хангаж ажилласнаар тухайн орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

2025 он гэхэд "Аллианс" хөтөлбөрийн цар хүрээг улам өргөжүүлж нийт 21 аймаг бүрийн хамгийн шилдэг ББСБ-уудыг "Аллианс" хөтөлбөрийн гишүүн болгоно. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 аймагт уг хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа бол 2022 оны эцсээр нийт 10 аймагт гишүүнтэй болох төлөвлөгөөтэй байна.

***SMB хөтөлбөр***

Үнэт цаас гаргагч нь бизнес эрхлэгчдийг хүү багатай тогтвортой санхүүжилтээр хангахын тулд эх үүсвэрийн бүтцээ илүү урт хугацаатай, тогтвортой хувилбарууд руу чиглүүлж байна. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчид болон ногоон санхүүжилт руу чиглэсэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий санхүүжилт татахаар олон улсын санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна.

Ялангуяа дэлхийн хэмжээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон санхүүжилт зах зээлд цаашид даваамгайлах хандлагатай байгаа бөгөөд энэ зах зээлд бусдаасаа түрүүлж амжилттай байр сууриа бүрдүүлсэн санхүүгийн байгууллагууд дунд хугацааны тогтвортой өсөлтийн дүр зургаа илүү тодорхой болгож чадаж байна.

"Инвескор ББСБ" ХК нь жижиг дунд бизнес эрхлэгч нарт тулгардаг дээрх асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхээр зорьж 2018 онд бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих "SMB (Сэмбий) хөтөлбөр"-ийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд таатай нөхцөл бүхий эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зээлийг санал болгохоос гадна бизнесийн зорилго, эрэлт хэрэгцээнд нийцсэн зөвлөх үйлчилгээ болон сургалтуудыг мэргэжлийн байгууллагууд, донор байгууллагуудтай хамтран хүргэж байна.

## 13.2. Гадаад зах зээлд баримтлах стратеги: Санхүүгийн экспорт

Үнэт цаас гаргагч нь Төв Азийн зах зээлд өөрийн бизнесийн ноу-хау, финтек бүтээгдэхүүн, санхүүгийн эх үүсвэрийн давуу талаа ашиглан, салбар компани байгуулах төлөвлөгөөний дагуу Киргиз Улсад хоёр охин компани байгуулж, үйл ажиллагааг нь амжилттай эхлүүлсэн юм. Энэхүү стратегийн гол үзэл нь Монгол Улсын зах зээлд амжилттай туршигдсан санхүүгийн шийдэл, үйл ажиллагааны ноу-хау, финтекийн шийдлүүдийг ижил төстэй эдийн засаг, соёлтой орчинд нэвтрүүлэх боломж, нөхцөлийг Үнэт цаас гаргагч хангасан, тус зорилтот улс орнуудад тогтвортой санхүүжилтыг бүрдүүлэх боломцоотой гэх санаа юм. Үнэт цаас гаргагч нь цаашид Төв Ази, Зүүн Өмнөд Азийн улс орнуудад охин компаниа байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэйгөөр судалгаа гүйцэтгэн, ажиллах хүчин бүрдүүлэн ажиллаж байна.

Төв Азийн зах зээлийг сонгох болсон шалтгаан нь эдгээр орнуудын хувьд Монгол Улстай нийгэм, соёл, эрхзүйн орчин, эдийн засгийн бүтцийн хувьд харьцангуй ойролцоо тулд харилцан ойлголцох, хамтран ажиллахад илүү хялбар хэмээн үзэж буйд юм. Мөн эдгээр орнуудын зах зээлд бичил санхүүгийн үйлчилгээ, финтект суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд харьцангуй хөгжиж амжаагүй байгаа тул "Инвескор ББСБ" ХК-ийн хувьд өрсөлдөөний харьцангуй давуу тал болно.

Киргиз Улсын зах зээлд амжилттай нэвтэрснээр Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад улсад экспортолж Монгол Улсын экспортын орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэхээс гадна компанийн урт хугацааны өсөлт, тэлэлтийн үндсэн суурийг бүрдүүлж чадсан юм.

Ирэх 3 жилийн хугацаанд Үнэт цаас гаргагч нь шинээр Төв Азийн хоёр улсын зах зээлд нэвтэрч бизнесээ нутагшуулах, мөн Зүүн Өмнөд Азийн зах зээлд орох бэлтгэлээ бүрэн хангах болно.

## 13.3. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө

Хүснэгт 22. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүү байдлын тайлангийн 3 жилийн төсөөлөл, 2022 - 2024, мянган төгрөгөөр

| Үзүүлэлтүүд | 2022Т | 2023Т | 2024Т |
|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 14,972,281 | 19,499,903 | 33,593,222 |
| Хөрөнгө оруулалт | 4,056,823 | 4,868,187 | 5,841,825 |
| **Харилцагчдад олгосон зээл-цэвэр** | **300,829,322** | **456,572,557** | **710,158,794** |
| *Нийт зээл* | *303,968,668* | *462,032,375* | *720,770,506* |
| *Эрсдэлийн сан* | *(7,987,483)* | *(11,277,583)* | *(17,593,030)* |
| *Хүүгийн авлага* | *4,848,137* | *5,817,765* | *6,981,318* |
| Авлага | 5,584,661 | 6,143,127 | 6,757,440 |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | 13,274 | 539,578 | 566,557 |
| Бусад актив | 2,756,061 | 3,169,470 | 3,644,890 |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 9,670,987 | 11,605,185 | 13,926,222 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **337,883,408** | **502,398,007** | **774,488,950** |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 77,339,020 | 126,080,140 | 221,712,538 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 75,789,328 | 83,090,856 | 121,502,697 |
| Бонд | 55,000,000 | 87,286,251 | 138,570,336 |
| Бусад өглөг | 8,867,905 | 11,971,314 | 15,562,708 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **216,996,253** | **308,428,560** | **497,348,278** |
| Хувьцаат капитал | 17,190,237 | 18,390,237 | 18,390,237 |
| Нэмж төлөгдсөн капитал | 29,469,738 | 48,269,738[1] | 48,269,738 |
| Хоёрдогч өглөг болон эздийн өмчийн бусад хэсэг | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 69,227,180 | 122,309,471 | 205,480,697 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **120,887,155** | **193,969,447** | **277,140,672** |
| **Нийт пассив ба өөрийн хөрөнгө** | **337,883,408** | **502,398,007** | **774,488,950** |

*[1] 2023 оны нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой өсөлт*

**График 44.** Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын төсөөлөл, 2020 - 2021 гүйцэтгэл, 2022 - 2024 төсөөлөл, тэрбум төгрөгөөр




Нийт зээлийн багцын хувьд 2024 оны эцэст 721 тэрбум төгрөгт хүргэж 2021 оны эцэстэй харьцуулахад 316 хувиар буюу 4.2 дахин өссөн дүнтэй байх төсөөлөлтэй байна. 2021 – 2024 оны жилийн дундаж өсөлт нь 66 хувь байна.

**График 45.** Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн төсөөлөл, 2020 - 2021 гүйцэтгэл, 2022 - 2024 төсөөлөл, тэрбум төгрөгөөр




Үнэт цаас гаргагч нь нийт хөрөнгөө 2024 оны эцэст 774 тэрбум болгож өсгөсөн байх төлөвлөгөөтэй бөгөөд энэ нь 2021 оны эцсийн гүйцэтгэлтэй харьцуулахад 265%-аар буюу 3.6 дахин өссөн дүн юм. 2021 – 2024 оны жилийн дундаж өсөлт нь 54 хувь байна.

**График 46.** Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлогын төсөөлөл, 2020 - 2021 гүйцэтгэл, 2022 - 2024 төсөөлөл, тэрбум төгрөгөөр




Үнэт цаас гаргагч нь хүү болон түүнтэй адилтгах орлогоо жил бүр өсгөж 2024 оны эцэст 173 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь 2021 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 321 хувиар өссөн, 4.2 дахин их үзүүлэлт байх юм. 2021 – 2024 оны жилийн дундаж өсөлт нь 62 хувь байна.

**График 47.** Үнэт цаас гаргагчийн шимтгэл, хураамжийн орлогын төсөөлөл, 2020 - 2021 гүйцэтгэл, 2022 - 2024 төсөөлөл, тэрбум төгрөгөөр




Үнэт цаас гаргагч нь шимтгэл, хураамжийн орлогын өсөлтийг 2024 оны эцэст 37 тэрбум төгрөгт хүргэж 2021 оны гүйцэтгэлээ 311 хувиар буюу 4.1 дахин өсгөх төсөөлөлтэй байна. 2021 – 2024 оны жилийн дундаж өсөлт нь 60 хувь байна.

**График 48.** Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн төсөөлөл, 2020 - 2021 гүйцэтгэл, 2022 - 2024 төсөөлөл, тэрбум төгрөгөөр




Үнэт цаас гаргагч нь цэвэр ашгаа 2024 оны эцэст 83 тэрбум төгрөгт хүргэж 2021 оны гүйцэтгэлээ 333 хувиар буюу 4.3 дахин өсгөх төсөөлөлтэй байна. 2021 – 2024 оны жилийн дундаж өсөлт нь 64 хувь байна.

Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн орлогын тайлангийн 3 жилийн төсөөлөл, 2022 - 2024, мянган төгрөгөөр

| Үзүүлэлтүүд | 2022Т | 2023Т | 2024Т |
|---|---|---|---|
| **Хүү болон түүнтэй адилтгах орлого** | **76,179,897** | **112,985,154** | **173,280,622** |
| **Хүү болон түүнтэй адилтгах зардал** | **22,240,754** | **28,607,858** | **44,342,179** |
| *Хүү болон түүнтэй адилтгах зардал* | *13,079,002* | *15,448,243* | *23,187,383* |
| *Итгэлцлийн үйл ажиллагааны зардал* | *9,161,752* | *13,159,614* | *21,154,796* |
| **Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал** | **4,996,029** | **3,290,100** | **6,315,447** |
| **Хүүгийн цэвэр орлого** | **48,943,114** | **81,087,197** | **122,622,996** |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 14,613,642 | 23,381,827 | 37,410,922 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (зардал) | - | - | - |
| **Нийт хүүгийн бус цэвэр орлого** | **14,613,642** | **23,381,827** | **37,410,922** |
| **Нийт үйл ажиллагааны орлого** | **63,556,755** | **104,469,023** | **160,033,919** |
| Ажиллагсадтай холбогдолтой зардал | 10,362,845 | 15,701,685 | 22,552,528 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 12,442,798 | 19,190,949 | 27,786,423 |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | **22,805,643** | **34,892,634** | **50,338,952** |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) | (496,170) | - | - |
| **Татварын өмнөх ашиг** | **40,254,942** | **69,576,389** | **109,694,967** |
| Орлогын татварын зардал | 8,218,783 | 16,494,097 | 26,523,742 |
| **Цэвэр ашиг** | **32,036,159** | **53,082,292** | **83,171,225** |

Хүснэгт 24: Онцлох харьцаа үзүүлэлтүүдийн төсөөлөл, 2022 - 2024, хувиар

| Үзүүлэлтүүд | 2022Т | 2023Т | 2024Т |
|---|---|---|---|
| Өрийн харьцаа | 64.2% | 61.4% | 64.2% |
| Өрийн үйлчилгээний харьцаа | 0.71 | 0.58 | 0.69 |
| Нийт хөрөнгийн өгөөж | 9.5% | 10.6% | 10.7% |
| Нийт хөрөнгийн дундаж өгөөж | 11.6% | 12.6% | 13.0% |
| Эздийн өмчийн өгөөж | 26.5% | 27.4% | 30.0% |
| Эздийн өмчийн дундаж өгөөж | 32.6% | 33.7% | 35.3% |
| Хүүгийн цэвэр ахиуц | 20.5% | 21.2% | 20.7% |
| ҮАЗ/Орлого | 35.9% | 33.4% | 31.5% |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2
БҮРТГЭВ-02

2022.11.09

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
UNIVERSITY
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 14. Хууль эрх зүйн орчны тухай

14.1. Зохицуулах байгууллагууд

14.2 Хамаарах хууль, дүрэм, журам

14.3 Тусгай зөвшөөрөл

14.4 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

14.5 Мэдээллийн аюулгүй байдлын тухай

14.6 Харилцагчийг таньж мэдэх (KYC) шаардлага

14.7 Оюуны өмчийн эрх

14.8 Татварын тухай

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

ТАВАН БОГД КАПИТАЛ

# 14. Хууль эрх зүйн орчны тухай

## 14.1. Зохицуулах байгууллагууд

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1 дэх хэсэг, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг болон СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу ББСБ-ын үйл ажиллагаа болон үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь СЗХ-ны зохицуулах харилцаанд хамаарна.

## 14.2. Хамаарах хууль, дүрэм, журам

**Хүснэгт 25.** Хамааралтай хууль, дүрэм, журмын жагсаалт

| № | Хуулийн нэр | Хэрэгжиж эхэлсэн огноо |
|---|---|---|
| 1 | Иргэний хууль | 2002 оны 02 дугаар сарын 05-ны өдөр |
| 2 | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль | 2003 оны 02 дугаар сарын 01-ний өдөр |
| 3 | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай | 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр |
| 4 | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль | 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр |
| 5 | Зээлийн мэдээллийн тухай хууль | 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |
| 6 | Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль | 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр |
| 7 | Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль | 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр |
| 8 | Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль | 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдөр |
| 9 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль | 2018 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр |
| 10 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай | 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр |
| 11 | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль | 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |

| № | Хэм хэмжээний акт (дүрэм, журам, стандарт, заавар, аргачлал гэх мэт)-ын нэр | Хэрэгжиж эхэлсэн огноо |
|---|---|---|
| 1 | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам | 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдөр |
| 2 | ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам | 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр |
| 3 | ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам | 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр |
| 4 | Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэлийн журам | 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдөр |
| 5 | ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам | 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр |
| 6 | Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам | 2003 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр |
| 7 | Үнэт цаасны бүртгэлийн журам | 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр |
| 8 | ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичиг бүртгэх, түүнд хяналт тавих журам | 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр |
| 9 | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам | 2019 оны 02 дугаар сарын 08-ны өдөр |

ББСБ-ын үндсэн үйл ажиллагаанд дээр дурдсан хууль тогтоомжийн зохицуулалтуудыг удирдлага болгодог бөгөөд тухайн харилцаанд үйлчлэх бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журмыг мөн адил өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02
2022.11.09
"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2022 11 09
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

## 14.3. Тусгай зөвшөөрөл

Үнэт цаас гаргагч нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 10.1.1, 15, 15.3.1, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 9.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлдэг. Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ 101/554 дугаар тусгай зөвшөөрөл, 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор Зээлийн үйл ажиллагаа, Факторингийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйл ажиллагаа, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авсан.

## 14.4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

Үнэт цаас гаргагч нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоог Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн бий болгох, үр дүнтэй хэрэгжүүлэхэд зорьж ажилладаг бөгөөд энэхүү зорилгын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд жил бүр үнэлгээ хийх замаар сайжруулах, "Монпеп Дата" ХХК-тай хамтран олон улсын санхүүгийн хориг жагсаалт, улс төрд нөлөө бүхий этгээдийг тодорхойлох, тулган шалгах үйл явцыг автоматжуулах, дэвшилтэт технологийг ашиглан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хялбаршуулахад чиглэсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлээд байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь нийт ажилтнуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод тогтолцооны талаар мэдлэг, ойлголт өгөх, холбогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх дотоод сургалтыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг хариуцан ажилладаг ажилтнуудын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэн ажилладаг.

## 14.5. Мэдээллийн аюулгүй байдлын тухай

Үнэт цаас гаргагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс үйл ажиллагаандаа Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, кибер аюулгүй байдлыг хангах зохицуулалт, стандартууд зэргийг удирдлага болгон ажилладаг. Үнэт цаас гаргагчийн хувьд мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2013 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. Уг ажлын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын багц дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, хэрэгжилтийг хангуулахаар нийт ажилтнуудад сургалт хийх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэж байна.

Үнэт цаас гаргагчийн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хүрээнд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд ашиглагдах үнэ цэнэ бүхий мэдээлэл буюу мэдээллийн өмчийн хяналт зохицуулалтыг тодорхойлсон. Энэхүү зохицуулалтын хүрээнд байгууллагын, ажилтнуудын болон харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах орчин тогтолцоог бүрдүүлсэн. Биет болон биет бус хэлбэрээр оршин буй бүхий л мэдээлэл болон мэдээллийн өмч нь нууцын зэрэглэлийн ангилал, холбогдох хяналтын дагуу үйл ажиллагаанд хэрэглэгддэг бөгөөд үүнийг дотоод журмаар зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавих мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтныг томилсон.

## 14.6. Харилцагчийг таньж мэдэх (KYC) шаардлага

Үнэт цаас гаргагч нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шаардлагын хүрээнд харилцагчийг таньж мэдэх хууль тогтоомжид заасан үүрэг хүлээдэг бөгөөд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар холбогдох харилцагчийг таньж мэдэх шаардлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн систем болох Смарт-ЛОС систем нь харилцагчийг таньж мэдэхэд хуулиар болон зохицуулагч байгууллагаас шаардсан баримт бичгүүдийг бүртгэх, хадгалах, баталгаажуулах үйл явцыг тодорхойлон оруулсан байдаг. Харилцагч таньж мэдэх үйл ажиллагаатай холбоотой бий болсон баримт бичгүүдийг хуульд заасан хугацаанд архивлан хадгалдаг. Үнэт цаас гаргагчийн харилцагч таньж мэдэх ажиллагаа нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлага болон бусад хууль тогтоомжийн шаардлагыг хангасан болно.

InvesCore
6060854 ☎ 1119286063
УЛААНБААТАР ХОТ

## 14.7. Оюуны өмчийн эрх

Оюуны өмчийн тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1 дэх хэсэгт зааснаар "оюуны өмч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийн өмчийг ойлгодог. Тиймээс хуулийн хүрээнд дараах оюуны өмчийн эрхийг бүртгэж, хамгаалдаг байна. Үүнд:

- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх;
- Шинэ бүтээл;
- Ашигтай загвар;
- Бүтээгдэхүүний загвар;
- Барааны тэмдэг;
- Газар зүйн заалт.

Үнэт цаас гаргагч нь оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон газар зүйн заалт эзэмшдэггүй. Үнэт цаас гаргагч нь нийт 8 ширхэг барааны тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн бөгөөд Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтын дагуу тус барааны тэмдгүүд нь 10 жилийн хугацаанд хүчинтэй байж, тухай бүр 10 жилийн хугацаагаар сунгах зохицуулалттай.

## 14.8. Татварын тухай

Үнэт цаас гаргагч нь татвар, санхүүгийн чиглэлээр дор дурдсан хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллаж байна. Үүнд:

**Хүснэгт 26.** Хамааралтай татварын тухай хуулиудын жагсаалт

| № | Хуулийн нэр | Хэрэгжиж эхэлсэн огноо |
|---|---|---|
| | Татварын ерөнхий хууль | 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |
| 2 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль | 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |
| 3 | Хувь хүний орлогын албан татварын тухай хууль | 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |
| 4 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль | 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |
| 5 | Нягтлан бодох бүртгэлийн тухай | 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |
| 6 | Аудитын тухай хууль | 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр |
| 7 | Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай | 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр |

| № | Хэм хэмжээний акт (дүрэм, журам, стандарт, заавар, аргачлал гэх мэт)-ын нэр | Хэрэгжиж эхэлсэн огноо |
|---|---|---|
| | Нягтлан бодох бүртгэлийн валютыг тогтоох, өөрчлөх санхүүгийн тайланг хөрвүүлэх журам | 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдөр |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар | 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдөр |
| 3 | Санхүүгийн тайлан тодруулгын маягт | 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдөр |
| 4 | Санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал | 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдөр |
| 5 | Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журам | 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр |
| 6 | Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журам | 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр |

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагч нь албан татвар төлөгч мөн бөгөөд өөрийн үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан шилжүүлсний орлого болон бусад орлогод албан татвар төлдөг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагч нь 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар төлнө. Харин тус хуулийн 20.2.5 дахь хэсэгт заасснаар Үнэт цаас гаргагч нь гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн орлогод 5 хувиар татвар ногдуулж, төлнө.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.4, 13.5.6, 13.5.5, 13.5.7 дахь заалтуудад тус тус заасны дагуу үнэт цаас, хувьцаа гаргах, шилжүүлэх, борлуулах, хүлээн авах, тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ, санхүүгийн хэрэгслийг анхдагч, хоёрдогч зах зээл болон биржийн бус зах зээлд бүртгүүлэх, гаргах, арилжих, шилжүүлэх, борлуулах, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаа болон тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ, зээл олгох үйлчилгээ болон зээлийн хүү нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөнө.

Үнэт цаас гаргагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, хуульд заасан хугацаанд буюу улирал тутам аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, хувь хүний орлогын албан татварын тайлан /суутган болон цалин хөлсний/ болон үнэ шилжилтийн тайланг тус тус илгээдэг.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаа нь татварын холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хууль тогтоомж зөрчсөн, татвар төлөх үүргээ биелүүлээгүй үндэслэлээр эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шаардах хуудас, эсвэл акт, шийтгэврийн хуудас байхгүй болно.

СЗХ
он 2022 сар 11 · 03 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИ
MONGOLIAN STOCK EXCHAN
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 15. Хууль зүй болон засаглалын комплаенс

15.1. Хууль зүйн комплаенс

15.2. Засаглалын комплаенс

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCorp
УЛААНБААТАР ХОТ

# 15. Хууль зүй болон засаглалын комплаенс

## 15.1. Хууль зүйн комплаенс

Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаанд мөрдөх дотоод журам, заавар, тушаал, шийдвэр, үйл ажиллагаанд хэрэглэх гэрээ хэлцэл болон бусад эрх зүйн баримт бичгийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянаж, үнэлэх зорилгоор жил бүрийн бизнес төлөвлөгөөнд хуулийн нийцлийн үнэлгээ хийх ажлыг тусган гүйцэтгэдэг. 2022 онд хуулийн нийцлийн үнэлгээг эхний улиралд багтаан гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу тус үнэлгээг хийсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дотоод дүрэм, журам, эрх зүйн баримт бичгүүд нь 96 хувийн нийцэлтэй, 4 хувь нь эрсдэлгүй хэмжээнд үл нийцэлтэй гэж үнэлэгдсэн болно.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлөх хууль тогтоомж шинээр батлагдах, эсвэл хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид өөрчлөлт орох тохиолдолд төлөвлөгөөт бус хуулийн нийцлийн үнэлгээг хийж удирдлагууд болон бизнесийн нэгжүүдэд танилцуулдаг. Төлөвлөгөөт бус хуулийн нийцлийн үнэлгээгээр Үнэт цаас гаргагчийн эрх зүйн баримт бичгүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг үнэлж, нийцээгүй тохиолдолд хэрхэн нийцүүлэх талаар зөвлөмжийг тусгадаг.

2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулга нь байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаа, дотоод журамд хэрхэн нөлөөлөх буюу хуульд нийцүүлэн хийгдэх шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгасан төлөвлөгөөт бус хуулийн нийцлийн үнэлгээг гаргаж, Хүний нөөцийн газраас үнэлгээнд заасны дагуу хуулийн нийцлийг хангуулж ажилласан.

Хуулийн нийцлийн үнэлгээг Үнэт цаас гаргагчийн Хууль, Эрсдэлийн удирдлагын газрын Хууль, эрх зүйн алба гүйцэтгэдэг бөгөөд үнэлгээг удирдлагуудад танилцуулж, хуулийн нийцлийг хангуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг холбогдох газар нэгжид үүрэг болгох замаар хуулийн нийцлийг хангуулж ажилладаг.

Мөн байгууллагын Эрх зүйн актын удирдлагын журам болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу бизнесийн нэгжээс боловсруулан үйл ажиллагаанд хэрэгжүүлэх журам, зааврыг эрх бүхий этгээдээр батлуулахаас өмнө хууль, эрх зүйн албаар заавал хянуулж, нийцлийг хангуулсны дараа хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлдэг.

### 15.1.1. Шүүхийн маргаан

Үнэт цаас гаргагч нь иргэний хэргийн шүүхэд нийт 6 удаа хариуцагчаар татагдсан бөгөөд үүнээс нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон 3, нэхэмжлэлийг хангаж шийдсэн 2, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 1 хэрэг байна. Хариуцагчаар оролцож буй иргэний хэргүүд нь зээлийн барьцаа хөрөнгө чөлөөлүүлэх тухай болон барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбоотой харилцагчаас нэхэмжлэл гаргасан маргаанууд байдаг.

Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд харилцагч, хамтран ажиллагч байгууллагуудтай олон төрлийн иргэний эрх зүйн гэрээ, хэлцэл байгуулж ажилладаг бөгөөд уг гэрээ, хэлцлүүдтэй холбоотой шүүхээр хянан шийдвэрлэгдсэн, эсвэл шийдвэрлэгдэж байгаа маргаан байхгүй болно. Түүнчлэн хөдөлмөрийн харилцаанд ажилтантай байгуулсан гэрээ, хэлцэлтэй холбоотой аливаа хөдөлмөрийн маргаан шүүхэд үүссэн тохиолдол гараагүй байна.

Зохицуулагч байгууллага, төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс байгууллагын үйл ажиллагаа хуульд нийцээгүй үндэслэлээр шаардлага хүргүүлсэн, акт тавьсан, зөрчлийн хэрэг үүсгэсэн тохиолдол өнөөдрийн байдлаар байхгүй бөгөөд Үнэт цаас гаргагч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд захиргаа акт, захиргааны гэрээг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг тогтоолгох аливаа нэхэмжлэл гаргаагүй болно.

СЗХ
он 2022 сар 11 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2
БҮРТГЭВ-02

## 15.2. Засаглалын комплаенс

Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалыг компанийн бүтэц болон засаглалын баримт бичгүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг. Засаглалыг хэрэгжүүлэгч бүтцийн хувьд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод, гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх удирдлагын дэргэдэх хороод, дэд захирал, газар нэгжийн удирдлага гэсэн бүтэцтэй. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дарга, гишүүд болон нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангасан талаар хөндлөнгийн хуулийн дүгнэлтэд тусгасан.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо болон Эрсдэлийн удирдлагын хороо тус тус ажилладаг төдийгүй байгууллагын Дотоод аудитын газар нь ТУЗ-өөс сонгогдож, томилогдон ББСБ-ын үйл ажиллагааны дотоод хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байна. Дотоод аудитын газар нь дотоод хяналтын чиг үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, дахин зөрчил гарахаас сэргийлэх зөвлөмж хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-ийн дэргэдэх хорооны үйл ажиллагааг зохицуулахаар Аудитын хорооны журам, Нэр дэвшүүлэх хорооны журам, Эрсдэлийн удирдлагын хорооны журмыг ТУЗ-өөс батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын удирдлагад Зээлийн хороо, Удирдлагын хороо, Актив, пассив, эрсдэлийн удирдлагын хороо болон Мэдээлэл технологи, автоматжуулалтын хороог тус тус байгуулж, хороодын үйл ажиллагааг Хороодын үйл ажиллагааны журмаар зохицуулна. Хорооны шийдвэр гаргах үйл ажиллагааг хараат бус, хуульд нийцсэн байдлыг хангах үүднээс хорооны хуралд гишүүдийн оролцоог тэнцвэртэй хангах, шийдвэрийг олонхийн саналаар гаргах зарчмыг баримтлахаар журамд тусгасан.

Үнэт цаас гаргагчийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн болохыг мөн компанийн засаглалын журмууд нь нь хуульд нийцсэн, Компанийн засаглалын кодекс зөрчөөгүй болохыг хөндлөнгийн хуулийн дүгнэлтэд тусгасан байна.

Компанийн Дүрэмд тусгаснаар Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулах бөгөөд ТУЗ нь түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй. Компанийн Дүрэмд 1,500,000,001 (нэг тэрбум таван зуун сая нэг) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө худалдан авах, захиран зарцуулах эрхийг ТУЗ-ийн зөвшөөрлөөр гүйцэтгэхээр зохицуулсан. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа болох зээл шийдвэрлэх эрхийг тогтоохдоо салбарын захирал 35,000,000 (гучин таван сая) төгрөг, салбарын удирдлагын газрын захирал 50,000,000 (тавин сая) төгрөг, дэд захирал 100,000,000 (нэг зуун сая) төгрөг, гүйцэтгэх захирал 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөг, Зээлийн хороо 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэл үнийн дүнтэй зээл шийдвэрлэх бол түүнээс дээш үнийн дүнтэй зээлийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо шийдвэрлэхээр зохицуулсан. Гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа өөрийн чиг үүргийг хуваарилах замаар төвлөрлийг бууруулах, хараат бус байдлыг хангах зарчмыг баримталдаг. Үнэт цаас гаргагч нь бүтцийн хувьд бизнес хариуцсан дэд захирал, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал, санхүү хариуцсан дэд захиралтай бөгөөд дэд захирлууд нь тус тусын хариуцсан асуудлаар шийдвэр гаргалтад оролцож, үүрэг, хариуцлага хүлээхээр Үнэт цаас гаргагчийн дотоод журамд тусгасан. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, чиг үүргийн давхцал бий болохоос сэргийлэх зорилгоор газар, нэгжүүдийг чиг үүргийн дагуу хуваарилж, холбогдох удирдлагын удирдлага дор ажилладаг. Тухайлбал гүйцэтгэх захирлын удирдлагад хүний нөөцийн газар болон хууль, эрсдэлийн удирдлагын газар байх бөгөөд байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн нийцэл, тусгай активын үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Борлуулалт, салбарын үйл ажиллагаа, зохион байгуулалт, бизнес хамтын ажиллагаа, маркетинг, олон нийттэй харилцах асуудлыг бизнес хариуцсан дэд захирлын удирдлагад буй газар нэгжүүд; санхүү бүртгэлт, тайлагнал, санхүүгийн удирдлага, хөрөнгийн менежменттэй холбоотой харилцааг санхүү хариуцсан дэд захирлын удирдлагад буй газар, нэгжүүд хариуцдаг бол үйл ажиллагаа, бизнес хөгжил, системийн удирдлагатай холбоотой асуудлыг үйл ажиллагаа хариуцсан дэд захирлын удирдлагад буй газар нэгжүүд тус тус хэрэгжүүлдэг.

ИНВЕСКОР
БОНД 2.

# 16. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

16.1. Бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл

16.2 Бусадтай байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцэл

16.3 Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл

16.4 Үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээ хэлцэл

СЗХ
он сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 2

# 16. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

## 16.1. Бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасны дагуу хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцлээс бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон нэг, эсвэл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг их хэмжээний хэлцэл гэнэ.

Үнэт цаас гаргагчийн сүүлийн буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар балансын актив нь 212,222,295,000 (хоёр зуун арван хоёр тэрбум, хоёр зуун хорин хоёр сая, хоёр зуун ерэн таван мянга) төгрөг байна. Үнэт цаас гаргагчийн сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувь буюу 53,055,573,750 (тавин гурван тэрбум, тавин таван сая, таван зуун далан гурван мянга, долоон зуун тавин) төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй хэлцэл 2022 онд байгуулсан бол уг хэлцэл нь их хэмжээний хэлцэлд тооцогдоно. Үнэт цаас гаргагч нь энэхүү танилцуулгыг бэлтгэх өдрийн байдлаар их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор буюу 2019, 2020, 2021 онд их хэмжээний 2 хэлцэл хийсэн ба уг хэлцлээс гадна 2017 онд их хэмжээний 1 хэлцэл байгуулсан. Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсанаас хойш нийт их хэмжээний 3 хэлцэл байгуулсан нь "хэвийн" хэрэгжиж байна. Энэхүү танилцуулгыг гаргах өдрийн байдлаар их хэмжээний хэлцэлтэй холбоотой ямар нэгэн зөрчил, маргаан үүсээгүй болно.

Үнэт цаас гаргагчийн байгуулсан их хэмжээний хэлцлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн гаргасан хууль зүйн дүгнэлтээс танилцана уу.

**Хүснэгт 27.** Үнэт цаас гаргагчийн байгуулсан их хэмжээний хэлцлүүдийн тухай мэдээлэл

| Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Хуулийн шаардлага хангасан эсэх | Гэрээний хэрэгжилт |
|---|---|---|---|
| "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/02-Т-01 тоот "Их хэмжээний хэлцэл хийх тухай" тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар зээл олгох, түүнийг буцаан төлөхтэй холбоотой харилцааг 2017 оны 03 дугаар сарын 30-ний өдөр 18033001 тоот Зээлийн эрх нээх 25 тэрбум төгрөгийн үндсэн гэрээ байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/16-Т тоот "Их хэмжээний хэлцэл хийх тухай" тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар зээлийн эрх нээх, зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, зээлийг эргэн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр 25 тэрбумын Зээлийн эрх нээх гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| "МИК ОССК" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/25Т дугаар "Их хэмжээний хэлцэл батлах тухай" тогтоолоор 40 тэрбумын үнийн дүн бүхий санхүүжилтийг татан төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 12 дугаар сарын 28-ны Зээлийн хөрөнгийн багц худалдах, худалдан авах ерөнхий гэрээ, нэмэлт гэрээ, Үйлчилгээний ерөнхий гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
УЛААНБААТАР ХОТ

## 16.2. Бусадтай байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 18 хэлцэл хийсэн бөгөөд түүнээс 10 хэлцэл нь хэрэгжиж дууссан, 8 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байна. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахын өмнө Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон байна.

Үнэт цаас гаргагчийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн гаргасан хууль зүйн дүгнэлтээс танилцана уу.

**Хүснэгт 28.** Үнэт цаас гаргагчийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн тухай мэдээлэл

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Хуулийн шаардлага хангасан эсэх | Гэрээний хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/02-Т-01 тоот "Их хэмжээний хэлцэл хийх тухай" тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар зээл олгох, түүнийг буцаан төлөхтэй холбоотой харилцааг 2017 оны 03 дугаар сарын 30-ний өдөр 18033001 тоот Зээлийн эрх нээх 25 тэрбум төгрөгийн үндсэн гэрээ байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| | "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/16-Т тоот "Их хэмжээний хэлцэл хийх тухай" тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар зээлийн эрх нээх, зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, зээлийг эргэн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр 25 тэрбумын Зээлийн эрх нээх гэрээ г байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| | "Инвескор Капитал ҮЦК" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/31-Т "Үнэт цаас нээлттэй гаргах тухай" тогтоолоор олгосны дагуу нээлттэй өрийн хэрэгсэл гаргах ажлыг зохион байгуулах, андеррайтер зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Үнэт цаас гаргагч нь төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулах Андеррайтерийн үйлчилгээний гэрээг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |

**Хүснэгт 28.** Үнэт цаас гаргагчийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн тухай мэдээлэл /Үргэлжлэл/

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Хуулийн шаардлага хангасан эсэх | Гэрээний хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 4 | "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/32-Т тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК-ийн Покет аппликэйшнээр дамжуулан олгосон цахим зээлийн авлагын эрх болон түүнд дагалдах эрхүүдийг "Инвескор ББСБ" ХК-д худалдах, "Инвескор ББСБ" ХК нь хэлэлцэн тохирсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахаар 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг, "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК-ийн Покет аппликэйшнээр дамжуулан олгосон цахим зээлийн авлагын эрх болон түүнд дагалдах эрхүүдийг "Инвескор ББСБ" ХК-д тухай бүр худалдах, "Инвескор ББСБ" ХК нь хэлэлцэн тохирсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахаар 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Хөрөнгө худалдах, худалдан авах мастер гэрээг тус тус байгуулахаар тохирчээ. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 5 | Япон улсын иргэн Кавазоэ Такааки | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр А/06 тоот "Зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор тус компанийн хувьцаа эзэмшигч болох Кавазоэ Такаакигийн 1,528,385 ширхэг хувьцааг барьцаалуулан "Инвескор ББСБ" ХК-иас зээл авахад татгалзах зүйлгүй тухай зөвшөөрөл, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/22-Т тоот "Хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй этгээдэд зээл олгохыг зөвшөөрсөн байна.<br><br>Дээрх зөвшөөрлийн дагуу Япон улсын иргэн Кавазоэ Такаакитай В10019060601 тоот Зээлийн эрх нээх гэрээг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 6 | "Эй Ай Лаб" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 12 тоот "Хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Эй Ай Лаб" ХХК-тай Онлайн зээл судалгааны платформ хөгжүүлэх ажил гүйцэтгэх СР-210219-001 дугаартай гэрээг 2021 оны 02 дугаар сарын 19-ны өдөр байгуулсан. Ажлын хөлс: 112,133,367 төгрөг. | Хангасан | Хэрэгжсэн |
| 7 | "Эй Ай Лаб" ХХК | Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/01Б-т тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Эй Ай Лаб" ХХК-тай Чатбот системийн холболт хийх үйлчилгээ үзүүлэх ажил гүйцэтгэх гэрээг 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |
| 8 | "Золотой Стандарт МКК" ХХК | ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/03Т тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Золотой Стандарт МКК" ХХК-тай 2 сая ам.долларын Зээлийн гэрээг 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР

Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн тухай мэдээлэл /Үргэлжлэл/

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Хуулийн шаардлага хангасан эсэх | Гэрээний хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 9 | "Инвескор Проперти" ХХК | ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/01А-1 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Инвескор Проперти" ХХК-тай Модун тауэрт оффис түрээсийн гэрээг 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 10 | "Коло Тинкинг" ХХК | ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 12 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу А7/201201 тоот Покет апп дизайн хөгжүүлэх гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 11 | "Коло Тинкинг" ХХК | ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 12 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу 21/03 тоот Онлайн хурлын систем түрээслэх гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |
| 12 | "Коло Тинкинг" ХХК | ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 12 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу ТС-210621-001 тоот Ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |
| 13 | "Эй Ай Лаб" ХХК | ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 12 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу ТС-210621-001 тоот Мини апп хөгжүүлэх гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |
| 14 | "Инвескор Капитал ҮЦК" ХХК | ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 11-01 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу Р-210726-001 тоот Тавилга худалдах худалдан гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |
| 15 | "Инвескор Капитал ҮЦК" ХХК | ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 11-01 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу CL-210726-001 тоот Санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |
| 16 | "Инвескор Капитал ҮЦК" ХХК | ТУЗ-ийн 2021 оны дугаар сарын 14-ний өдрийн А22/Т тоот тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай 2021 оны 10 сарын 14-ний өдөр С-211014-01 тоот Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг байгуулсан. Уг гэрээгээр 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр байгуулагдсан АҮГ_211014/01 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд дурдсаны дагуу Үнэт цаас гаргагчийн ББЗЗ дээр хаалттай хүрээнд санал болгон гаргах нийт 10,000,000,000 төгрөгийн өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийн биелэлтийг хангах баталгаа болгон зээлийн багц барьцаалахаар зохицуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |

Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн тухай мэдээлэл /Үргэлжлэл/

| № | Гэрээний нэгөө тал | Гэрээний нөхцөл | Хуулийн шаардлага хангасан эсэх | Гэрээний хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 17 | "Инвескор Эй Ай Лаб" ХХК | ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 12 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу 01/2021/08/20 тоот Маркет Плэйс онлайн зах зээлийн систем хөгжүүлэх гэрээг байгуулсан. | Хангасан | Хэрэгжсэн |
| 18 | "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/07-Т тоот "Хоёрдогч өглөгт хөрвүүлэх тухай" тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу бизнесийн эргэлтийн зээлийн зориулалтаар зээл олгох, түүнийг буцаан төлөхтэй холбоотой харилцааг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 211222-01 Хоёрдогч өглөгийн гэрээ байгуулсан. | Хангасан | Хэрэгжиж байгаа |

## 16.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 16,282,237,386 төгрөг бөгөөд үүний 5 хувь нь 814,111,869 төгрөг) бүхий үүрэг хүлээсэн нийт 84 гэрээ байгуулсан. Тэдгээрээс их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг оруулан 2017 оны 2 гэрээ, 2019 оны 3, 2020 оны 7, 2021 оны 31, 2022 оны 15 гэрээ буюу нийт 58 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байгаа, бусад гэрээ нь бүрэн хэрэгжиж дууссан.

## 16.4. Үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээ хэлцэл

Хуулийн зөвлөх нь 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Д-22/198 тоот хууль зүйн дүгнэлтээр Үнэт цаас гаргагч нь дараах ач холбогдол бүхий хэлцлүүдийг байгуулсан гэж үзжээ.

**ББСБ-д зориулсан CBS программ хангамжийн захиалгын гэрээ:** 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ББСБ-д зориулсан CBS программ хангамжийг хөгжүүлж, нийлүүлэх Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан CBS программ хангамжийн захиалгын гэрээг "Дижитал Воркс" ХХК (гүйцэтгэгч)-тай байгуулсан. Энэхүү гэрээгээр бараа бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, нийлүүлэх нөхцөл, гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, оюуны өмч, лицензийн эрх, талуудын эрх, үүрэг, эрх шилжүүлэх, эрсдэл шилжих, нууцлал, гэрээ хүчин төгөлдөр болох, дуусгавар болох, хариуцлага, давагдашгүй хүчин зүйлс, маргаан шийдвэрлэх харилцааг зохицуулсан нь Иргэний хуулийн 31-р бүлэг, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 7.1.1, 18.2, 23.4-д нийцсэн байна.

**Хамтран ажиллах гэрээ:** "Инвескор ББСБ" ХК болон "Эвт Заан Чулуу ББСБ" ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ТС211208-01 дугаартай Хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Энэхүү гэрээгээр Үнэт цаас гаргагч нь нийгмийн хариуцлагын хүрээнд "Эвт Заан Чулуу" ББСБ буюу орон нутгийн ББСБ-ыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, бизнесийн хоршил үүсгэх, тухайлан байгуулсан гэрээнд заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор талуудын хооронд үүссэн харилцааг зохицуулсан байна.

**Хамтран ажиллах гэрээ:** Үнэт цаас гаргагч нь "Сайн Интернэшнл" ХХК-тай ББСБ-ын зээлийн үйлчилгээгээр дамжуулан Гэрээнд заасан өөрийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчид худалдах, Үнэт цаас гаргагч нь худалдсан барааны үнийг төлүүлэх зорилгоор худалдан авагчид зээл олгохтой холбоотой үүссэн харилцааг зохицуулахаар 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 19040401 тоот "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулж, гэрээний хугацааг сунган 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр TE-210403-001 тоот гэрээг шинэчлэн байгуулсан. Гэрээнд гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний талуудын нэр, хаяг, хамтын үйл ажиллагааны зорилго, бэлтгэн нийлүүлэгчийн эрх, үүрэг, банк бус санхүүгийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, гэрээ цуцлах үндэслэл, гэрээний хугацаа, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл заалтуудыг 8 хавсралтуудын хамт тусгасан ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хуульд нийцсэн байна.

**Төлбөр тасалдлын даатгалын гэрээ:** "Монгол Даатгал" ХК, "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-тай Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчийг төлөөлөн Даатгалын зүйлийг харилцан тохиролцсон үнэлгээгээр даатгуулах, Үнэт цаас гаргагч нь Даатгалын зүйлтэй холбоотой бүхий л үүргийг хэрэгжүүлж, даатгалын хураамж төлөх, Даатгагч нь даатгалын тохиолдолд үүсэхэд нөхөн төлбөрийн эрхтэй этгээдэд нөхөн төлбөрийг үл маргах журмаар олгох харилцааг зохицуулсан даатгалын зүйлийн нөхцөлүүд, гэрээний хугацаа, талуудын гаргах баталгаа, талуудын эрх, үүрэг, гэрээний нууцлал, гэрээний хариуцлагын талаар тусгасан TDBC-156/2020 тоот Төлбөр тасалдлын даатгалын гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан.

**Хамтран ажиллах гэрээ:** "МИГ Даатгал" ХХК болон "Инвескор ББСБ" ХК нь 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр TC210701-001 тоот Хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр Даатгагч нь ББСБ-ын бүтээгдэхүүн үйлчилгээг даатгалын үйлчилгээтэй хослуулж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд энэхүү гэрээгээр тохиролцсон нөхцөлийн дагуу Даатгагчийн бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулан ажиллаж, хураамжийн орлого хуваарилах болон бусад эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан.

**Систем хөгжүүлэх гэрээ:** "Эй Ай Лаб" ХХК болон "Инвескор ББСБ" ХК нь 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдөр 01/2021081201 тоот Marketplace Онлайн зээлийн систем хөгжүүлэх ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Энэхүү гэрээгээр "Эй Ай Лаб" ХХК буюу гүйцэтгэгч нь Үнэт цаас гаргагч буюу захиалагчийн захиалга, бизнесийн шаардлагын дагуу "Marketplace онлайн зээлийн систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг алдаа дутагдалгүй хийж гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, гүйцэтгэгчид гэрээнд заасан ажлын хөлс төлөх хэлцлийн нөхцөл, талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулсан байна.

**Лиценз нийлүүлэх гэрээ:** "Инвескор ББСБ" ХК болон "Новелсофт" ХХК нь 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр CC-210512-001 тоот Лиценз нийлүүлэх гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр "Новелсофт" ХХК буюу нийлүүлэгч нь Tableau BI /лиценз/-г тогтоосон хугацаанд "Инвескор ББСБ" ХК буюу захиалагчийн эзэмшилд шилжүүлэх, захиалагч нь лицензийг хүлээн авах, төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулсан байна. Тус гэрээ нь Иргэний хуулийн 22-р бүлэгт заасан Худалдах худалдан авах харилцааг зохицуулсан зохицуулалтуудыг дордуулсан зүйлгүй байна.

**Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ:** "Инвескор ББСБ" ХК болон "Грант Торнтон аудит" ХХК нь 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 2021/67 тоот Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу "Грант Торнтон Аудит" ХХК нь "Инвескор ББСБ" ХК болон түүний охин компаниудын 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайланд холбогдох хууль журмын дагуу аудит хийж, дүгнэлтээ тогтоосон хугацаанд ирүүлсэн болно.

**Контрактын гэрээ:** "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу Д.Баясгалантай 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр А/40-Т тоот контрактын гэрээг байгуулсан. Компанийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нь Компанийн тухай хууль болон контрактад заасан эрх, үүргээ биелүүлэн, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнан ажиллаж байна.

**Оффис түрээсийн гэрээ болон ажлын байр түрээсийн гэрээ:** "Инвескор ББСБ" ХК нь ажлын байрны зориулалтаар "Хурган Мөнх" ХХК-тай 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Оффис түрээсийн гэрээ, "Роял Парк" ХХК-тай 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр R20021201 тоот Ажлын байр түрээсийн гэрээг тус тус байгуулсан. Компани 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр "Роял Парк" ХХК-тай байгуулсан гэрээнд нэмэлт оруулан, R200221201-1 тоот Түрээсийн гэрээний нэмэлтийг баталсан.

СЗХ
он 2022 сар 11. 03 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 17. Үнэт цаас олон нийтэд санал болгох тухай

17.1. Үнэт цаас гаргах үндэслэл, зорилго

17.2. Үнэт цаасны нөхцөл

17.3. Үнэт цаасны үнэ, хүүгийн түвшин тогтоосон үндэслэл

17.4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

17.5. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын өгөөж

17.6. Санхүүжих чадавхийн зэрэглэл

17.7. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
Үнэт цаас гаргагч
УЛААНБААТАР ХОТ

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК

# 17. Үнэт цаас олон нийтэд санал болгох тухай

## 17.1. Үнэт цаас гаргах үндэслэл, зорилго

Үнэт цаас гаргагч нь харилцагчдадаа урт хугацаанд тогтвортой зээлээр хангаж, санхүүгийн найдвартай түнш, дэмжигч нь байхыг эрмэлздэг бөгөөд энэ зорилгын хүрээнд бусдаас санхүүжилтын эх үүсвэр татан төвлөрүүлэх шаардлагатай болдог. Үнэт цаас гаргагч нь зах зээлийн нөхцөл байдал, өөрийн санхүүгийн үзүүлэлт, дотоод нөөц боломжоо зэргийг үндэслэн үнэт цаас гаргах шийдвэрийг гаргасан бөгөөд уг үнэт цаас гаргалт нь компанийн зээл олголт болон ашигт ажиллагааг нэмэгдүүлж, харилцагчид болон хөрөнгө оруулагчдад үнэ цэнэ бий болгоно гэж үзсэн.

Мөн СЗХ-ны 2021 оны 06-р сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын Дөрөвдүгээр бүлэгт Бонд гаргах хөтөлбөрийг зохицуулж, тодорхой хугацааны туршид хэд хэдэн удаагийн гаргалт бүхий бондын хөтөлбөрийг гаргахыг зөвшөөрч зохицуулсан нь үнэт цаас гаргагчдын хувьд тогтвортой, тогтмол санхүүжилт татах, үйл ажиллагаагаа санхүүжүүлэх боломжийг олгосон юм. Иймд "Инвескор ББСБ" ХК нь өөрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зээлийн бүтээгдэхүүнээр хангах эх үүсвэрийн боломжтой байх зорилгоор нийт 12 сарын хугацаанд хэрэгжүүлж дуусгах Өрийн хэрэгслийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болно.

## 17.2. Үнэт цаасны нөхцөл

"Инвескор ББСБ" ХК нь дараах нөхцөл бүхий нээлттэй өрийн хэрэгсэл буюу үнэт цаас гаргах хөтөлбөрийг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд санал болгож хэрэгжүүлнэ.

| | |
|---|---|
| **Үнэт цаасны бүртгэл** | Монголын Хөрөнгийн Бирж |
| **Үнэт цаасны төрөл** | Энгийн хүүтэй бонд |
| **Үнэт цаасны арилжаа** | Олон нийтэд |
| **Хөтөлбөрийн нийт үнийн дүн** | 50.0 тэрбум төгрөг хүртэлх |
| **Нэгж үнэт цаасны нэрлэсэн үнэ** | 100,000 төгрөг |
| **Нийт тоо, ширхэг** | 500,000 ширхэг хүртэлх |
| **Анхдагч зах зээлд хэсэгчлэн гаргаж арилжаалах хуваарь** | Нээлттэй бондыг хэсэгчлэн гаргах хугацаа, хүү, хэмжээг тухай бүрд нь Компанийн Гүйцэтгэх захирал тогтооно |
| **Үнэт цаасны хугацаа** | 12 - 24 сар |
| **Үнэт цаасны хүү** | 15 - 18 хувь |
| **Хүү төлөх давтамж** | Улирал тутам |
| **Үндсэн төлбөр төлөгдөх** | Транч бүрийн хугацааны эцэст |
| **Үнэт цаасны зарцуулалт** | Компанийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулах |
| **Үнэт цаасны барьцаа / баталгаа, эргэн төлөлт** | Үнэт цаас гаргагчийн хүү, шимтгэлийн орлого болон харилцагчдад олгосон зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтүүд нь бондын эргэн төлөлтийг санхүүжүүлнэ.<br><br>Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 сарын 19-ний өдрийн 28 тоот тогтоолын дагуу нээлттэй бондын эргэн төлөлтийн баталгааг толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй 71.5 тэрбум төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаагаар хангахаар шийдвэрлэсэн.<br><br>Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь 2022 оны 09 сарын 19-ний өдрийн 9 тоот Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр 71.5 тэрбум төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцааг уг үнэт цаасны эргэн төлөлтийн баталгаа болгож барьцаалуулахыг зөвшөөрсөн ба 2022 оны 10 сарын 20-ны өдрийн 12 тоот Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт батлан даалт гаргахыг зөвшөөрсөн болно. |
| **Хадгалалт, төлбөр тооцоо** | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ТӨХХК |
| **Бусад давуу талууд** | МХБ-н хоёрдогч зах зээл дээр бусад этгээдэд худалдан борлуулах боломжтой<br><br>Хүүгийн орлогын албан татвар 5% |

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-21 БҮРТГЭВ-02

## 17.3 Үнэт цаасны үнэ, хүүгийн түвшин тогтоосон үндэслэл

### 17.3.1. Үнэт цаасны үнэ, хүүгийн түвшин тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад санал болгох Үнэт цаасны өгөөж буюу хүүгийн түвшинг зах зээлийн хүүгийн түвшин, компанийн нэр хүнд, санхүүгийн үзүүлэлттэй уялдуулан тогтоосон.

2022 оны 6 сарын байдлаар томоохон 5 арилжааны банкны 24 сарын хугацаатай хадгаламжийн жилийн дундаж хүү нь 9.8% байгаа бөгөөд "Инвескор Бондын 2.0"-ийн хувьд уг дундаж хүүний түвшингээс 5.2 - 8.2 нэгжээр илүү байна.

**График 49.** Банкуудын иргэдийн 24 сарын хугацаатай хадгаламжийн жилийн хүү, хувиар




**Эх сурвалж:** Арилжааны банкнуудын вэб сайт

Хүүгийн орлогын албан татварыг тооцож үзвэл арилжааны банкуудын хадгаламжийн дундаж хүү цэврээр 8.8% бол Инвескор бондынх 14.3 - 17.1% буюу 5.5 – 8.3 нэгжээр илүү байхаар байна.

"Инвескор ББСБ" ХК-ийн хувьд хөрөнгө оруулагчдад санал болгох өгөөжийн хэмжээг зах зээл дээр өрсөлдөхүйц байлгах, төр болон хувийн хэвшлийн зүгээс хэрэгжүүлж буй зээлийн хүүг бууруулах санал, арга хэмжээнүүдийг судалж үзсэний үндсэн дээр уг хүүгийн хувийг тогтоосон болно.

### 17.3.2. Үнэт цаасны зах зээл – бусад үнэт цаасны судалгаа

2022 оны 6 сарын байдлаар Монголын Хөрөнгийн Биржийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээл идэвхтэй санал болгосон үнэт цаас байхгүй байна. Харин хоёрдогч зах зах зээл дээр Инвескор ББСБ ХК-ийн 2021 онд гаргасан бондоос гадна 2021 оны 3 сард "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гаргасан "ЭТТ Бонд /төгрөг/ " болон "ЭТТ Бонд /ам.доллар/", 2021 оны 7 сар болон ЛэндМН ББСБ ХК-ийн гаргасан Лэнд Бонд, 12 болон 2022 оны 4 сард гаргасан Лэнд Бонд Хөтөлбөр, "Мобифинанс ББСБ" ХХК-ийн "Мон Пэй" тус тус арилжаалагдаж байна.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

Хүснэгт 29. МХБ дээр арилжаалагдсан төгрөгийн өрийн хэрэгслүүд, 2015 - 2022

| Компанийн нэр | Гаргасан огноо | Хугацаа | Жилийн хүү | Бодлогын хүү | Зөрүү | Нийт тэрбум төгрөг |
|---|---|---|---|---|---|---|
| Эрчим Инженеринг | 2015 | 1 жил | 18.50% | 13.00% | 5.50% | 0.5 |
| Сүү ХК | 2017.06.19 | 1 жил | 17.50% | 12.00% | 5.50% | 6 |
| "Инвескор ББСБ" ХК | 2020.11.12 | 2 жил | 14.40% | 6.00% | 8.40% | 4 |
| "Микро Кредит ББСБ" ХК | 2020.11.12 | 2 жил | 14.40% | 6.00% | 8.40% | 4 |
| "Эрдэнэс Тавантолгой" ХК | 2021.03.19 | 2 жил | 10.00% | 6.00% | 4.00% | 236.6 |
| "Инвескор ББСБ" ХК | 2021.05.03 | 2 жил | 13.00% | 6.00% | 7.00% | 20 |
| "ЛэндМН ББСБ" ХК | 2021.05.29 | 1 жил | 14.00% | 6.00% | 8.00% | 5 |
| "Мобифинанс ББСБ" ХК | 2021.08.31 | 1 жил | 14.00% | 6.00% | 8.00% | 1 |
| "Омни Актив ТЗК" ХХК | 2022.01.28 | 2 жил | 14.50% | 6.50% | 8.00% | 5 |
| "ЛэндМН ББСБ" ХК | 2022.03.23 | 2 жил | 15.00% | 9.00% | 6.00% | 3.1 |
| "Инвескор ББСБ" ХК | 2022 | 2 жил | 15-18.0% | 10.00% | 5-8.00% | 50 |

Монголын Хөрөнгийн Бирж дээр гарсан нээлттэй бондууд нь эдийн засаг, зах зээлийн өөр өөр нөхцөл байдалд гарсан тул бодит хүүгийн түвшнийг тухайн үеийн бодлогын хүүтэй харьцуулж тооцлоо. Эндээс харахад бодит хүүгийн хувь 5-8% буюу "ЛэндМН ББСБ" ХК болон "Омни актив ТЗК" ХХК нарын гаргасан бондуудтай ижил түвшинд байна.

Хаалттай бондуудын хүү нь зах зээлийн зарчмаар нээлттэй бондуудаас бага зэрэг өндөр байдаг. Учир нь нээлттэй бонд нь доорх давуу талуудтай юм.

- ✓ Хүүгийн орлогын албан татварын хөнгөлөлт (нээлттэй бонд 5%-ийн татвар, хаалттай бонд болон хадгаламжинд 10%-ийн татвар тус тус ногдуулна);
- ✓ Хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжаалах буюу үнэт цаасны эзэмших эрхээ шилжүүлэх боломж;
- ✓ Хууль, журмын илүү нарийн зохицуулалттай;
- ✓ Хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс илүү хамгаалах зохицуулалттай;

Мөн "Инвескор ББСБ" ХК-ийн олон нийтэд санал болгож буй өрийн хэрэгсэл нь доорх ялгарах онцлог, давуу талуудтай байна. Үүнд:

- ✓ Хороонд бүртгүүлснээс хойш 12 сарын хугацаанд хөтөлбөр хэлбэрээр, Транчуудад хувааж гаргах тул хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад илүү уян хатан;
- ✓ Улирал тутам тогтмол өгөөж хүртэнэ;
- ✓ "Инвескор ББСБ" ХК-ийн онцгой амжилт, ирээдүйн өсөлт, хөгжлөөр эргэн төлөлт баталгаажсан;
- ✓ Өрийн хэрэгслийн эргэн төлөлтийн баталгаа болгож "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй "Инвескор ББСБ" ХК-ийн 71.5 тэрбум төгрөг хүртэлх үнэлгээтэй хувьцааг барьцаалсан ба нэмэлтээр "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь үнэт цаасны эргэн төлөлтөд батлан даалт гаргасан;
- ✓ Инвескор ББСБ" ХК болон Андеррайтерийн хувьд өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхтэй байлгах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ;

"ИНВЕСКОР ББСБ" ХК
УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК

## 17.4. Татан Төвлөрүүлэх Хөрөнгийн Зарцуулалт

"Инвескор ББСБ" ХК-ийн нээлттэй өрийн хэрэгслийн хөтөлбөрийн хүрээнд татан төвлөрүүлэх хөрөнгийг компанийн үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

### Бизнесийн зээл

Бизнесийн зээлийн багцын гол өсөлтийг жижиг, дунд сегментийн зорилтот харилцагч нарт олгох зээлийн багцаар бүрдүүлнэ.

Инвескор Аллианс хөтөлбөрт нэгдсэн ББСБ-уудад зээлийн шугам нээж орон нутгийн бизнес эрхлэгч нарыг дэмжинэ.

SMB (Сэмбий) хөтөлбөрийн хүрээнд зорилтот буюу дэмжих салбарын бизнес эрхлэгч нарт хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгоно.

Зээлийн батлан даалтын сан болон Тогтвортой санхүүгийн холбоотой хамтран ажиллаж барьцаа хөрөнгийн дутагдалтай, үйл ажиллагаа тогтворжсон харилцагч нарт бизнесийн зээл олгоно.

Ногоон зээл, ногоон санхүүжилтын санаачилгыг дэмжиж зээлийн багцыг бүрдүүлнэ. Ногоон зээл авсан харилцагч нарыг мөн SMB хөтөлбөрт хамруулна.

**Хүснэгт 30.** Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

| Зарцуулалт | Эзлэх хувь |
|---|---|
| Харилцагчдад олгох зээлийн багцыг санхүүжүүлэх | 100% |

### Автомашины зээл

Автомашины зээлийн багцыг өсгөхдөө Үнэт цаас гаргагч нь зөв талдаа жолооны хүрдтэй, насжилт багатай тээврийн хэрэгслүүдийг болон цахилгаан хөдөлгүүртэй, байгальд ээлтэй автомашинуудыг илүү дэмжиж ажиллана. Мөн өрхийн болон байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын зээлийг түлхүү олгох замаар хүнс, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, уул уурхайн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

### Финтек зээл

"Инвескор ББСБ" ХК нь өөрийн эх үүсвэрээр нийт Покет аппликейшнээр богино хугацаат болон урт хугацаат зээлийн багцын 70 хувийг бүрдүүлэх төлөвлөгөөтэй байна. Покет платформ нь 2022 оны эхний хагаст багтаан цахим зээлийн гэрээ байгуулах шийдлийг харилцагч нарт санал болгох бөгөөд 2022 онд байгуулах нийт гэрээний 60 хувийг цахимаар байгуулахаар төлөвлөж байна. Орон нутаг дахь зээлийн багцын тэлэлтийг онцгой анхаарч нийт 10 аймагт гэрээ байгуулах боломжийг бүрдүүлнэ. "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК-ийн хувьд үндсэн 3 салбартайгаар ажиллах бол явуулын хөдөлгөөнт 10 цэгийг ажиллуулна.

### Хэрэглээний зээл

Хамтран ажиллаж буй худалдааны байгууллагуудад таблет шийдлийг нэвтрүүлэх, зээлийн судалгааны процессыг сайжруулах замаар зээлийн судалгааны хугацааг богиносгоно. Сайн зээлийн түүхтэй давтан зээл авч буй харилцагчдыг онцгойлон анхаарч тусгай нөхцөл санал болгох замаар зээлийн эрсдэлээ бууруулж борлуулалтаа нэмэгдүүлэх юм. Бүх салбаруудад дижитал салбарын дэвшилтэт технологи, шийдлүүдийг нэвтрүүлэх замаар хосолсон бүтэцтэй болгох ба ингэснээр хүний нөөцийн болон бусад зардлуудыг бууруулж, харилцагчдын цаг завыг хэмнэнэ.

СЭХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2
БҮРТГЭВ-02

Инвескор Санхүүгийн Группийн хэмжээнд дагаж мөрдөх төслийн удирдлагын тогтолцоог шинэчлэн хөгжүүлж, олон улсын жишиг стандартуудыг нэвтрүүлж байгаа бөгөөд ингэснээр төслийн санаа гаргахаас эхлүүлээд амжилтай дуусаж бодит үр дүнгээ гаргах хүртэлх бүхий л процессыг үр ашигтай удирдах юм.
Үнэт цаас гаргагч нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, процессыг сайжруулах, зардлаа хэмнэх сайн төслүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлэх замаар стратегийн давуу талаа нэмэгдүүлж ашигт ажиллагааны түвшнийг тогтмол өсгөж ажиллах болно.

## 17.5. Үнэт Цаасны Хөрөнгө Оруулалтын Өгөөж

Санал болгож буй өрийн хэрэгслийн хугацаа нь 2 жил, хүүгийн хувь хэмжээ нь жилийн 15%-18% байна гэж төсөөлвөл хөрөнгө оруулагч 10 сая төгрөгийн буюу 100 ширхэг бонд худалдан авсан тохиолдолд 2 жилийн хугацаанд хүртэх өгөөжийн тооцооллыг доорх жишээнээс харна уу.

**Хүснэгт 31.** Үнэт цаасны хөрөнгө оруулалтын өгөөж, төгрөгөөр

| | | | | |
|---|---|---|---|---|
| Анхны хөрөнгө оруулалт | 10,000,000 | 10,000,000 | 10,000,000 | 10,000,000 |
| Жилийн хүү | 15% | 16% | 17% | 18% |
| Хүүгийн орлого/нийт/ | 3,000,000 | 3,200,000 | 3,400,000 | 3,600,000 |
| Хүүгийн орлогын татвар | 150,000 | 160,000 | 170,000 | 180,000 |
| Нийт өгөөж | 2,850,000 | 3,040,000 | 3,230,000 | 3,420,000 |
| Нийт өгөөжийн хувь | 28.50% | 30.40% | 32.30% | 34.20% |

**Хүснэгт 32.** Үнэт цаасны жилийн өгөөж 15 хувь бол хөрөнгө оруулалтын өгөөж, төгрөгөөр

| Төлбөр хийгдэх хугацаа /Үнэт цаас авснаас хойш/ | Хүүний төлбөр /татварын дараах/ | Үндсэн төлбөр | Нийт төлбөр |
|---|---|---|---|
| +3 сар | 356,250 | | 356,250 |
| +6 сар | 356,250 | | 356,250 |
| +9 сар | 356,250 | | 356,250 |
| +12 сар | 356,250 | | 356,250 |
| +15 сар | 356,250 | | 356,250 |
| +18 сар | 356,250 | | 356,250 |
| +21 сар | 356,250 | | 356,250 |
| +24 сар | 356,250 | 10,000,000 | 10,356,250 |
| **Нийт** | **2,850,000** | **10,000,000** | **12,850,000** |

**Хүснэгт 33.** Үнэт цаасны жилийн өгөөж 16 хувь бол хөрөнгө оруулалтын өгөөж, төгрөгөөр

| Төлбөр хийгдэх хугацаа /Үнэт цаас авснаас хойш/ | Хүүний төлбөр /татварын дараах/ | Үндсэн төлбөр | Нийт төлбөр |
|---|---|---|---|
| +3 сар | 380,000 | | 356,250 |
| +6 сар | 380,000 | | 356,250 |
| +9 сар | 380,000 | | 356,250 |
| +12 сар | 380,000 | | 356,250 |
| +15 сар | 380,000 | | 356,250 |
| +18 сар | 380,000 | | 356,250 |
| +21 сар | 380,000 | | 356,250 |
| +24 сар | 380,000 | 10,000,000 | 10,380,00 |
| **Нийт** | **3,040,000** | **10,000,000** | **13,040,000** |

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 ... 1119286063
УЛААНБААТАР ХОТ

Хүснэгт 34. Үнэт цаасны жилийн өгөөж 17 хувь бол хөрөнгө оруулалтын өгөөж, төгрөгөөр

| Төлбөр хийгдэх хугацаа /Үнэт цаас авснаас хойш/ | Хүүний төлбөр /татварын дараах/ | Үндсэн төлбөр | Нийт төлбөр |
|---|---|---|---|
| +3 сар | 403,750 | | 403,750 |
| +6 сар | 403,750 | | 403,750 |
| +9 сар | 403,750 | | 403,750 |
| +12 сар | 403,750 | | 403,750 |
| +15 сар | 403,750 | | 403,750 |
| +18 сар | 403,750 | | 403,750 |
| +21 сар | 403,750 | | 403,750 |
| +24 сар | 403,750 | 10,000,000 | 10,403,750 |
| **Нийт** | **3,230,000** | **10,000,000** | **13,230,000** |

Хүснэгт 35. Үнэт цаасны жилийн өгөөж 18 хувь бол хөрөнгө оруулалтын өгөөж, төгрөгөөр

| Төлбөр хийгдэх хугацаа /Үнэт цаас авснаас хойш/ | Хүүний төлбөр /татварын дараах/ | Үндсэн төлбөр | Нийт төлбөр |
|---|---|---|---|
| +3 сар | 427,500 | | 427,500 |
| +6 сар | 427,500 | | 427,500 |
| +9 сар | 427,500 | | 427,500 |
| +12 сар | 427,500 | | 427,500 |
| +15 сар | 427,500 | | 427,500 |
| +18 сар | 427,500 | | 427,500 |
| +21 сар | 427,500 | | 427,500 |
| +24 сар | 427,500 | 10,000,000 | 10,427,500 |
| **Нийт** | **3,420,000** | **10,000,000** | **13,420,000** |

## 17.6. Үнэт цаасны эргэн төлөлтийн баталгаа / барьцаа

Үнэт цаас гаргагчийн хүү, шимтгэлийн орлого болон харилцагчдад олгосон зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтүүд нь бондын эргэн төлөлтийг санхүүжүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 сарын 19-ны өдрийн 28 тоот тогтоолын дагуу нээлттэй үнэт цаасны эргэн төлөлтийн баталгааг толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй 71.5 тэрбум төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаагаар хангахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолыг Үнэт цаасны танилцуулгын 122-р хуудаснаас харна уу.

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нийт 60,968,730 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг бөгөөд үүнээс 71.5 тэрбум төгрөг хүртэлх үнэлгээ бүхий хувьцаа (цаашид "Барьцааны зүйл" гэх)-г Үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүргийн баталгаа болгож, Барьцаалагчид барьцаалуулахыг зөвшөөрч, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн 9 тоот шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргасан болно. Уг шийдвэрийг Үнэт цаасны танилцуулгын 123-р хуудсанд тусгасан болно. Мөн Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн талаарх мэдээлэл болон сүүлийн 2 жилийн аудитлагдсан санхүүгийн үр дүнг Үнэт цаасны танилцуулгын 124-125-р хуудаснаас харна уу.

Үүний дагуу Барьцаалагч буюу Үндсэн Андеррайтер (Таванбогд Капитал ҮЦК ХХК), Барьцаалуулагч (Эс Ай Би Жэй Капитал ХХК), Үүрэг гүйцэтгэгч (Инвескор ББСБ ХК) нар нь 2022 оны 09 сарын 20-ны өдөр БГ-220920/01 тоот "Хувьцааны барьцааны гурван талт гэрээ" байгуулсан байна.

17

Уг гэрээний зорилго нь Үүрэг гүйцэтгэгчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 06 сарын 22-ны өдрийн 21 тоот "Үнэт цаас нээлттэй гаргах тухай" тогтоолын үндсэн дээр Нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн эргэн төлөлтийн баталгаа болгож Барьцаалуулагч нь өөрийн хууль ёсны эрхийн дагуу эзэмшиж буй "Инвескор ББСБ" ХК-ийн 71.5 тэрбум төгрөг хүртэл үнэлгээ бүхий 17,006,803 ширхэг хувьцааг Барьцаалагчид барьцаалуулах, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг Үүрэг гүйцэтгэгч хариуцахтай холбогдсон хэлцлийн нөхцөл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон бий болох Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

Барьцааны зүйлийн үнэлгээг Санхүүгийн Зохицуулах Хорооны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.7 дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 09 сарын 15-ны өдрийн байдлаарх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцсон ба үүний дагуу нэгж хувьцааны үнэлгээ 4200 төгрөг, нийт барьцаа хөрөнгийн үнэлгээ нь 71,428,571,429 (далан нэгэн тэрбум дөрвөн зуун хорин найман сая таван зуун далан нэгэн мянга дөрвөн зуун хорин есөн) төгрөг байна.

Үүрэг гүйцэтгэгч нь Андеррайтерийн гэрээ болон өрийн бичгийн дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, хүү, алданги болон Андеррайтерийн гэрээтэй холбоотой бий болсон бусад төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд Барьцаалагчийн барьцааны эрх хүчинтэй байна.

Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс Үүрэг гүйцэтгэгч буюу Үнэт цаас гаргагчийн нээлттэй хүрээнд гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэхийг зөвшөөрсөн тогтоол гаргасан тохиолдолд Барьцаалагч нь хөтөлбөрийн хүрээнд өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгох бүрд санал болгож буй өрийн хэрэгслийн үндсэн төлбөрийн зээл-үнэлгээний харьцаа (LTV) үзүүлэлт 70 хувь байхаар тооцож тухай бүрд нь барьцаа бүртгүүлнэ. Ингэхдээ хувьцааны тухайн үеийн сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг баримтална.

Барьцааг бүртгүүлэхдээ хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг үйлдэж, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим мэдээллийн санд бүртгүүлэх ба Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасыг барьцаалах тухай журам"-д заасны дагуу ҮЦТХТ-д бүртгүүлж тусгаарлуулна.

Барьцааны зүйлийн зах зээлийн үнэлгээ буурч, өрийн бичгийн үндсэн төлбөрийн зээл-үнэлгээний харьцаа (LTV) үзүүлэлт 70 хувиас хэтэрсэн тохиолдолд Барьцаалуулагч нь тус харьцаа үзүүлэлтийг 70 хувиас хэтрэхгүй байхаар тооцоолон энэ гэрээнд заасан нөхцөл журмын дагуу нэмж хувьцаа барьцаалах үүрэг хүлээнэ.

**Толгой компанийн батлан даалт**

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Эс Ай Би Жэй Капитал" ХХК нь 2022 оны 10 сарын 20-ны өдрийн 12 тоот Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр охин компани болох "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан гаргах 50 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнтэй нээлттэй бондын үндсэн болон хүүгийн төлбөрт батлан даалт гаргахыг зөвшөөрсөн болно. Уг шийдвэрийг Үнэт цаасны танилцуулгын 123/2-р хуудсанд тусгасан болно.

Үүний дагуу Барьцаалагч буюу Үндсэн Андеррайтер (Таванбогд Капитал ҮЦК ХХК), Батлан даагч (Эс Ай Би Жэй Капитал ХХК), Үүрэг гүйцэтгэгч (Инвескор ББСБ ХК) нар нь 2022 оны 10 сарын 20-ны өдөр БГ-221020/01 тоот "Батлан даалтын гэрээ" байгуулсан байна.

СЗХ
2022.11.02
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

## 17.7. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

### 17.7.1. Үнэт цаас эзэмшигчийн эрх

- Үнэт цаас гаргагчийн гаргаж буй Үнэт цаасыг худалдан авсан эзэмшигч нь холбогдох хууль журмуудад заасны дагуу доорх эрхүүдийг эдэлнэ. Үүнд:
- Үнэт цаас гаргагч, Үнэт цаастай холбоотой мэдээллийн талаар бие даасан хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийн санхүү, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргах эрхтэй.
- Үнэт цаасны үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй.
- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд бүрэн төлөхийг шаардах эрхтэй.
- Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны мэдээллийн ил тод байдлын журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн мэдээллийг авах эрхтэй.
- Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн мэдээлэлтэй танилцах эрхтэй.
- Үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж дээрээс худалдан авах, хоёрдогч зах зээл дээр арилжаалах, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гуравдагч этгээдэд шилжүүлэх, захиран зарцуулах эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон, үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан эсхүл эд хөрөнгөгүй болсон тохиолдолд тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.

### 17.7.2. Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагч нь СЗХ-оос баталсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам" болон түүний хасвралтад заасны дагуу холбогдох мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгө, санхүүгийн байдал болон үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.
- Өрийн хэрэгслийн хугацаа дуусах үед хуримтлагдсан хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрийг бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох журамд заасны дагуу өөрийн санхүүгийн болон бусад байдлын талаар үнэн зөв мэдээллийг тогтмол мэдээлэх үүрэгтэй.

17

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он 2022 сар 11 өдөр 09
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

- Үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад заасан зориулалтаар захиран зарцуулах үүрэгтэй.

- Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирол, алдангийг үл маргах журмаар төлж барагдуулах үүрэгтэй.

- Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрлах өөрийн дансанд шилжүүлэх үүрэгтэй.

### 17.8. Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн хооронд байгуулагдсан Бондын гэрээ

Үнэт цаас гаргагч болон Үндсэн Андеррайтер нь 2022 оны 10-р сарын 20-ны өдөр FL-221020-001 тоот Бондын гэрээг СЗХ-ны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3.6 дахь хэсэгт заасны дагуу байгуулсан болно. Талууд тус гэрээнд бондын нөхцөлүүд болох нэрлэсэн үнэ, тоо, хугацаа, төрөл, хүүгийн төрөл, түвшин, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хуваарийн талаар оруулсан байх ба мөн захиалга авах журам, төлбөрийн тасалдал болон үнэт цаас гаргагчийг төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, Үнэт цаас гаргагчийн мэдээлэл өгөх үүрэг зэрэг журамд тусгасан асуудлыг зохицуулсан байх бөгөөд Хуулийн фирмээс уг гэрээг холбогдох хууль, тогтоомжид нийцсэн болох тухай дүгнэлт гаргасан байна.

СЗХ
он 2022 сар 11 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ИНВЕСКОР
БОНД 2.

# 18. Үнэт цаас арилжаалах нөхцөл

18.1. Үнэт цаас эзэмших харилцааны эрх зүйн зохицуулалт

18.2 Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр

18.3 Зохицуулагч байгууллагын шийдвэр

18.4 Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах

18.5 Хөтөлбөрийн хүрээнд Үнэт цаас хэсэгчлэн гаргах

18.6 Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах

18.7 Хуваарилалт

18.8 Захиалгын үнийг буцаан олгох

18.9 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

18.10 Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар

18.11 Арилжааны шимтгэл

18.12 Албан татвар

18.13 Валютын ханш

18.14 Бүхэлчлэх

18.15 Хэл

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286083
УЛААНБААТАР ХОТ

# 18. Үнэт цаас арилжаалах нөхцөл

## 18.1. Үнэт цаас эзэмших харилцааны эрх зүйн зохицуулалт

Үнэт цаас эзэмшигчийн нээлттэй өрийн хэрэгсэл эзэмшихтэй холбоотой харилцааг Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмын холбогдох зүйл заалтаар тус тус зохицуулна.

## 18.2. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр

Үнэт цаас гаргагч нь бондын анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 4 дүгээр бүлэгт заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Тогтоосон үнийн аргаар арилжааг явуулахад хөрөнгө оруулагч нь худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед цаг хугацааны болон үнийн ахлах дараалал үйлчлэхгүй.

## 18.3. Зохицуулагч байгууллагын шийдвэр

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг МХБ болон СЗХ-д нэгэн зэрэг гаргах бөгөөд уг арилжаа эрхлэх болон зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь Үнэт цаасны транч бүрт анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын тавааc доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх тухай мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлд захиалга авч эхлэх болон үргэлжлэх хугацаа, санал болгох бондын хэмжээ, үнэ зэргийн талаарх мэдээллийг тусгасан байна.

Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг авч дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор хуваарилалтыг хийн, тайланг МХБ-ийн дүгнэлтийн хамт СЗХ-д хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон МХБ-д үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

## 18.4. Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах

СЗХ болон МХБ-ээс Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалахыг зөвшөөрсний дараа Үнэт цаасны танилцуулгыг нийтэд нээлттэй байршуулах бөгөөд үнэт цаасны транч тус бүрийн анхдагч зах зээлийн захиалга эхлэхээс өмнө ажлын 10 өдөрт багтаан үнэт цаас болон тухайн транчийн мэдээллийг олон нийтэд танилцуулах, сурталчлах аяныг зохион байгуулна.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь дээрх ажиллагааг хийхээс өмнө мэргэжлийн хөрөнгө оруулагч болон стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулж болно.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь Үнэт цаасны танилцуулгыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сар тутамд шинэчлэн Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

## 18.5. Хөтөлбөрийн хүрээнд Үнэт цаас хэсэгчлэн гаргах

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлд заасны дагуу хэсэгчлэн /транчтайгаар/ гаргах бөгөөд хэсэгчлэн гаргах хугацаа, хэмжээ, хүүгийн түвшин болон бусад нөхцөлийг тухай бүрд нь Компанийн Гүйцэтгэх захирал тогтооно.

## 18.6. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь Үнэт цаасны транч тус бүрийн анхдагч зах зээлийн захиалга авах хугацааг тогтоох бөгөөд уг хугацаа нь ажлын 5 өдрөөс илүүгүй байна. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авахад дараах нөхцөл үйлчилнэ.

- ✓ Олон нийтэд санал болгох үнэт цаасны худалдан авах захиалгыг МХБ-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.
- ✓ Үнэт цаас гаргагчийн харилцагч нь бусад үнэт цаасны компани сонгон үйлчлүүлж, худалдан авах захиалга өгөх бүрэн боломжтой.
- ✓ Үнэт цаасны арилжааны захиалга эхлэх болон дуусах хугацааг Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь СЗХ-оос шийдвэр гаргасны дараа МХБ-тэй хамтран тогтооно.
- ✓ Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг андеррайтер компани болон Үнэт цаас гаргагч хамтран стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулагчдаас тусгайлан авна.
- ✓ Үнэт цаасны арилжааны захиалга авах ажиллагааг МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжааны программаар зохион байгуулна.
- ✓ Хөрөнгө оруулагч анхдагч зах зээлийн захиалгын хугацаанд Үнэт цаас гаргагчийн тогтоосон үнээр тоо ширхэг, нийт үнийн дүнг зааж захиалга өгнө. Хөрөнгө оруулагч анхдагч зах зээлийн захиалга эхлэхээс өмнөх хугацаанд өөрийн харилцдаг үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгсөн нөхцөлд уг захиалга нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгын үед арилжааны программд шивэгдэж орно.

## 18.7. Хуваарилалт

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь тухайн транчийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа үргэлжлэх хугацаанд санал болгож буй Үнэт цаасыг худалдан авах захиалга санал болгож буй үнэт цааснаас давсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан хуваарилалт хийнэ.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь зөвшилцөж олон нийтэд хуваарилах үнэт цаасны худалдан авах захиалгын бүрэн биелэх нөхцөл бүхий хэмжээг тогтоож болох бөгөөд энэ талаар МХБ-д хүргүүлж, Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга эхлэхээс өмнө МХБ-ээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ. Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь зөвшилцөж үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг арилжааны захиалга эхлэхээс өмнө МХБ-д хүргүүлнэ.

18

## 18.8. Захиалгын үнийг буцаан олгох

Үнэт цаасны худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс давсантай холбоотойгоор хувь тэнцүүлэн хуваарилалт хийсэн тохиолдолд Захиалагч нь биелэгдээгүй захиалгын үнийг өөрийн үнэт цаасны компаниар дамжуулан буцаан авах эрхтэй. Захиалгын үнийг буцаан авахтай холбоотой тухайн үнэт цаасны компанийн тогтоосон шимтгэл хураамж төлөх шаардлагатай болж болзошгүйг анхаарна уу.

СЗХ
он... сар... өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2

## 18.9. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь транч тус бүрийн анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-д хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ. ҮЦТХТ болон МХБ нь уг зөвшөөрлийг хүлээн авснаар үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

## 18.10. Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар

Хөрөнгө оруулагч нь МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах заврын дагуу бонд худалдан авах мөнгөн хөрөнгө байршуулах ба өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалгаа өгнө.

**Схем 8.** Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар

**Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар**

Биржид бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэх

**Данс нээлгэх**

Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа бонд худалдан авах захиалга өгнө мөнгөө байршуулна.

**Захиалга өгөх**

Үнэт цаасны дансанд Хүснэгт 37 дахь заврын дагуу мөнгөн хөрөнгө байршуулах

**Мөнгө байршуулах**

Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдсанаар хөрөнгө оруулагчийн нэр дээр бонд шилжинэ.

**Арилжаа**

**Хүснэгт 36 .** Үнэт цаас худалдан авах захиалгын мөнгө байршуулах заавар

| | |
|---|---|
| **Дансны нэр** | ҮЦК-ийн нэр |
| **Дансны дугаар** | ********* /Брокероос авна./ |
| **Банкны нэр** | "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК |
| **Гүйлгээний утга** | Нэр, Регистр, Invescore Bond /Инвескор Бонд/ |

InvesCore

**"Инвескор КАПИТАЛ ҮЦК" ХХК үнэт цаасны данстай бол:**

Хэрэв та "Инвескор Капитал ҮЦК" ХХК-д үнэт цаасны данстай бол доор заавраар гүйлгээ хийнэ үү.

| | |
|---|---|
| **Дансны нэр** | Инвескор Капитал ҮЦК ХХК |
| **Дансны дугаар** | 495086732 |
| **Банкны нэр** | Худалдаа Хөгжлийн Банк |
| **Гүйлгээний утга** | Нэр, Регистр, Invescore Bond /Инвескор Бонд/ |



"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
6060854 1119280
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он 2022 сар 11. 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

## 18.11. Арилжааны шимтгэл

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн ҮЦК-д төлөх ба уг шимтгэлд эрх бүхий байгууллагууд болон арилжаа эрхлэх байгууллын шимтгэл багтсан байна. МХБ-д бүртгэлтэй ҮЦК-иудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

## 18.12. Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө. 17.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 21.2.4-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.1.4-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс 20.2.5-т заасны дагуу 5 хувь, 18.3-т заасан (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого) худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 20.1-т заасан хувь хэмжээгээр татвар төлнө.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

## 18.13. Валютын ханш

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

## 18.14. Бүхэлчлэх

Зарим мөнгөн дүн болон хувийг тоймлон оруулсан тул зарим хүснэгтэд бүхэл утгаар илэрхийлсэн тоон дүнгүүд нь арифметик бүхэлчлэх аргыг ашигласан дүн болно.

## 18.15. Хэл

Энэхүү танилцуулгыг Монгол хэлээр үйлдсэн бөгөөд гадаад хэл рүү орчуулсан орчуулга нь Монгол хувилбараас утга, агуулга, ямар нэгэн байдлаар зөрсөн тохиолдолд энэ Монгол эх хувилбарыг давуу хүчинтэйд тооцно. Танилцуулгад олон улсад тогтсон жишиг, практикийн дагуу зарим Англи нэр томьёолол ашиглана.



"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
6060854 ... 1119...
УЛААНБААТАР ХОТ

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

ИНВЕСКОР

БОНД 2.

# 19. Үнэт цаас гаргахад оролцсон байгууллагууд


19.1. Үндсэн андеррайтерийн тухай

19.2 Туслах андеррайтерийн тухай

19.3 Хуулийн зөвлөхийн тухай

19.4 Аудитын компанийн тухай

19.5 Оролцогч байгууллагуудын ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх мэдэгдэл



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
FINANCIAL INSTITUTION
Үнэт цаас гаргагч
6060854 ☏ 11192808
УЛААНБААТАР ХОТ

Андеррайтер

СЗХ
2022 .11. 8 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 21
БҮРТГЭВ

## 19. Үнэт цаас гаргахад оролцсон байгууллагууд

### ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

#### "ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК" ХХК

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа, 1 давхар |
| Утас: | (976) 7272-7282 |
| И-мэйл: | cr@tavanbogdcapital.com |
| Веб хуудас: | www.tavanbogdcapital.com |

### ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

#### "ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж 18/1, Даун Таун барилга, 6 давхар 601 тоот |
| Утас: | (976) 7709 0077 - 2 |
| И-мэйл: | info@icapital.mn |
| Веб хуудас: | www.icapital.mn |

### ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

#### "ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас: | (976) 11 330048 |
| И-мэйл: | info@mdsa.mn |
| Веб хуудас: | www.mdskhanlex.com |

### АУДИТЫН КОМПАНИ

#### "ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК

| | |
|---|---|
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Далай Тауэр, 9 давхар |
| Утас: | (976) 7011 0799 |
| И-мэйл: | info@mn.gt.com |
| Веб хуудас: | www.grantthornton.mn |

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854
УЛААНБААТАР ХОТ

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2022 он 11 сар 09 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2
БҮРТГЭВ-02

## 19.1. Үндсэн андеррайтерийн тухай

"Таван Богд Капитал" ҮЦК ХХК нь 2011 онд "Зэт Жи Би ҮЦК" ХХК нэртэйгээр брокерийн үйл ажиллагаа явуулах зорилготойгоор үүсгэн байгуулагдсан бөгөөд 2021 оны 04 сард бүтцийн өөрчлөлт хийж, "Таван Богд Трейд" ХХК-ийн 85%-ийн хөрөнгө оруулалттайгаар өөрчлөн байгуулагдсан. Ийнхүү 2021 оны 04 сараас үйл ажиллагаандаа томоохон өөрчлөлтийг хийж Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлтээр тусгай зөвшөөрлүүдийг авч харилцагч, хөрөнгө оруулагчдад үнэт цаасны зах зээлийн үйлчилгээг өргөн хүрээнд үзүүлж эхлээд байна. Компани нь олон жилийн туршлагатай, санхүү хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдээр баг хамт олноо бүрдүүлэн богино хугацаанд бодитой үр дүн гарган ажиллаж байна.

**Хүснэгт 37.** Үндсэн андеррайтерийн товч танилцуулга

| | | |
|---|---|---|
| ТАВАН БОГД КАПИТАЛ<br>БОЛОМЖОО БОДИТ БОЛГО | **Компанийн нэр** | "Таван Богд Капитал ҮЦК" ХХК |
| | **Улсын бүртгэлийн дугаар** | 9011286006 |
| | **Регистрийн дугаар** | 5469112 |
| | **Хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа, 1 давхар |
| | **Утас** | (976) 7272-7282 |
| | **И-мэйл** | cr@tavanbogdcapital.com |
| | **Веб хуудас** | www.tavanbogdcapital.com |

"Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлууд, ололт, амжилтуудаас дурдвал:

- ✓ Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд 2021 оны 12 дугаар сард 10 тэрбум төгрөгийн Говь бонд, 2022 оны 04 дүгээр сард 500 сая төгрөгийн Эко кар бонд, 2021 оны 12 сараас 2022 оны 05 дугаар сар хүртэл хугацаанд гурван удаагийн гаргалтаар нийт 15 тэрбум төгрөгийн Таван Богд Финанс бондыг тус тус амжилттай гаргахад андеррайтерийн үйлчилгээг үзүүлээд байна.
- ✓ Гадаад, дотоодын үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслийн зуучлалын, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг 40 гаруй мянган харилцагчдадаа үзүүлэхийн зэрэгцээ өөрийн сошиал хуудас, веб сайтаар дамжуулан дэлхийн болон дотоодын зах зээлийн нөхцөл байдлыг мэдээллэн ажиллаж өдөрт давхардсан тоогоор 10,000 гаруй харилцагч, үйлчлүүлэгчид тогтмол мэдээ, мэдээллийг (Crypto focus, Global stock focus, Domestic stock focus, Full focus г.м) хүргүүлэн ажиллаж байна.
- ✓ Системийн нөлөө бүхий топ 5 арилжааны банкуудын IPO теслүүдэд зориулан хөрөнгө оруулалтын зөвлөхийн "Банк реформер" цогц үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.
- ✓ Ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор анхлан хеджингийн үйлчилгээг нэвтрүүлэв.
- ✓ Олон улсын чиг хандлагын дагуу NFT зах зээлд бүтээгдэхүүнээ гаргаж анхдагч зах зээлд 1 секунд хүрэхгүй хугацаанд амжилттай борлуулалт хийсэн. NFT эзэмшигчид нь хугацаагүйгээр "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн бүхий л бүтээгдэхүүн үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр авах эрхтэй болсноороо давуу талтай байна.

**Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай**

Үнэт цаас гаргагч нь "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-тай 2022 оны 06 сарын 27-ны өдрийн 43/28 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан бөгөөд уг гэрээний хүрээнд нээлттэй өрийн хэрэгсэл арилжаалах ажлыг удирдан зохион байгуулах, зөвлөгөө өгөх, бэлтгэл ажлуудыг удирдан гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчдад Үнэт цаас гаргагч, түүний олон нийтэд санал болгож буй Үнэт цаасыг танилцуулах, санал болгох, арилжих, зорилтот санхүүжилтыг татан төвлөрүүлэхээр тохиролцсон.

Үнэт цаас гаргагч нь андеррайтерийг Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж, Үнэт цаас гаргагчийн ба түүний охин компанийн тухайлсан ба нэгтгэгдсэн санхүүгийн тайлан тэнцэл, шаардлагатай бусад материалыг гарган өгч, Туслах андеррайтертай ижил зорилгын хүрээнд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх замаар хамтарч ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хоорондох үүсэх харилцааг зохицуулахад оршино.

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд, өөрийн эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэрт заасан нөхцөлөөр өрийн хэрэгсэл гарган, хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалах замаар санхүүжилт татах үйл ажиллагаанд "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийг Үндсэн андеррайтераар, "Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийг Туслах андеррайтераар сонгосон бөгөөд Үндсэн андеррайтер нь Туслах андеррайтертай 2022 оны 06-р сарын 28-ны өдөр 43/29 тоот "Хамтын Ажиллагааны Гэрээ"-г байгуулсан.

Үндсэн андеррайтер нь СЗХ болон МХБ-д хүргүүлэх Үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэхэд шаардлагатай удирдлагаар хангах, санал зөвлөмжийг өгөх, бэлэн болсон Үнэт цаасны танилцуулгатай танилцах, санал өгөх, Эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авахад хүчин чармайлт гарган ажиллах, нээлттэй өрийн хэрэгслийг худалдан авах боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлж үнэт цаас худалдан авах захиалга авах, холбогдох хууль журамд заасан андеррайтерийн цогц үйлчилгээг үзүүлнэ.

## 19.2. Туслах андеррайтерийн тухай

"Инвескор Капитал" ҮЦК ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм. Тус компани нь СЗХ-оос үнэт цаасны брокерын үйл ажиллагаа, үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа, үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүй, өмгөөллийн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олноор багаа бүрдүүлсэн. Биржийн болон Биржийн бус зах зээлд үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохион байгуулах, үнэт цаасны арилжаанд зах зээл үүсгэгчээр оролцох, M&A болон хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн туршлагатай.

**Хүснэгт 38.** Туслах андеррайтерийн товч танилцуулга

| | | |
|---|---|---|
| InvesCore КАПИТАЛ ҮЦК ХХК | **Компанийн нэр** | "Инвескор Капитал ҮЦК" ХХК |
| | **Улсын бүртгэлийн дугаар** | 9011741137 |
| | **Регистрийн дугаар** | 6317839 |
| | **Хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж 18/1, Даун Таун барилга, 6 давхар 601 тоот |
| | **Утас** | (976) 7709 0077 - 2 |
| | **И-мэйл** | info@icapital.mn |
| | **Веб хуудас** | www.icapital.mn |

"Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

- 2019 онд "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгож, гаргах ажиллагаанд туслах андеррайтераар оролцож нийт 18.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.
- 2021 онд Монголын анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас "Инвескор Актив ХБҮЦ"-ыг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан гаргах ажиллагаанд андеррайтераар ажиллаж нийт 4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Уг үнэт цаас гаргах ажиллагаанд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу хөрөнгө худалдагчаар "Инвескор ББСБ" ХК, "Микро Кредит ББСБ" ХХК оролцсон.
- 2021 онд хувийн хэвшлийн анхны өрийн хэрэгслийн хөтөлбөр болох "Инвескор ББСБ" ХК-ийн нийт 20 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Инвескор Бонд өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргасан бөгөөд 100% борлуулж дуусгасан.
- Биржийн Бус Зах Зээлд 2021 онд "Кэй Эй Майнинг" ХХК-ийн нийт 10.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий "Хишиг Бонд 2022 15%" өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргаж, Транч 1 болох 3.2 тэрбум төгрөгийг амжилтай татан төвлөрүүлсэн.
- Биржийн Бус Зах Зээлд 2022 онд "Актив Гарден" ХХК-ийн 10 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийн хөтөлбөрийг бүртгүүлж үүнээс эхний транчийг амжилттай гаргаад байна.
- Биржийн Бус Зах Зээлд 2022 онд "Шунхлай" ХХК-ийн 50 тэрбум төгрөгийн идэвхтэй үлдэгдэл бүхий өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргаж, нийт 23.9 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

**Туслах андеррайтерийн хамтран ажиллах гэрээний тухай**

Туслах андеррайтер болох "Инвескор Капитал ҮЦК" ХХК болон Үндсэн андеррайтер "Таван Богд Капитал ҮЦК" ХХК нь 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр 43/29 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан. Тус гэрээ нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ээс баталсан холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн гаргаж буй нээлттэй өрийн хэрэгслийг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгох, худалдах үйл ажиллагааг амжилттай болгох зорилгоор Үндсэн болон Туслах андеррайтеруудын хамтран ажиллах хүрээнд үүсэх харилцааг зохицуулна.

Уг гэрээний хүрээнд Үндсэн болон Туслах андеррайтерууд нь Үнэт цаасны танилцуулгыг хамтран боловсруулах, Эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авахад хүчин чармайлт гаргах, боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлон гэрээ хэлцэл хийхэд зуучлан хамтран ажиллах, маркетинг төлөвлөгөө боловсруулахад Үнэт цаас гаргагчид зөвлөмж өгөн өөрийн боломжит сувгаар мэдээлэл түгээж шаардлагатай танилцуулга боловсруулах, анхдагч арилжааг зохион байгуулж, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх үүрэгтэй.

## 19.3. Хуулийн зөвлөхийн тухай

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн үнэт цаасыг олон улсын түвшинд санал болгох, Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах, Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах, "ЛэндМН ББСБ" ХК, "Инвескор ББСБ" ХК болон "Түмэн шувуут" ХК-ийн IPO, "Хөвсгөл Алтандуулга" ХК, "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах, "ЛэндМн ББСБ" ХК-ийн бонд, Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл дээр хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

### Хуулийн зөвлөхтэй байгуулсан гэрээний тухай

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаан Лекс" ХХН нь Үнэт цаас гаргагчтай 2022 оны 06 сарын 17-ны өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулжээ. Гэрээний дагуу хуулийн зөвлөх нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох журам, Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Үйлчлүүлэгчээс бонд гаргахад хууль зүйн дүгнэлт гаргахаар тохиролцсон байна.

Гэрээний дагуу хуулийн зөвлөх нь өөрийн үүрэгт ажлаа тохиролцсон хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх, үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үнэт цаас гаргагчийн нууцыг чандлан хадгалах үүргийг тус тус хүлээсэн байна. Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөхөд гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлчилгээний хөлсийг хугацаанд нь бүрэн төлөх, үнэн зөв бодит мэдээлэл, шаардлагатай баримт, материалыг гаргаж өгөх, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах үүргийг хүлээжээ.

## 19.4. Аудитын компанийн тухай

"Грант Торнтон Аудит" ХХК нь аудит, татвар, зөвлөх үйлчилгээний цар хүрээгээрээ дэлхийн эхний 6 компанийн нэгд ордог бөгөөд, дэлхийн 140 оронд ажиллаж буй 62,000 мэргэжилтнээс бүрдсэн хараат бус баталгаажуулалт, татвар ба зөвлөх үйлчилгээний фирмүүдийн сүлжээ юм.

Монгол улсын аудит, татвар, зөвлөх үйлчилгээний салбарт 20 шахам жил үйл ажиллагаа явуулж байсан "Улаанбаатар Аудит Корпораци"

ХХК нь 2017 онд Грант Торнтон Интернэйшнл Лтд дэлхийн сүлжээ байгууллагын жинхэнэ гишүүн болж, тус сүлжээг Монгол Улсад төлөөлж ажиллах бүрэн эрхтэй гишүүн фирмээр хүлээн зөвшөөрөгдөн, 2019 оноос "Грант Торнтон Аудит" ХХК гэсэн нэршлээр ажиллаж байна.
"Грант Торнтон Аудит" ХХК нь 2013 оноос эхлэн СЗХ-оос "Үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрөл авч, энэхүү салбарын техник, арга зүйн төдийгүй салбарын зохицуулалтын талаарх мэдлэг, туршлагыг хуримтлуулан ажиллаж байна.

"Грант Торнтон Аудит" ХХК-ийн салбарын хүрээнд гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

Даатгал, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч хувьцаат компаниудын IPO аудитор:

- "Мандал Даатгал" ХК (2014 - 2019)
- "Монос Хүнс" ХК (2015 - 2018)
- "Түмэн Шувуут" ХК (2014 - 2019)
- "Бодь Даатгал" ХК (2019 - 2020)

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч ТЗК-ийн зээлийн багцад тодорхой шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зээлийн шинжилгээ хийж, аудитын дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээ:

- "Омни Капитал ББСБ" ХХК-ийн гаргасан "Омни Актив ТЗК" ХХК-ийн ХБҮЦ.

Банк бус санхүүгийн байгууллагуудын аудитор:

- "Инвескор ББСБ" ХК
- "Ард Кредит ББСБ" ХК
- "Нет Капитал ББСБ" ХХК
- "Жэй Траст Интернэшнл ББСБ" ХХК
- "БСБ Финанс ББСБ" ХХК
- "Омни Капитал ББСБ" ХХК
- "Очир Ундраа ХЗХ ББСБ" ХХК
- "Ди Би Эм Лизинг" ХХК
- "Вишнфанд ББСБ" ХХК
- "Бичил зээлийн хөгжлийн сан (MDF)
- "Транскапитал ББСБ" ХХК
- "Монголын Санхүүгийн Групп ББСБ" ХХК

Хөрөнгийн зах зээлийн оролцогчид болох "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК (2019), "Арилжааны Төлбөр Тооцоо ҮЦК" ХХК (2008, 2017), "Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК (2021)-ийн санхүүгийн тайлангийн аудитороор ажиллаж, 2018 онд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна. "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК-ийн Кредит Банкны хувьцааг худалдан авсны дараах бизнесийн үнэлгээг 2021 - 2022 онд хийж гүйцэтгэсэн туршлагатай.

## Аудитын компанитай байгуулсан гэрээ

"Грант Торнтон Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2021 оны 11-р сарын 22-ны өдөр "Аудитын үйлчилгээ үзүүлэх" нэртэй гэрээг байгуулсан бөгөөд "Инвескор ББСБ" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг багтаасан санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлангуудтай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд нь СТОУС-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийлгэхээр тохиролцсон байна.

Мөн уг талууд нь 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр "Үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулан Үнэт цаас гаргагчийн гаргаж буй Үнэт цаасны танилцуулгад аудит хийж, тодорхойлох захидал гаргахаар тохиролцсон. Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад холбогдох журамд заасны дагуу Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг хянах үйлчилгээг үзүүлэхээр тохиролцжээ.

Гэрээний дагуу "Грант Торнтон Аудит" ХХК нь үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, хичээл зүтгэл, үр дүнтэйгээр хугацаанд нь гүйцэтгэх, үйлчлүүлэгчийн гарган өгсөн санхүүгийн баримт мэдээллийг зөвхөн гэрээт ажлын зорилгоор ашиглах, чанд нууцлах үүрэг хүлээсэн байх ба үйлчлүүлэгч буюу Үнэт цаас гаргагч нь Зээлийн шинжилгээ гаргагчид шаардлагатай санхүүгийн болон бусад баримт бичгүүдийг тохирсон цаг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн гаргаж өгөх, үйлчилгээний цар хүрээг хязгаарласан дарамт шахалт үзүүлэхгүй байх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангах, төлбөрийг хугацаанд нь төлөх үүрэг хүлээсэн байна.

## 19.5. Оролцогч байгууллагуудын ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх мэдэгдэл

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч байгууллагууд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Үнэт цаас гаргагчтай холбоотой үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай мэдэгдэл гаргаж, тус тусын тодорхойлох захидал, дүгнэлт тайлангуудад тусгасан болно.

Бондын нөхцөлд өөрчлөлт оруулах тухай ТУЗ-ын тогтоол

InvesCore
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09-р сарын 19-ний өдөр № 28 Улаанбаатар хот

*Нэлттэй бондын нөхцөлд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсгүүд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 16 дугаар зүйл, "Инвескор ББСБ" ХК (цаашид "**Компани**" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсгүүд, 9.6.22 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.5-2.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 21 тоот тогтоолоор батлагдсан нийтэд санал болгон гаргах нээлттэй бондын нөхцөлд дараах өөрчлөлтийг оруулсугай;

| | |
|---|---|
| Бондын барьцаа / баталгаа | Бондын эргэн төлөлтийн баталгааг "Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй 71.5 тэрбум төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаагаар хангах |

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотой гэрээ хэлцлийг байгуулах, Бондын транч тухай бүрд барьцааг баталгаажуулан бүртгүүлэх, барьцаа хөрөнгийн үнэлгээ буурсан тохиолдолд энэхүү тогтоолд тусгасан харьцааны дагуу нэмж хөрөнгө барьцаалах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Д.Баясгалан)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (А.Энэрэл)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б. АНХБОЛД

SIBJ Capital

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

2022 оны 09-р сарын 19-ний өдөр № 9 Улаанбаатар хот

*Охин Компанийн хувьцаа барьцаалах тухай*

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн хувьцаа эзэмшигч нь Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.21 заалтыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Охин компани болох "Инвескор ББСБ" ХК нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийт 50,000,000,000.00 (тавин) тэрбум төгрөгийн үнийн дүнтэй нээлттэй бонд гаргахтай холбоотойгоор уг үнэт цаасны эргэн төлөлтийн баталгаа болгож Компанийн эзэмшиж буй 71.5 тэрбум төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцааг үндсэн андеррайтер "Таванбогд Капитал ҮЦК" ХХК -д үнэт цаасны үндсэн болон хүүгийн эргэн төлөлт төлөгдөж дуусах хүртэл хугацаатайгаар барьцаалахыг зөвшөөрсүгэй;
2. Энэхүү шийдвэрийн нэгт заасан барьцааг хэрэгжүүлэх зорилгоор "Таванбогд Капитал ҮЦК" ХХК, болон "Инвескор ББСБ" ХК-тай гурван талт "Хувьцаа барьцаалах тухай" гэрээг байгуулах, уг барьцааны гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б. Анхболд/-д олгосугай;
3. Энэхүү шийдвэрийн хоёрт заасан "Хувьцаа барьцаалах тухай" гэрээний нөхцөлийн дагуу барьцаалагдаж буй энгийн хувьцааг үнэт цаасны үндсэн болон хүүгийн эргэн төлөлт төлөгдөж дуусах хүртэл хугацаатайгаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд тусгаарлуулахыг зөвшөөрсүгэй;
4. Энэхүү шийдвэрийн хүрээнд барьцаалагдаж буй хувьцааны үнэлгээг гаргах ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б. Анхболд/-д олгосугай;
5. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шийдвэрийн хүрээнд байгуулагдаж буй гэрээний үүргийг биелүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б. Анхболд/-д даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:**

Кавазоэ Такааки 川添 隆明

Б. Анхболд

Б. Мөнх-Очир Б. Мөнх-Очир

"ИНВЕСКОР ББСБ" ХК

СЭХ
оны сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-2
БҮРТГЭВ-02

SIBJ Capital

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР

2022 оны 10-р сарын 20-ны өдөр № 12 Улаанбаатар хот

*Батлан даалт гаргах тухай*

"Эс Ай Би Жэй Капитал" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн хувьцаа эзэмшигч нь Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.21 заалтыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Охин компани болох "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан гаргах нийт 50,000,000,000.00 (тавин тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүнтэй нээлттэй бондын үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлтөд батлан даалт гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү шийдвэрийн нэгт заасан батлан даалтыг хэрэгжүүлэх зорилгоор бондын үндсэн андеррайтер "Таванбогд Капитал ҮЦК" ХХК болон үүрэг гүйцэтгэгч "Инвескор ББСБ" ХК-тай гурван талт "Батлан даалтын гэрээ" байгуулах, уг батлан даалтын гэрээнд Компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д олгосугай.
3. Компани батлан даалтын гэрээг байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай аливаа баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах, байгуулагдсан "Батлан даалтын гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д олгосугай.
4. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шийдвэрийн хүрээнд байгуулагдаж буй гэрээний үүргийг биелүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:**

Кавазоэ Такааки 川添 隆明

Б. Анхболд

Б. Мөнх-Очир

Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн тухай мэдээлэл

Монгол Улсын хуулийн этгээд "Эс Ай Би Жэй Капитал" ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9011739005, Регистрийн дугаар: 6057209) нь 2016 оны 3 сарын 21-нд үүсгэн байгуулагдсан бөгөөд "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 60,968,730 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг.

**Үйл ажиллагааны чиглэл:** Бизнесийн зөвлөгөө өгөх, Менежментийн зөвлөгөө өгөх, Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин тауэр-1, 13 давхар

**Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн хувьцаа эзэмшигчид**

| № | Овог нэр | Иргэншил | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Баянмөнхийн Анхболд | Монгол | 2,865,723 | 45% |
| 2 | Батбаярын Мөнх-Очир | Монгол | 1,974,165 | 31% |
| 3 | Кавазоэ Такааки | Япон | 1,528,385 | 24% |

**Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн сүүлийн 2 жилийн санхүүгийн мэдээлэл**

| Эс Ай Би Жэй Капитал ХХК | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|
| ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /АУДИТЛАГДСАН/ | | |
| төгрөгөөр | | |
| **Борлуулалтын орлого** | 146,590,909 | 136,363,636 |
| Борлуулалтын өртөг | | |
| **Нийт ашиг** /алдагдал/ | 146,590,909 | 136,363,636 |
| Хүүгийн орлого | 5,801,515,767 | 1,902,223,501 |
| | - | 1,036,223,501 |
| Бусад орлого | 31,654 | |
| Борлуулалтын маркетингийн зардал | | |
| Ерөнхий удирдлагын зардал | 257,086,928 | 433,778,871 |
| Бусад зардал | 24,856,493 | 799,667 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний | | 63,999 |
| **Татварын өмнөх ашиг** /алдагдал/ | 5,666,163,256 | 2,346,671,317 |
| | 580,151,224 | 293,869,136 |
| **Татварын дараах ашиг** /алдагдал/ | 5,086,012,032 | 2,346,671,317 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| **Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/** | 5,086,012,032 | 2,346,671,317 |

СЗХ
он сар өдөр 2022.11.09
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

| Эс Ай Би Жэй Капитал ХХК | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|
| **БАЛАНС** /Аудитлагдсан тайлан/ | | |
| төгрөгөөр | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | **2,499,541,612** | **24,665,775** |
| Дансны авлага | **1,274,355,947** | **2,446,472,117** |
| Татвар, НДШ-ийн авлага | **5,157,921** | **184,160** |
| Бусад авлага | **8,587,524** | **56,663,922** |
| Бараа материал | **400,000,000** | **218,179** |
| Урьдчилж төлсөн зардал/ тооцоо | | **429,850,001** |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | **4,187,643,004** | **2,958,024,154** |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 3,258,351 | 3,107,866 |
| Биет бус хөрөнгө | 23,863,860 | 134,510,156 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 18,709,586,400 | 17,894,072,660 |
| Бусад хөрөнгө /Дуусаагүй барилга/ | | 4,168,849,071 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **18,736,708,611** | **22,200,539,753** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **22,924,351,615** | **25,158,563,907** |
| **ӨР ТӨЛБӨР** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 10,870,403,962 | 837,962,562 |
| Татварын өр | 594,841,061 | 331,383,922 |
| НДШ-ийн өглөг | - | **16,512,490** |
| Бусад богино хугацаат өр | - | **11,158,983** |
| Урьдчилж олсон орлого | - | - |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **11,465,245,023** | **1,197,062,998** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **11,465,245,023** | **1,197,062,998** |
| **ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | - | - |
| Хувийн өмч | - | - |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | 5,090,833,592 | 7,436,904,909 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **22,924,351,615** | **25,158,563,907** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР** | | |
| **ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **22,924,351,615** | **25,158,563,907** |

"ИНВЕСКОР ББСБ" ХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК

СЗХ
2022 .11 .09 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-21
БҮРТГЭВ-02

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ
## "Инвескор ББСБ" ХК

Улаанбаатар хот
2022 оны 06 сарын 30-ны өдөр

**ТУЗ-ийн дарга** **Б.Анхболд**
Гарын үсэг:

Улаанбаатар хот
2022 оны 06 сарын 30-ны өдөр

**Гүйцэтгэх захирал** **Д.Баясгалан**
Гарын үсэг:

Улаанбаатар хот
2022 оны 06 сарын 30-ны өдөр

**Санхүү хариуцсан дэд захирал** **Р.Пүрэв**
Гарын үсэг:

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР
## "Таван Богд Капитал ҮЦК" ХХК

Улаанбаатар хот
2022 оны 06 сарын 30-ны өдөр

**Гүйцэтгэх захирал** **Г.Мөнх-Эрдэнэ**
Гарын үсэг:

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР
## "Инвескор Капитал ҮЦК" ХХК

Улаанбаатар хот
2022 оны 06 сарын 30ны өдөр

**Гүйцэтгэх захирал** **Г. Уянгахишиг**
Гарын үсэг: